



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

*Энэхүц модулийг БШУЯ, ЖАЙКА
хамтран хэрэгжүүлж буй "Багшлах арга зүйн
хөгжлийг түгээн дэлгэрцүлэх тогтолцоог
бэхжүүлэх нь" төслийн хүрээнд боловсруулав.*

БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ

ХИЧЭЭЛИЙН СУДАЛАГААНЫ АРГА ЗҮЙН ҮНДЭС

ЕБС-ийн багш нарт зориулав.

Улаанбаатар хот

2013 он

DDC

371.102

V-823

БОЛОВСРУУЛСАН БАГ:

Ахлагч:

Төмөрбаатарын Ганбаатар

МУБИС-ийн Математик Статистикийн сургуулийн багш

Гишүүд:

Банзрагчийн Бурмаа

МУИС-ийн Физик Электроникийн сургуулийн профессор

Мөнхөөгийн Ганбат

МУИС-ийн Физик Электроникийн сургуулийн багш, дэд профессор

Чойжилсүрэнгийн Нямгэрэл

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн сургуулийн багш

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн сургуулийн багш

Эрдэнэчулууны Мөнгөнтулга

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

Цэрэндоржийн Наранцэцэг

МУБИС-ийн Багшийн сургуулийн багш

ЭКСПЕРТИЙН БАГ:

Ахлагч:

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн Сургуулийн профессор

Бадамжавын Золзаяа

МУБИС-ийн Компьютер, Мэдээллийн Технологийн Сургуулийн ахлах багш

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерийн Сургуулийн багш

Цэвэгжавын Пагмасүрэн

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

РЕДАКЦИЙН БАГ:

Алимаагийн Туяа

БШУЯ-ны Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсийн дарга

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн Сургуулийн профессор

Эрдэнийн Пүрэвжав

Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

ЗӨВЛӨХ БАГ:

Иший Тэцүя

Төслийн менежер

Сүзүки Саяака

Сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Такахата Хироши

Токио Гакугэй их сургуулийн профессор

Камата Масахиро

Токио Гакугэй их сургуулийн профессор

Фүкүчи Акитэрү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Мацүра Шюү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Бадамсамбуугийн Хишигбаяр

Төслийн мэргэжилтэн

ISBN 978-99962-54-76-5



“Содпресс” ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
----------	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйн үндэс

1.1 Монгол Улсын Бага Дунд Боловсролын шинэчлэл, арга зүйн хөгжлийн үндсэн зарчмууд, түүний хэрэгжилт, хуримтлуулж буй туршлага	5
1.2 Суралцагчийн танин мэдэх онцлог	15

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

Хичээлийн судалгаа хийх арга зүй

2.1 Хичээлийн судалгааны түүх	24
2.2 Хичээлийн судалгаа	32
2.2.1 Хичээлийн бэлтгэл судалгаа хийх	35
2.2.2 Хичээлийн заах ба ажиглах	43
2.2.3 Хичээлийн хэлэлцүүлэг, хэлэлцүүлэг зохион байгуулах	60

АШИГЛАСАН МАТЕРИАЛ	72
--------------------	----

УДИРТГАЛ

Энэхүү сургалтын модулийг Монгол Улсын Засгийн газар, Японы Олон Улсын Байгууллага (ЖАЙКА)-ын хамтран хэрэгжүүлж буй “Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулсан болно. Энэхүү төсөл нь 2006-2009 онд БСШУЯ болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ийн хамтран хэрэгжүүлсэн **“Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах арга зүйн хөгжил”** (“Teaching methods Improvement Project towards Children’s Development in Mongolia”) төслийн үргэлжлэл болон 2010-2013 онд хэрэгжсэн. Энэ төслийн хүрээнд ерөнхий модулиас гадна 8 судлагдахууны, удирдлага, менежментийн модуль болон багш бэлтгэх сургуулиудад зориулсан модуль хөтөлбөрүүд боловсруулагдан гарч байна.

Энэхүү модуль нь судлагдахууны модулиудад нийтлэг бичигдэх үндсэн агуулгуудыг тусгасан тул хичээлийн судалагааны арга зүйн үндэс хэмээн нэрлэсэн болно. Иймд энэ модульд 8 судлагдахууны модулийн үндэс болох агуулгыг багтаасан бөгөөд тухайн модулиудад үндсэн модулийн агуулгыг өөр өөрийн судлагдахууны онцлогийг тусган, жишээгээр баяжуулан оруулсан болно.

Мөн модулиудын эцэст дурдсан 5 өдрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн эхний өдрийн сургалтын агуулга дахь мэдээлэл, лекцийн материал нь энэхүү модульд дэлгэрэнгүй байдлаар туссан болно.

Энэхүү сургалтын модуль, хөтөлбөрийг та бүхэн сургалтад ашиглахдаа тухайн сургалтад оролцогчдын өмнөх мэдлэг, мэдээллийн түвшин, онцлогт тохируулан, мөн тухайн цаг үеийнхээ мэдээ, мэдээллээр баяжуулан хэрэглэх боломжтой юм.

Багш таны багшлахуйн хөгжилд оруулах хувь нэмэр арвин байх болтугай.


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ҮНДЭС


1.1. Монгол улсын Бага Дунд Боловсролын шинэчлэл, арга зүйн хөгжлийн үндсэн зарчмууд, түүний хэрэгжилт, хуримтлуулж буй туршлага

Бага, дунд боловсролын шинэчлэлийн явц:

Монгол улсад бага, дунд боловсролын шинэчлэл эрчимтэй явагдаж байна. Энэ хэсэгт бид боловсролын шинэчлэлийн хүрээнд юу хийв, одоо хаана явж байгааг тодруулах зорилгоор өмнөх олон сургалтын хүрээнд хийгдэж байсан мэдээллүүдийг эмхэтгэн хүргэж байна. Юуны өмнө Та бүхэнд хэдийнээ танил болсон хоёр тулгуур дохио буюу 2000, 2001 онд явагдсан Чанартай боловсрол-Багшийн хөгжил сургалтын модуль, Боловсролын стандарт, киррикулимыг шинэчлэх үзэл баримтлал, Технологийн шинэчлэл зэрэг сургалтын модульд хэвлэгдэж байсан зарим слайдыг үзүүлж байна.



Дэлхийн боловсролын хөгжлийн чиг хандлага



Эндээс Та бүхэн бага дунд боловсролын шинэчлэлийн үзэл баримтлал, үйл явцын талаарх мэдлэгээ сэргээн санах бизээ.

Тухайлбал, Монгол улсад нийгмийн түүхэн нөхцлийн цоо шинэ шаардлага тулгарч үүнтэй уялдан боловсролын тогтолцооны шинэчлэл хийгдсэн. Мөн боловсрол судлалын онолын парадигмын өөрчлөлтүүд хийгдсэн. Боловсролын тогтолцооны шинэчлэл нь Бага, дунд боловсролын стандарт (БДБС)-ыг шинэчлэн боловсруулах ажлаар эхэлсэн байдаг.

Монгол орны тогтвортой хөгжлийг XXI зуунд авч явах ирээдүйн иргэдэд **чанартай боловсрол** олгох бодлогын хүрээнд 2004 онд манай бага, дунд боловсролын салбарт анх удаа боловсролын шинэ стандарт боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

- Суралцагчид ямар агуулга, сэдэв үзэхийг гарчгийн жагсаалт байдлаар илэрхийлдэг сургалтын “оролт” (input)-д төвлөрдөг стандартаас, суралцагчид юу мэддэг, чаддаг болсон байх вэ гэдгийг илэрхийлсэн сургалтын амжилтын хүлээгдэж буй үр дүнд “гаралт” (output)-д төвлөрсөн стандарт болгон өөрчилсөн.

Боловсрол, сургалтын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээтэй холбоотой олон шинэ шийдлүүд хийсэн. Үүний дотор суралцахуй ба багшлахуйн арга зүйг, боловсролын бодлогын шинэ үзэл баримтлал, боловсролын онолын шинэ парадигмын үүднээс өөр өнцгөөс харж, ойлгон шинэчлэх шаардлага тулгарсан.

Бид боловсролын стандарт, сургалтын үндэсний ба сургуулийн онцлогтой хөтөлбөр, хичээл ба сургалтын арга зүйн хөгжлийн асуудалд салангид биш, цогц байдлаар хандахыг эрмэлзэж байгаа учир БДБС-д хийгдсэн шийдлүүд, түүнийг илэрхийлж буй ухагдахуунуудын талаар зарим тайлбарыг сургуулийн удирдлага, багш нарын үндсэн үүрэгтэй нь холбон хийж байна.

- Та бүхэн стандартад тусгагдсан шийдлүүдийг “БДБС-ын ерөнхий зөвлөмж”, математик, эх хэл, физик гэх мэт тодорхой боловсролын стандартын зөвлөмжүүдээс ахин харж болно. (2000-2004 онд хэвлэгдсэн материалууд тухайн үед бүх сургуульд тараагдсан).

БСШУ-ны сайдын 2007 оны 351 дүгээр тушаалаар батлагдсан ЕБС-д ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтод :

- Захирал: Сургууль дээр БДБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулна, ...
- Менежер: БДБС ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг манлайлна, ...
- Багш: Цогц чадамжид суурилсан стандартыг хэрэгжүүлнэ, ... гэх мэтээр заасан байна.

Монгол улсын боловсролын тогтолцооны хувьд ерөнхий боловсролыг 10 жил,

11 жилд эзэмшүүлэх, өдгөө 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажил хийгдэж байна. Боловсролын тогтолцоог 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажил нь 12 жилийн сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулах ажлаар эрчимжиж үндэсний хөтөлбөрүүдийг хичээл бүрээр боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнтэй уялдан сурах бичгийн шинэчлэл ч хийгдэж байна.

2005 оноос эхлэн хэрэгжсэн боловсролын стандартыг 5 жил тутамд үнэлэн хөгжүүлэх хуулийн дагуу 2009 онд боловсролын стандартад үнэлгээ хийгдсэн ба өнөөдрийн байдлаар боловсролын стандартыг шинэчлэн сайжруулах үндэсний багууд томилогдон ажиллаж байна. Ингэж шинэчлэн сайжруулахдаа ерөнхий боловсролыг олон улсын жишигт хүргэх, шинэчлэх бодлого баримталж байна.

Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, үйл явц:

Шинэ засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрдэм боловсролтой Монгол хүн” хөтөлбөрийг тусган хэрэгжүүлэхээр заажээ. Энэ хөтөлбөрт боловсролын салбарын гол зорилтыг “Монголын онцлог бүхий, олон улсын стандартад нийцсэн, хөрвөх чадвартай боловсролыг эх орондоо олж авах, эзэмшсэн мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой байх, эх орны хөгжлийн ирээдүй монгол хүнээ сургаж бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт байх болно” гэж заасан байна.

Мөн 2012 онд БШУЯмнаас “Зөв Монгол хүн” боловсролын чанарын шинэчлэлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. “Зөв Монгол хүн” бодлогын зарим зорилтуудыг хэрэгжүүлэхэд хичээлийн судалгааны арга зүй гол түлхэц болох юм. Тухайлбал багшийн хөгжлийн шинэчлэл, хувь хүний хүсэл, зорилгод суурилсан сургалтын шинэчлэлийн дараах зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр хичээлийн судалгааны зорилгоо сонгон судалгаа хийх боломжтой. Үүнд:

Багшийн мэргэжил, арга зүй, ур чадварыг суралцагчдын хөгжлөөр нь үнэлдэг, ... нөхцлийг бүрдүүлнэ.

- Бага боловсролын сургалтыг өөртөө итгэлтэй, эргэцүүлэн бодож өөрийгөө илэрхийлэх чадвартай сурах хүсэл эрмэлзэлтэй, суралцах арга барилтай Монгол хүүхэд болгон төлөвшүүлэх суурь зарчимд тулгуурлан шинэчилнэ.
- Бага ангийн багш өөрийн судалгаа, үнэлгээг дүн тавилгүйгээр хийж бусадтай харьцуулахгүйгээр суралцагчийг дүгнэдэг байна. Сурагчдад айдасгүйгээр суралцах орчныг бүрэн бий болгож, бүтээлч байдал, эрсдэлийг давж чадах чадварыг нь дэмждэг байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын үр дүнгүй хэт ачааллыг бууруулах, сургалтын хөтөлбөрийг сонголттой, уян хатан болгох үндсэн дээр сурагчид өөрийн авъяас, сонирхол, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиглэлдээ нийцүүлэн тухайн хичээлээр өргөжүүлэн гүнзгийрүүлсэн, нэмэлт агуулгатай, ялгаатай сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг болно.
- Ерөнхий боловсролын сургалтын зорилго, агуулга, хөтөлбөр, сургалтын болон үнэлгээний арга зүй, сургалтын зохион байгуулалтыг өөрчлөн шинэчилнэ.
- Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сургалтын агуулгын шинжлэх ухаанч академик хоцрогдлыг арилгаж, сургалтын агуулгыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн өрсөлдөх чадвартай сургалтын жишигт хүргэнэ.
- Дунд, ахлах ангийн үнэлгээг сурагчийн суралцах хүсэл эрмэлзлийг урамшуулан дэмжсэн, тэдний цээжилсэн, сэргээн санах санамжийг нь биш бодит ур чадварыг үнэлж, багшид сурагч бүрийн өсөлт, өөрчлөлтийг үнэлж,

сурагч бүртэй ажиллах, багш өөрийнхөө ажлын гүйцэтгэлийг өөрөө үнэлж, хичээлийн зохион байгуулалт, арга зүйгээ сайжруулахад нь дэмжлэг болдог байхаар өөрчилнө. гэх мэт.

Арга зүйн хөгжлийн үйл явц:

Мэдлэгт тулгуурласан зуун гэж нэрлэгдэж буй орчин цагийн болон ирээдүйн нийгэмд, шинэ мэдлэг, мэдээлэл, техник технологи нь нийгмийн амьдралын бүхий л салбарын хөгжлийн үндэс болно гэж үзэж байна. Нийгмийн хөгжлийн энэхүү онцлог нь **ирээдүйн иргэдээс цаг үедээ тохирсон шинэ мэдлэг чадвар, шинэ сэтгэлгээг** шаардаж байгаа бөгөөд үүнийг **шинэ арга зүйгээр** л эзэмшүүлэх боломжтой. Арга зүйн хөгжлийн **гарааны цэг** нь 2004 онд боловсруулсан Бага, дунд боловсролын шинэ стандарт (БДБС) юм.

БДБС-ын “**Арга зүйн хөгжил**”- хэсэгт суралцагчид “цогц чадамж”-д суурилсан боловсролыг тасралтгүй эзэмшихэд чиглэсэн дидактик шийдлүүдийн үндэс болж байгаа онол, арга зүйн үндсэн зарчмуудыг тусгаж өгсөн. Эдгээр зарчим нь суралцахуй ба багшлахуйг тайлбарлаж буй орчин цагийн онол болох когнитив ба конструктив сэтгэл судлал, дидактикийн гол үзэл санааг ерөнхийд илэрхийлсэн. Арга зүйн үндсэн зарчмуудын гол санааг төслийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаатай, тухайлбал хичээлийн хөгжил ба арга зүйн хөгжилтэй холбон тайлбарлавал :

- **Боломжийг тэнцүү олгох зарчим:** Суралцагчид боловсрол эзэмших явцад тэднийг нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн байдал болон үндэстэн, ястны ялгаатай байдлаар нь ялгаварлахгүй байх гэсэн үндсэн хууль болон боловсролын хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх явдал нь энэ зарчмын гол санаа юм. Мөн энэ зарчмын санаа нь боловсролын шинэчлэлийн бодлогын хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлэх гэсэн утгаар орсон байна.
- **Судлах агуулгыг сонгох зарчим:** Шинжлэх ухааны агуулгыг суралцагчийн танин мэдэх боломж, насны онцлог, хэрэгцээ шаардлагыг тооцон хялбарчлаж, дидактикаар дахин бүтээж хичээлийн агуулга болгох.
 - Агуулга шинжлэх ухаанд биш харин суралцагчдын эзэмших ёстой цогц чадамжуудад баримжаалан сонгогдоно.
- **Суралцахуйн зарчим:** Суралцахуйг тайлбарладаг сэтгэл судлалын онолуудаас орчин цагт эдгээр онол, үзэл баримтлалын парадигм болж буй конструктив сэтгэл судлалын онолын гол санаануудад баримжаална:
 - Суралцагч өөрийн бүтээлч үйл ажиллагаагаар мэдлэг бүтээнэ.
 - Суралцахуй нь өөрийн зохицуулалттай, хариуцлагатай байна.
- **Багшлахуйн зарчим:** Багшийн аливаа шийдлийг нэг талаас боловсролын шинжлэх ухааны зарчмуудад нөгөө талаас өөрийн туршлага, санаачлага, мэдрэмжтэй хослуулан боловсруулна:
 - Суралцагчдын сурах үйлийн, сэтгэл зүйн, материаллаг орчныг дээрх мэдлэг, чадвартайгаар бүрдүүлнэ.
 - Багш бэлэн мэдлэгийг дамжуулах бус, суралцагчдын сурах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвлөнө.
- **Технологийн зарчим:** Сургалтад орчин цагийн мэдээлэл, харилцааны технологийн хэрэгслийг ашиглах, энэхүү технологийн хэрэглэгч болоход дэмжлэг үзүүлэх.
 - Манай сургуулиудын онцлогийг тооцон багш нарын энэ чиглэлийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд мэдээлэл зүйн багш нараасаа суралцахыг чармайх.

- Мэдээлэл зүйн багш нарын бусдадаа үзүүлэх дэмжлэг нь ихээхэн ач холбогдолтой учир, сургуулиуд энэ ажлыг өөрсдийн багш нартай хамтран, хэрхэн хэрэгжүүлэхээ тогтох.

- **Үнэлгээний зарчим:** Үнэлгээ нь суралцагчдыг хөгжүүлэхэд чиглэсэн байх, тэдний хөгжилд гарч буй эерэг өөрчлөлтүүдийг үнэлэх.

Боловсролын стандартын шинэ шийдлүүд, арга зүйн зарчмуудыг ухаарч ойлгон, хэрэгжүүлэх нь сургууль бүрийн идэвхитэй үйл ажиллагаа, багш бүрийн сэтгэлгээ болон үйлийн өөрчлөлтөөс хамаарах учир нэг далайцаар бүтэх хялбар зүйл биш юм. Сургууль багш нар маань өнгөрсөн хугацаанд тодорхой туршлага хуримтуулж байгаа боловч сургалтын арга зүйн хөгжлийн асуудлыг илүү ахисан түвшинд авч үзэн, арга зүйн хөгжилд чанарын дэвшил гаргах шаардлагатай байгааг бид бүгд мэдэж, анзаарч байдаг.

Багшийн үндсэн ажил болох хичээл дээр сурах ба багшлах үйл ажиллагаа нэгэн зэрэг явагддаг. Иймд хичээлийн хөгжил ба арга зүйн хөгжил нь нэг зоосны хоёр тал. Судалгааны түвшинд хичээлийн хөгжлийн тасралтгүй үйл явцыг “хичээлийн соёлын хөгжил” гэсэн нэр томъёогоор илэрхийлж, гол нь нийгмийн хөгжлийн дагуу хичээлийн соёлд өөрчлөлт орж буйг тодруулдаг. Судлаачид хичээлийн соёлын хөгжил гэж юу болох, түүний үзэл санаа хичээл сургалтын түвшинд хэрхэн хэрэгжих талаар багшийн мэргэжил дээшлүүлэх модуль боловсруулж (2005 он) сургалтад хэрэглэхээс гадна, гарын авлага байдлаар хэвлэж, сургуулиудад тараасан. Үүнд:

- БДБС ба хичээлийн соёл ерөнхий модуль
- Математикийн боловсролын стандарт ба хичээлийн соёлын хөгжил(5 модуль)
- БДБС ба байгалийн ухааны хичээлийн соёлын хөгжил (3 модуль)

БДБС, Сургалтын үндэсний хөтөлбөр, хичээл, арга зүйн хөгжлийн талаар хуримтлуулсан туршлага дээрээ тулгуурлан хүүхэд төвтэй хичээл, хичээл төвтэй сургуулийн хөгжлийг хэрэгжүүлэх чиглэлээр ахиц гаргах шаардлага, мөн боломж байгаа юм.

Арга зүйн хөгжлийн талаарх бидний туршлага:

Арга зүйн хөгжлийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх, багш нарын арга зүйг хөгжүүлэх чиглэлээр манай боловсролын салбарт олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байсан ба эдгээр төсөл нь тодорхой үр дүнгээ өгч байсан. Өөрөөр хэлбэл манай ерөнхий боловсролын сургууль, багш нар маань арга зүйн хувьд туршлага ихтэй. Иймд арга зүйн шинэчлэлд хувь нэмрээ оруулахын тулд өмнөх туршлага дээрээ тулгуурлах хэрэгтэй. Тухайлбал:

- 2000 оноос хэрэгжүүлсэн олон төрлийн төсөлд (Данида, Сорос, сургалтын технологийн шинэчлэл, JICA,) оролцсон туршлага
- БДБС -ыг хэрэгжүүлсэн туршлага
- Сургуулийн онцлогтой хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж буй туршлага зэрэгтээ тулгуурлана.

Эдгээр төсөл хөтөлбөрийн нэг нь болж БШУЯ, Японы JICA байгууллага хамтран дараах төслүүд хэрэгжиж байна. Үүнд:

- “Сурагчдын суралцахуйг дэмжих **арга зүйн хөгжил**” (2006-2009)
- “Багшлахуйн **арга зүйн хөгжлийг** түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” (2010 оноос).

Эдгээр төсөл хэрэгжих болсон хэрэгцээ, шаардлага нь Бага, дунд боловсролын стандартад тусгагдсан “арга зүйн хөгжлийн зарчмууд”-ыг хичээл, сургалтын үйл

ажиллагаанд хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж буй сургууль, багш нарын үйл ажиллагааг дэмжихэд оршино.

Төслийн онцлог юу вэ? Бага, дунд боловсролын салбарт боловсролын шинэчлэлийг дэмжсэн олон төсөл хэрэгжиж, төсөл бүр тодорхой асуудалд төвлөрдөг.

Бид дээр дурьдсан арга зүйн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд дараах асуудлууд дээр түлхүү анхаарч байна. Үүнд:

1. Суралцахуй ба багшлахуйн арга зүйн шинэчлэлийг багшийн үндсэн ажил болох хичээлтэй нь уялдуулан хүүхэд бүрт үр ашиг өгөх хичээлийг хэрхэн бэлтгэж, төлөвлөж, явуулж, хэлэлцэн сайжруулах, энд дээд, дунд сургуулийн багш нар, сургуулийн удирдлага хэрхэн хамтран ажиллах, оролцогч бүр өөрийн гүйцэтгэх үүргийг хэрхэн бүтээлч, хариуцлагатай гүйцэтгэхийг мэдэрч, хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч байна. Өөрөөр хэлбэл боловсролын стандарт, сургалтын үндэсний ба сургуулийн онцлогтой хөтөлбөр, хичээл ба сургалтын арга зүйн хөгжилд цогц байдлаар хандахыг эрмэлзэж байна. Бүхэлдээ хүүхэд төвтэй хичээл, хичээл төвтэй сургуулийн хөгжлийг дэмжихэд чиглэж байна.
2. Японы багш нарын хүүхэд бүрт чанартай боловсрол олгодог сургалтын арга зүйтэй танилцаж, судалж, суралцахаар ажиллаж байна. Тухайлбал:
 - Багш хичээлдээ бэлтгэж, төлөвлөхдөө хэрхэн сурагчдын суралцахуйг дэмжих орчныг бүрдүүлэх арга зүйг хэрхэн нарийвчлан тунгаан бодож, төлөвлөж, тодорхой шийдлүүдийг хийдэг болон хичээлд хэрэглэх хэрэглэгдэхүүн, материалыг, сурагчдын сурах үйл ажиллагааг хэдийд, яаж дэмжихэд зохицуулан сонгодог болох.
 - Багш нар тодорхой зорилготойгоор, тодорхой багшийн хичээлд сууж, тухайн хичээлийн талаар ярилцан арга зүйгээ хөгжүүлэх чиглэлээр харилцан бие биенээсээ суралцан, хамтдаа хөгждөг.
 - Эдгээр үйл ажиллагааг илэрхийлдэг Япон үгийг бид Монгол хэлэнд одоогоор “Хичээлийн бэлтгэл-хэрэглэгдэхүүний судалгаа”, “Хичээлийн судалгаа” гэж орчуулав.

Манай багш нар боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх, арга зүйн зарчмуудыг хичээл дээрх суралцахуй ба багшлахуйн үйл ажиллагаанд буулгах талаар хуримтлуулсан туршлагад тулгуурлан, Японы багш нарын арга зүйгээс суралцан, өөрийн гэсэн онцлогтой “хичээлийн судалгаа”-ны үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлэх, ингэснээр бага, дунд боловсролын салбарын шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилготой ажиллаж байна.

Хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгааны талаар өмнөх төслийн зөвлөмжүүдэд дурдсан байгаа тул тэндээс уншиж болно. Мөн энэ төслийн хүрээнд боловсруулан гаргаж буй 8 судлагдахууны модуль бүрт тухайн судлагдахууны онцлогийг тусгасан хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл – хэрэглэгдэхүүний судалгааны талаар бичсэн байгаа.

Харин энэхүү модульд хичээлийн судалгааны талаар зарим туршлага, санаа болон Япон зөвлөхүүдийн санааг тоймлон, анхаарах асуудлуудыг хүргэж байна.

Хичээлийн судалгааны талаар судлаачдын тайлбар

Хичээлийн судалгаа нь нэр томъёоны хувьд авч үзвэл Японы JUGYOKENKYU гэсэн үгийн үгчилсэн орчуулга бөгөөд энэ нь англи хэл дээр “Lesson study”, “Research lesson” гэсэн үгээр бууддаг.

Хичээлийн судалгаа гэж юу вэ? гэдгийг Японы судлаач Макото Ёшида (Makoto Yoshida) тодорхойлохдоо: “Хичээлийн судалгаа гэдэг нь багш нарын багшлах

ур чадвар, арга зүйгээ системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа” гэсэн байна.

Иймээс судлаачид хичээлийн судалгаа нь Японы боловсролын шинэчлэлийг хийсэн, боловсролыг хөгжүүлж буй гол үйл ажиллагаа юм гэж тодорхойлдог байна.

Япон зөвлөхүүдийн өгсөн зөвлөмж

Хироши Такахата (Токио Гакүгэй Их Сургууль): Японы багш нар мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхийн тулд янз бүрийн түвшний сургалтад суралцах үүрэгтэй байдаг. Хичээлийн судалгаа ч мөн ийм төрлийн сургалтын нэг хэлбэр гэж ойлгогддог.

Эхлээд хичээлийн судалгааны зорилгын талаар товч танилцуулахад, идэвх санаачлагатай багш нарын нээсэн шинэ арга барилыг бүгдэд таниулж нээлттэй хичээл явуулснаар олон багш нарын санал дүгнэлтийн үндсэн дээр тэрхүү арга барилыг улам боловсронгуй болгохыг зорихоос гадна нөгөө талаас олон тооны багш тэрхүү шинэ арга барилыг санаа болгож хичээлдээ хэрэглэхийг дэмжих зорилготой юм. Арга барилаа хүнд үзүүлэх болон хүний арга барилыг үзэж таних нь хоёр талдаа хөгжин дэвших боломжийг олгодог сайн талтай байдаг бөгөөд хичээлийн судалгаа гэдэг нь тухайн хүн болон орчин тойрныхон нь бүгд цугтаа хөгжихөд хэрэглэгдэхүүний ач холбогдол болон хүүхдийг илүү ойлгож чаддаг болж, эцсийн дүнд энэ гурвын хоорондын холбоо улам бүр бат бэх болж өгдөг.

Хичээлийн судалгаа нь доорх гурван шатнаас бүрдэг.

1. Нэгж хичээлийн кирриkyлим (хичээлээ урьдчилан төлөвлөх)

2. Хичээл заах, ажиглалт хийх

3. Хичээлийн дараах нэгдсэн хэлэлцүүлэг

1-р шатанд хичээл заах багшийн хийх ажил бөгөөд энэ шатанд хамт олон болон ахмад багш нар цаашилбал их сургуулийн багш нараас зөвлөгөө авч болно.

2-р шатанд нэг талаас багш сурагчдад хичээл зааж, нөгөө талаас оролцогчид хичээлд ажиглалт, анализ хийнэ.

3-р шатанд хичээлийн дараа (хичээл тарсан хойно байсан ч болно) хичээл заасан багш ба хичээлд ажиглалт хийж оролцсон бүх хүн цуглаж, тэрхүү хичээлийн тухай санал бодлоо солилцоно.

Хичээлийн судалгаа нь анхны үед явагддаг байснаасаа одоо бол нэлээд өөрчлөгдсөн байгаа. Энэ нь хичээлийг юу гэж ойлгохоос шалтгаалсан өөрчлөлт байсан юм. Дээр үед бол “мэдлэг дамжуулах хэлбэрийн хичээл” явагддаг байсан бөгөөд ийм хэлбэрийн хичээлийн гол зорилго нь “хүүхдийн толгойд их хэмжээний мэдээллийг хурдан бөгөөд оновчтой аргаар дамжуулж оруулж өгөх” гэдэг байсан. Ийм хичээлийн гол дүр нь “багш” байх бөгөөд багшийн заах ур чадвараас бүх юм шалтгаалдаг байсан. Харин орчин үед “мэдлэг олж авах, бүтээх арга барилыг эзэмших хэлбэрийн хичээл”-ийг зорих болсон бөгөөд энэхүү хичээлийн хувьд “явал хүүхэд тус бүр орчин тойрныхонтойгоо харьцах явцдаа мэдлэг олж авч бүтээх аргад суралцах вэ?” гэдэг л хамгийн гол анхаарах зүйл нь болж байна. Ийм хичээлийн гол дүр нь “хүүхэд” байх бөгөөд хүүхдийн үйл ажиллагаанаас бүх юм шалтгаална. Энэхүү өөрчлөлтийг даган хичээлийн судалгаанд ч гэсэн “багш”-аас илүү “хүүхэд”-ийг голчилж үзэх болсон. Багш бол хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжигч юм.

Хичээлийг ерөнхий талаас нь ажиглаж, түүний бүтцэд дүн шинжилгээ хийх нь хичээлийн судалгаа биш юм. Хичээлийн судалгаа бол тухайн заах хичээлээс шалтгаалж арга барил нь өөрчлөгдөх ба нэг хичээлийн сэдвээр ижилхэн нэгж хичээлийг заахад ч арга нь өөрөөр байна. Жишээлбэл: математикийн сурах

бичгээс яг ижил хуудсыг заах хичээлийн судалгаа байлаа гэхэд зорилго нь өөр байх юм бол ач холбогдол өгөх хэсэг ч өөр болж ирнэ. Өөрөөр хэлбэл нэг сурах бичиг дээр хичээлийн судалгаа хийсэн ч хичээлийн бэлтгэл судалгаа өөр байвал заах арга барил ч, хэлбэр ч өөр байна. Тиймээс хичээлийг ерөнхий загвараар нэг талаас нь хардаг хичээлд дүн шинжилгээ хийдэг нүдээр харвал түүнээс илүү чухал хичээлийн судалгааны элементүүдийг орхигдуулна. Хичээлийн судалгаанд, хичээлийг заах багшийн чухалд үзэж байгаа хүчин зүйл нь юу вэ гэдгийг хичээлийн өмнө хэлж мэдэгдсэн байх нь чухал байдаг.

Эхний хэсэгт өгүүлсэнчлэн хичээлийн судалгаа нь нийт оролцогч хэлэлцэж илүү сайн заах аргыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Тиймээс оролцогчид нь бүгд үр дүнт хүртэгч бас хувь нэмэр оруулагчид юм. Мөн хичээлийн судалгаа хийж байгаа нь энэ гээд урсгалаар нь хараад байж болохгүй. Хэдийгээр багш бүр өөр өөр бодолтой байж болох боловч ажиглагч багшийн байр сууринаас тодорхой, нэгдмэл зорилго тавьж ажиглахгүй бол болохгүй. Тэгснээр ажиглалт үр дүнтэй утгатай болно. Ямар талаас нь ажиглах вэ гэдгийг өмнө ярьсан саналуудаас санаа авбал зохино.

Багшийн арга зүйн хөгжлийг хүүхдийн хөгжлийн адил урт хугацаанд харах нь зүйтэй бөгөөд дээр нь оюуны хөдөлмөр хийж байгаа багш хүн хичээлийн судалгаанаас юуг олж мэдэх вэ, яаж бүтээлчээр ашиглах вэ гэдгээ бодож түүнийгээ бүтээх хэрэгтэй. Үүний тулд биднээс шаардлагатай байгаа зүйл маань үнэлгээ биш цаг хугацаа байгаад оршино.

Фүкүчи Акигэру (Токио Гакүгэй Их Сургууль): Өмнөх төслийн 3 жилд “хичээлийн судалгаа”, “хичээлийн бэлтгэл судалгаа”, “хүүхдийн хөгжил” гэсэн гурван түлхүүр үгийг хэрэглэж байлаа. Эдгээр нь шинэ заах аргыг өөртөө эзэмшихийн тулд дутагдаж болохгүй гол санаанууд юм. Энд багш хичээлээ өөрчилснөөр өөрөө, улмаар хүүхдүүд ч бас өөрчлөгдөж байгааг мэдрэх нь гол зорилго болно. Мөн яагаад заах аргаа өөрчлөх ёстой талаар ойлгох нь чухал. Их үр дүнтэй аргын нэг болох энэ арга нь одоогоор Японы бараг бүх сургуульд ердийн зүйл болжээ. “Хичээлийн судалгаа” нь сургуульд эрдэм шинжилгээний ажил явуулах гэсэн үг бөгөөд энэ нь хичээлийг зүгээр л нэг явуулахаар зогсохгүй хичээлийн ажиглалтад өөрчлөлт оруулахгүй бол бодит болж чадахгүй гэж үздэг. Японы хувьд, ямар ч сургуульд судалгааны баг бүрдсэн байдаг бөгөөд “хичээлийн судалгаа”, “хичээлийн бэлтгэл судалгаа”-г ашиглан хичээлийн чанарыг сайжруулахад үнэн санаанаасаа чармайн ажилладаг.

Өөрийн гэсэн онцлогтой "хичээлийн судалгаа"-ны үзэл баримтлалыг боловсруулж, хэрэгжүүлэх асуудалд:

Хамтарсан төсөл эхэлснээс хойш “хичээлийн бэлтгэл-хэрэглэгдэхүүний судалгаа”, “хичээлийн судалгаа” гэдэг үг хэллэгийг зөвхөн төсөлд хамрагдсан сургуулиудын хүрээнд хэрэглэж байсан. Харин өдгөө олон сургууль, багш нар сонирхон хэрэглэх боллоо. Ийм учраас эхнээс нь зөв ухаарч, зөв юм хийх хэрэгтэй байна.

- Манай хоёр орны нийгэм, соёлын уламжлал, хөгжлийн түвшин өөр учраас тухайн улсын онцлогтой сургалтын технологийг шууд хуулах нь боломжгүй бөгөөд шаардлагагүй асуудал болох нь мэдээж. Харин бидэнд эндээс санаа авч, өөрсдийн нөхцөл байдалд зохицуулан хэрэгжүүлж, хичээлийн үр өгөөжийг улам дээшлүүлэх боломж маш их байгааг ухаарч, ойлгох нь чухал юм.
- Бид өөрийн гэсэн онцлогтой “хичээлийн судалгаа”-ны үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлэх, ингэснээр бага, дунд боловсролын салбарын шинэчлэлд ахисан түвшинд хувь нэмэр оруулах чиглэлээр хамтран ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Хичээлийн бэлтгэл буюу хичээлийн бэлтгэл - хэрэглэгдэхүүний судалгаа гэдэг ойлголтын хүрээнд дараах санаануудыг ойлгож байна. Үүнд:

- Хичээлд бэлтгэх, төлөвлөх, хөтөлбөрөө боловсруулахдаа, сурагчдын сурах үйл ажиллагааны алхам бүрийг хэрхэн дэмжих **шийдлүүдийг** тунгаан бодож боловсруулаад, түүнийгээ хичээлийн явцад хэрхэн хэрэгжүүлэхээ төлөвлөөд, хэрэглэгдэх материалуудыг бэлтгэсэн цогц үйл ажиллагаа явуулж, хичээлийн хөтөлбөрийг бэлтгэдэг. **Багшийн шийдэл бүр судалгаа.**
- Багш өөрийн сурагчиддаа зориулан бэлтгэсэн, өмнөхөөсөө давуу **төгөлдөржсөн** арга зүйг боловсруулж байгаа нь тухайн багшийн оюуны бүтээл, тухайн багшийн **судалгаанд суурилсан хөтөлбөр юм.**
- Энд хөтөлбөрийг бэлэн болгосон **үр дүнгээс илүүтэй энэ хөтөлбөрийг сурагчийн сурах арга зүй, багшийн багшлах арга зүйг хөгжүүлэх алхмуудтай боловсруулсан үйл явц нь чухал.**

Хичээлийн судалгаа гэдэг ойлголтын хүрээнд дараах санаануудыг ойлгож байна. Үүнд:

Хичээлийг явуулах:

- Боловсруулсан хөтөлбөрийн дагуу сурах ба багшлах үйл ажиллагаа явагдана.
- Шинэ маягаар бодож боловсруулсан сурагчийн сурах арга зүй, багшийн багшлах арга зүйг хэрэгжүүлнэ.
- Сурагчид ба багш нь сурах ба багшлах арга зүйдээ гарч байгаа шинэ санаа алхмуудыг өөрсдөө мэдрэх, таашаах боломж олгоно.

Хичээлд ажиглалт хийх:

- Багш өөрийн хичээлийг хэрхэн бэлтгэж явуулсан талаар танилцуулна.
- Хичээлд сууж буй багш нар “би энэ хичээлийг, ингэж заах байсан” гэсэн бэлтгэлтэйгээр оролцоно.
- Шинэ арга зүйг өөрийн арга зүйтэй жиших, шинэ санаа олоход түлхүү анхаарна.

Манайд хэрэгжих боломжтой санаануудыг сонгон өөрийн нөхцөл байдалд хэрэгжүүлэн буулгах

Нэг талаас хичээлийн судалгааны учир утгын талаар Японы болон, энэ арга зүйг судалдаг гадаадын эрдэмтдийн тайлбар зөвлөгөөг сонсож судлаад, нөгөө талаас арга зүйгээ хөгжүүлэх талаар бидний хийх ёстой ажлуудыг бодохоор адил төстэй, санаа авах зүйл олон байна. Жишээ нь:

Алсын зорилгод баримжаалах

“Хичээлийн судалгааг зүгээр л нэг багшийн заах аргыг сайжруулах зүйл гэж ойлголгүй сургуулийн өмнөх зорилт, сургуулийн сурган хүмүүжүүлэх зорилтыг нарийвчлан гүйцэтгэх сэдвийг тогтооход чиглүүлэх” (Фүкүчи багш)

Энэ санааг манай нөхцөлд буулгавал:

- Багш хичээл, сургалтын ажлыг төлөвлөж, явуулахдаа зөвхөн тухайн сэдвээр явцуурах бус, сургууль дээр суралцагчдад боловсрол, хүмүүжил олгох үйл ажиллагааны хүрээнд авч үздэг мэдлэг чадвартай байх ёстой. Ерөнхий боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд миний хичээл ямар хувь нэмэр оруулах вэ? Энэ сэдэв ямар хувь нэмэр оруулах вэ? гэж бодохоор тодорхой боловсролын стандартын цогц чадамжууд өнөөдрийн хичээл дээр,

энэ сэдвийн хүрээнд сурагчид эзэмших ёстой мэдлэг, чадварыг уялдаа холбоонд нь авч үзэж байж хичээлээ төлөвлөх хэрэгтэй болно.

Хичээлийн агуулгыг сонгож боловсруулах

Агуулгын босоо, хөндлөн холбоог тооцон шурган (спирал) агуулга бүхий хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх (Такахата багш)

Энэ санааг манай нөхцөлд буулгавал:

- Цогц чадамжийн тасралтгүй хөгжлийг дэмжих, агуулга анги ахих бүрийд өргөсөн, агуулга дахь ухагдахуун, хуулийн утга санаа илүү гүнзгийрэх. Цөөн агуулгын хүрээнд баттай, шаардлагатай үед санагддаг суурь мэдлэг олгох,
- Сурагчдын өмнөх мэдлэгийн түвшнийг тооцон шинэ мэдлэгийг боловсруулах.

Хичээлд бэлтгэх

Хичээлийн бэлтгэл нь сурах бичгээ халт харах, туршилтад шаардлагатай багаж төхөөрөмжийг шалгаж үзэх гэх мэт хялбар төдий ажиллагаа биш (Камата багш)

"Сурагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил" төслийн гол санаа, хуримтлуулсан туршлага:

- БДБС, арга зүйн хөгжлийн зарчмыг ойлгож хэрэгжүүлэх нь багш бүрийн үүрэг. Төслийн багш нар энэ ажлыг илүү мэдлэг, чадвартай гүйцэтгэх туршлагатай болсон.
- Энэ төсөлд хамрагдсан багш нар хичээлд бэлтгэх, төлөвлөх, хичээлийг явуулах, хичээлээ хэлэлцэн сайжруулах явцад арга зүйгээ хэрхэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг өөрсдөө хийж гүйцэтгэсэн. Хүүхэд төвтэй, хүүхэд бүрт үр өгөөж өгдөг хичээлийн талаарх мэдлэг, чадвар нь нэмэгдсэн.
- Энэ ажилд Монгол, Японы багш бэлтгэдэг дээд сургуулийн багш нар онол, арга зүйн талаар дэмжлэг үзүүлсэн.
- Төслийн сургуулиудын удирдлага, хамт олон дэмжлэг үзүүлсэн.
- Төслийн менежментийг БСШУЯ, Жайка-ийн төслийн баг ерөнхийд нь хариуцаж дэмжлэг үзүүлсэн.

Төслийн үр дүн:

- Төвлөрсөн сургалт явуулах менежмент буй болсон.
- Сургууль, багш нар ашиглах гарын авлага боловсруулсан.

"Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрцүлэх тогтолцоог бэхжүүлэх" төслийн гол санаа, зорилго:

- Төсөлд хамрагдаж буй сургуулиудын багш нар БДБС, арга зүйн хөгжлийн зарчмыг ойлгож хэрэгжүүлэх ажлыг илүү мэдлэг, чадвартайгаар гүйцэтгэдэг болох талаар туршлага хуримтлуулна.
- Багш нар хичээлд бэлтгэх, төлөвлөх, хичээлийг явуулах, хичээлээ хэлэлцэн сайжруулах явцад арга зүйгээ хэрхэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг өөрсдөө хийж гүйцэтгэнэ.
- Өмнөх төслийн багш нартай адил туршлага хуримтлуулж, хүүхэд төвтэй, хүүхэд бүрт үр өгөөж өгдөг хичээлийн талаарх мэдлэг, чадвараа нэмэгдүүлэхээр ажиллана.
- Төвлөрсөн сургалтын материал, өмнө боловсруулсан гарын авлагуудыг судлаж, санаа авна.

- Төслийн хүрээнд хэд хэдэн модуль боловсруулахад сургууль багш нарын бие даан санаачлан хийсэн ажлууд тусгагдана.

Хичээлийн бэлтгэл судалгааны дор юуны өмнө дараах санаануудыг ойлгож болох талаар хэлэлцэх, шийдвэрлэх:

- Хичээлд бэлтгэх, төлөвлөх, хөтөлбөрөө боловсруулахдаа тодорхой шийдлүүдийг учир утгатай, тунгаан бодож боловсруулаад, түүнийгээ хичээлийн явцад хэрхэн хэрэгжүүлэхээ төлөвлөөд, хэрэглэгдэх материалуудыг бэлтгэх цогц үйл ажиллагаа
- Багш өөрийн сурагчдаа судлан, тэдэнд зориулан бэлтгэсэн, өмнөхөөсөө давуу талтай төгөлдөржсөн арга зүй бүхий хичээл заах үедээ хэрэглэх бэлтгэл материал.
- Багшийн шийдэл бүр багшийн оюуны бүтээл, эдгээр шийдэлд тулгуурласан хөтөлбөр нь судалгаанд суурилсан хөтөлбөр болно.

Багш нарын арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх:

- Бэлэн арга зүй дэлгэрүүлж байгаа биш. Хүүхэд, багш, сургууль бүр нь өөрийн онцлогтой. Сургууль, багш нар хичээлд бэлтгэх, явуулах, хэлэлцэн сайжруулах арга зүйн үндсэн зарчмуудыг ойлгож, өөрийн онцлогийг тооцон хэрэгжүүлнэ. Ингэж хэрэгжүүлдэг сургууль багш нарын тоо олон болно.
- Хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн судалгааны дээр дурдсан санаанууд нь аль ч хичээлийн хувьд хэрэгжих боломжтой боловч, хичээл бүр өөрийн онцлогтой стандартыг хэрэгжүүлдэг, өөрийн гэсэн онцлог бүхий арга зүйтэй гэдгийг тооцох.

Төслийн цр дүн:

Хичээлд бэлтгэх, хичээлийг явуулах, хичээлээ хэлэлцэн сайжруулдаг сургууль төвтэй тогтолцоог буй болгох замаар хичээлийн соёлыг хөгжүүлэх. Сургууль, багш бүр өөрийн гэсэн онцлогтой арга зүйгээр хувь нэмэр оруулдаг уламжлалтай болох. Төслийн хүрээнд хэрэгжих энэхүү үйл ажиллагаа нь бага, дунд боловсролын салбарын шинэчлэлийн үйл явцад тодорхой хувь нэмэр оруулах.

1.2 Суралцагчдын танин мэдэх онцлог

Боловсролын шинэчлэлийг эхэлж байсан 1990-ээд оны үед сургалтын арга зүйг хөгжүүлэхдээ *Хүцхдэд яаж заах вэ? Хүцхэд хэрхэн яаж суралцдаг вэ?* гэдэг асуултын алианаас нь эхлэх вэ гэсэн асуултыг тавьж байжээ. “Хэрэв *хүцхэд хэрхэн яаж суралцдаг вэ гэсэн асуултын хариултыг олоод, тэр зүй тогтолд нь нийцүүлэн заах аргаа боловсруулбал илүү оновчтой байх нь ойлгомжтой*” гэж хүүхэд яаж юм мэддэг, чаддаг болдгийг тунгаан бодох тухай сануулгыг 1999 онд хэвлэсэн, багш нарт зориулсан сургалтын гарын авлагад дурдаж байсныг сануулж энэ хэсгийн мэдээллийг эхэлье. Тэр цагаас хойш сургалтын арга зүйг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийсэн. Мөн 2000 оны “Технологийн шинэчлэл” сургалтаар “Мэдлэг нь хүнээс хүнд бүрэн утгаараа шууд, гүйцэд дамждаггүй бөгөөд хүн бүр өөрийн идэвхтэй, учир шалтгаант үйл ажиллагаагаар бусадтай хамтран нийгэмших явцдаа эзэмшихүйн зүй тогтлын дагуу мэдлэгээ өөрөө бүтээдэг” гэсэн санааг ярьж, сурталчилж, судалж, стандартын арга зүйн хөгжлийн үндсэн үзэл баримтлал болгож дэвшүүлсэн билээ. Энэ бүхний үр дүнд багшлах арга зүйд тодорхой ахиц дэвшил гарч байгаа ч багшийн арга зүйн шинэчлэл удаашралтай явагдаж байна. Бид эдгээр суралцахуйн сэтгэл судлалын шинэлэг зарчмыг их ярьж, бага хэрэгжүүлж байна.

Хэдийгээр боловсролын стандарт, үндэсний хөтөлбөрт суралцагч төвтэй багшлах арга зүйн шинэчлэлийн үзэл санааг боломжийн түвшинд тусгасан боловч

уламжлалт сургалтын зааж зааварладаг, мэдлэг дамжуулдаг арга зүй багш нарын дунд давамгайлсаар байна. Суралцагч өөрөө мэдлэгээ бүтээхэд нь туслах, тэрхүү багшлах арга зүйг хөгжүүлэхийн тулд хичээлийн судалгаа хийдэг. БШУЯ ба ЈСА байгууллагын хамтран хэрэгжүүлж буй багшийн арга зүйн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх зорилготой 2 шаттай төсөл энэ чиглэлд дорвитой үйл ажиллагаа явуулж байна.

Хичээлийн судалгаа, түүнийг хэрхэн явуулдаг арга зүйд суралцаж, улмаар судалгаат хичээл бүтээхийн тулд бид суралцагчдыг сайн судалж, тэдний танин мэдэх онцлогт нийцүүлэн хичээлийг бэлтгэх, явуулах, ажиглах, хэлэлцэх учиртай. Эхлээд *хүүхдийн хөгжлийг* бид хэрхэн ойлгож байгаа талаар онолын үндэслэлтэй дурдъя.

Хүүхдийн оюуны хөгжил ба сурах үйл ажиллагааны талаарх сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын (educational psychology) онол, үзэл баримтлалд хүүхдийн авьяас, чадвар харилцан адилгүй байдгаас үл хамааран, алсдаа мэдэж, чадах ёстой бүхий л зүйлийг хүүхэд бүр сурах боломжтой байдаг бөгөөд суралцахуй нь оюуны хөгжлийн хамгийн хүчтэй механизм гэж үздэг. Үүнийг үндэслэн “Хүн өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар мэдлэгээ бүтээн сурах үйл ажиллагааны үр дүнд хөгжинө” гэсэн санааг хүүхдийн хөгжил гэдэг утгаар авч үзэхээр төслийн I шатанд тогтсон болно.

Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйн хувьд нэг маягийн хэв загвар байхгүй. Хичээл бүр, хүүхэд бүр өөрийн онцлогтой.

Тухайлбал, байгалийн ухааны боловсрол нь байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах, шинжлэх ухаанч хандлага, аливаа асуудлыг байгаль ахуйд ээлтэйгээр шийдвэрлэхэд хариуцлагатай, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээтэй хандаж, нийгмийн амьдралын бүхий л түвшинд шийдвэр гаргахад оролцохын тулд байгалийн ухааны зохих мэдлэг, чадвартай байхыг шаардаж байна. Үүнийг бид байгалийн ухааны хичээлүүдээрээ эзэмшүүлдэг. Хэдийгээр багш нар байгалийн ухааны боловсролын зорилго, зорилт, байгалийн шинжлэх ухааныг нэвтэрхий мэддэг байсан ч суралцагч хэрхэн сурдаг зүй тогтол, тухайн ангийн сурагчдын онцлогийг мэдэхгүйгээр хичээлийн арга зүйг дэглэх боломж байхгүй. Тухайн ангийн сурагчдын онцлог гэдгийн дор хоёр талт асуудлыг авч үзэж байна. Хүний хөгжлийн сэтгэл судлалын онолуудад хүний бие бялдар, сэтгэл нийгэмшихүй, оюун ухааны хөгжлийг хүүхэд төрөхөөс эхлээд өтөл наслах хүртэл насны үечлэлээр нь судлан тогтоосон байдаг. Мэдээж, улс орон, бүс нутгийн соёл уламжлал, зан заншил өөр байдаг хэдий ч хүний хөгжлийн дээрх онцлогууд нь нийтлэг байдаг байна. Иймд судлаачдын судалж тогтоосон сургуулийн бага, суурь боловсролын шатны хүүхдийн хөгжлийн ерөнхий зүй тогтол онцлогоос танин мэдэхүй, оюун ухааны онцлогийг чухалчлан танилцуулахыг хичээлээ. Асуудлын нөгөө тал нь танай сургууль, таны заадаг хичээлд сууж байгаа хүүхэд бүр өөрийн онцлогтой. Хичээлийн сурган хүмүүжүүлэх техникийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй энэ онцлогийг зөвхөн Та л мэдэж байгаа. Хэрвээ Та бүхэн тухайн насны хүүхдийн нийтлэг болон тухайн ангийн сурагч бүрийн онцлогийг мэдэж, зөвлөмжийн дараагийн сэдэвт танилцуулах хичээлийн бэлтгэл судалгаа хийх, заах ажиглах, хэлэлцүүлэг хийх үе шатны арга зүйд тусган хэрэгжүүлж чадвал суралцагч төвтэй багшлах арга зүйгээ хөгжүүлж чадна.

Одоо Та бүхэнд бага, суурь боловсролд хамрагдаж буй сурагчдын оюун ухааны хөгжлийн онцлогийг насны үечлэлээр танлцуулья.

Оюун ухааны хөгжлийн онцлог (6 нас)*(Сэтгэхүйн цйлдлийн өмнөх шат)*

	Онцлог
Сэтгэхүйн хөгжил:	- Бодит байдлаас сэрж мэдэрнэ. - Бодит эд юмстай харилцах үйлдэл хийнгээ танин мэднэ - Харах, үнэрлэх, сонсох, амтлах, барих 5 мэдрэхүйн тусламжтайгаар юмсын гадаад, үндсэн шинжийг сэрж мэдэрч эхэлнэ
Хүртэхүйн хөгжил	- Хүртэхүйн задлан шинжлэх сул хөгжсөн тул юмсыг хүртэх үедээ сэтгэл догдлуулсан, хурц тод, нүдэнд харагдах зүйлд анхаарлаа төвлөрүүлээд гол зүйлийг орхино. - Анхаарлын багтаамж 3-4 объект. - Анхаарлын төвлөрөх хугацаа 7-10 мин, хуваарилах чадвар сул. - Анхаарал нэг хэвийн үйл ажиллагаанд амархан сарнина. - Механик ой давамгайлна. Юмыг байгаа чигээр нь тогтоож, сэргээн санана. - Ой тогтоолт нь санамсаргүй өнгөц шинжтэй. - Хараа, сонсголын ой түлхүү хөгжинө. Харснаа арай удаан, сонссоноо арай хурдан мартана. - Өдөр тутмын амьдралд хэрэглэдэг зүйлс, сонирхолтой, сэтгэл татсан зүйлийг амархан тогтооно. - Хурдан тогтооно, тогтоосноо сэргээн санах нь сул. - Түргэн мартана. - Хийсвэр сэтгэхүй хөгжөөгүй байна. - Задлан ялгах шинж сул хөгжсөн байна. - Дүрслэн бодохуй сайн хөгжсөн байна.
Хэл ярианы хөгжил	- Бусдын яриаг анхааралтай сонсоно, бүрэн ойлгоно. - Авиаг ялгаж сонсоно. - Хийсвэр утгатай үгийг ойлгохгүй. - Зүйр цэцэн үгийн утгыг ойлгоно. - Дуу хоолой, хэл ярианы өнгө ялгаатай болон төстэй талыг ялгана. - Асуултад хариулна. - Юмны хэлбэр, хэмжээ, өнгийг үгээр илэрхийлнэ. - Үзэж харсан зүйлдээ тулгуурлан “худлаа” зохиож ярина. - Эргэн тойрны үйл ажиллагаатай холбоотой асуулт тавина. Яагаад? Ямар хачин юм бэ? гэсэн учрыг ойлгох асуулт тавина. - Яриа нь тоочсон шинжтэй, хурц. - Яриандаа нэр үг, үйл үг, аялга үг, төлөөний нэр, тэмдэг нэр голдуу хэрэглэнэ. - Үгийн нөөц 1900-2000, идэвхитэй үгийн нөөц ихсэнэ. - Ахуйн яриандаа хүсэж мөрөөдөх, шаардах, хүсэх төлөвийг өргөн хэрэглэдэг мэдрэмжээ илэрхийлж сурна. - Таньдаг хүнтэй мэндчилнэ. - Шүлгийг урнаар уншихыг эрмэлзэнэ. - Үгэн тоглоомоор тоглох дуртай болно.

Хүүхдийн оюун ухааны гол төлөвшил 0-5 насанд явагдаж дууссан байна гэж судлаачид үзэж байна [3]. Зургаан настай, нэгдүгээр ангийн сурагчдын хувьд хөгжлийн тодорхой үе шатыг туулаад “Их мэдэх” болсон нас юм. Гэвч сургуулийн босгыг анхлан алхаж орсон, суралцах арга барилд суралцаагүй эдгээр сурагчдад бэрхшээл багагүй тулгарна. Иймд дараах сурган хүмүүжүүлэх арга техникийн өргөн хэрэглэхийг зөвлөж байна.

Хөгжүүлэх зорилго:

Мэдээж хичээл бүр өөрийн онцлогтой суралцахуйн үйлийг хэрэгжүүлэх нь тодорхой. Энэ ангийн хичээл нь хүүхдийг:

- Сургуульд дасахад нь сэтгэл санааны хувьд дэмжиж сурах хүсэл сонирхолтой болгох
- Өөрийгөө бие даан авч явах, тохиолдох саад бэрхшээлийг даван туулах тэсвэр суулгах
- Бүтээгүй зүйлдээ гутрахгүй байх, зүтгэл чармайлт гаргахад бэлтгэх,
- Айж эмээхгүйгээр санаагаа бусадтай хуваалцах,
- Бусдын ярьсныг ойлгох, тодорхой хугацаанд анхаарлаа төвлөрүүлэн барих, тогтоох, бодож сэтгэх чадвартай болгох зэрэгт голлон анхаарах шаардлагатай.

Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Ойр зуурын эд юмсыг хэлбэр, хэмжээ, өнгөөр нь бүлэглүүлэх
- Эд юмсыг ерөнхий ойлголтоор нэрлүүлэх
- Эд юмсыг хэлбэр, хэмжээ, өнгөөр нь харьцуулж ялгах, төсөөтэй ба ялгаатай талыг олуулах
- Үндсэн 7 өнгө ялгуулах, нэрлүүлэх
- Энгийн дүрэм, журам болон зүй тогтлыг зөрчихгүй байхыг таниулах
- Тоог тоолуулах, арифметикийн өгүүлбэртэй бодлого бодуулах
- Цаг, хугацааны үргэлжлэх, дараалал, орон зайн тухай анхны мэдэгдэхүүнтэй болгох
- Хүсэж буй зүйл, хийх гэж буй зүйлийнх нь ялгааг мэдүүлэх
- Эргэн тойрны бодит танил юмсын шинж, түүний өөрчлөлтийг 5 мэдрэхүйг ашиглан ажиглуулах, яриулах
- Сурах явцад нь тоглуулах, тоглоомоор дамжуулан сургах
- Юмсын байрлалыг тодорхойлуулах
- Геометрийн үндсэн дүрсийг ялгуулах, нэрлүүлэх
- Байгалийн танил авиаг ялгуулах, нэрлүүлэх
- Танил юмсыг өөрийн нь санаагаар дүрслүүлэх, хуулбарлуулах
- Тод үндсэн өнгийг илүү хэрэглэх
- Үгээр илэхийлсэн ойрын, танил, богино мэдээлэлтэй ажиллуулах, зуруулах
- Өгөгдсөн хялбар, ойлгомжтой аргачлалын дагуу дүрс бүтээлгэх гэх мэт
- Түргэн мартдаг тул давтан хийлгэх, давтуулах

Оюун ухааны хөгжлийн онцлог (7 нас)

Онцлог

Сэтгэхүй, хүртэхүйн хөгжил:

- Бодит дүрслэлийн сэтгэхүй эрчимтэй хөгжинө.
- Бодит зүйлийг орлуулан хэрэглэх чадвартай болсон байна.
- Төсөөллийн хөгжил сайжирч дүрслэлт сэтгэхүй эрчимтэй хөгжинө.
- Энгийн сэтгэхүйн үйлдлүүд хийж эхэлнэ.
- Хийсвэр ухагдахууныг ойлгохгүй.
- Хүртэхүйн бүхий л хэлбэр (хараа, сонсгол, хөдөлгөөний г.м.)-ийн хөгжил, зохицолгоо сайжирна.
- Юмсыг салангид шинжээр нь ялган танина.
- Анхаарал зориуд бус шинжтэй, багтаамж, төвлөрөх хугацаа бага зэрэг нэмэгдэнэ.
- Тод, хурц, өөрийнх нь сонирхлыг татсан зүйлийг амархан тогтооно.
- Сэргээн санана, утгын сул ой хөгжинө.
- Урьд өмнө хүртэж мэдэрсэн зарим тодорхой юмсын дүр, төсөөллөөр ой ухаан нь баялаг болно.

Хэл ярианы хөгжил	• Ойлгох чадвар сайжирна. • Хийсвэр утгатай үгийг ойлгоход бэрхшээлтэй хэвээр байна. • Яагаад гэдэг асуултыг тавина. • Сул үг нь багасаж, яриа нь илүү утгатай болно. • Өөрийн бодол санаагаа бүрэн илэрхийлж чадна.
--------------------------	--

Долоон настай хүүхдийн хувьд хүн, амьтан, байгалийг оролцуулан зурах зэргээр зурах сэдвийн хүрээ өргөжинө, баяжуулж зурна, нүд гарынхаа хөдөлгөөнийг хянаана, зурахдаа олон өнгө хэрэглэхийг хичээнэ, дүрслэхүй нь нэлээд бүтээлч шинжтэй болно, жижиг зүйлийг анхаарахгүй орхих тал байдаг зэрэг онцлогийг сургалтын явцад тооцож ажиллах шаардлагатай.

Оюун ухааны хөгжил (8 нас)

	Онцлог
Сэтгэхүй, хүртэхүйн хөгжил:	• Хүртэхүйн задлан шинжлэх чадвар нэмэгдэнэ. • Тод зүйлд анхаарлаа төвлөрүүлэх төдийгүй, зориудын зүйлийг анхаарч эхэлнэ. • Төсөөлөл эрчимтэй хөгжинө. • Бодит юмсын дүр, төсөөлөлд тулгуурлан дүрслэлт сэтгэхүй эрчимтэй хөгжихийн зэрэгцээ хийсвэр сэтгэхүй хөгжих эхлэл тавигдана. • Жишиж харьцуулах, эд юмсыг зориулалт, хэлбэр, хэмжээ, өнгөөр нь ангилах сэтгэхүйн үйлдлийг хийнэ. • Харин юмсыг ангилах үндэслэлийг ойлгохгүй.
Суралцах үйлийн хөгжил	• Үг яриа утгын ой сайн хөгжинө. • Албадмал үйл ажиллагаанд анхаарал сарнина. • 40 минутад 2-3 үйл ажиллагааг ээлжилж хийлгэх боломжтой болно. • Дүрслэн бодохуй нь бүтээлч шинжтэй болно. • Өнгийг хооронд нь хольж будах чадвартай болно. • Хээлэх, чимэглэх сонирхол ажиглагдана. • Зурах чадвар сайжирна. Нарыг уулын цаанаас голлуулж зурдаг болно гэх мэт.

Оюун ухааны хөгжлийн онцлог (9-12 нас)

Оюун ухааны хөгжлийн онцлог:

- Анхаарлаа төвлөрүүлэх хугацаа нэмэгдэнэ.
- Аливаа зүйлийг уялдаа холбоонд нь авч үзнэ.
- Юмсыг хэд хэдэн шинжээр нь ангилан ялгах, цуваанд дэс дарааллыг олох.
- Асуудлыг шийдвэрлэх чадвар нь нэмэгдэж, түүнийгээ дагаад бие дааж асуудлыг шийдвэрлэхэд суралцана.
- Ирээдүйнхээ боловсрол мэргэжлийн талаар бодож эхэлнэ.
- Тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулж танин мэдэхээс юмсын шинж чанар, учир шалтгааныг олж, таньж мэдэх, тэдгээрийг турших судлах зэргээр шинжлэх ухаанч талын үйл ажиллагаанд дуртай болж эхэлнэ.
- Туршилтыг ургуулан хийсвэрлэн бодох, таамаглал дэвшүүлэх зэрэгт төвлөрөх, асуудлыг шийдвэрлэхийг олон талаас нь оролдох, уялдаа холбоонд нь бодож шийдвэрлэх зэрэгт суралцана.
- Энэ насны сурагчдын унших чадвар сайжирч, бие даан унших дуртай болсон байдаг.

Зөвлөгөө:

Бага боловсролын 4 дүгээр ангиас эхлэн суралцах эдгээр насны хүүхдүүд өсөж өндөр болсон, томчуудын хэрэглэдэг багаж хэрэгсэл алх, хөрөө зэргийг хэрэглэж чаддаг болж, модоор наад захын энгийн зүйлийг бүтээх, оёх зэрэг үйлийг хийж чадна. Харин нарийн чимхлүүр ажлыг хийхэд хүндрэлтэй. Бичгийн хурд нэмэгдэж, шугамгүй цаасан дээр илүү хурдан бичнэ. Мөн хувийн хариуцлага нь дээшилж, бусдын зовлонг ойлгож, өөрийнхөө оронд тавьдаг болж ирнэ. Хэрэв тэднийг зоригжуулаад дэмжээд өгвөл санаагаа хэрэгжүүлж чадна. Цагийг хэрхэн зөв өнгөрөөх, ажил үүргээ хуваарилан үүргээ ухамсарлан, өөртөө шүүмжлэлтэй ханддаг болж ирнэ. Найз нөхдөдөө эцэг эхээсээ илүү итгэдэг. Бусдын бодлыг хүндэтгэж эхлэх боловч өөрийнхөөрөө зүтгэх нь ч бий. Найз нөхөд ах дүү нартайгаа муудалцах зэрэг харилцааны асуудалд уян хатан байх, буулт хийхдээ тийм ч сайн биш. Бусдыг өөртэйгээ насанд хүрсэн хүнтэй адил харьцахыг хүсдэг. Нийгмийн ухамсар дээшилж, ядуурал, дайн гэх мэт асуудлын талаар өөрийн гэсэн ойлголттой болж, хийсвэр сэтгэлгээ нь ч хөгжиж эхлэнэ. Иймд эдгээр сурагчдад багшлах арга зүй нь 1-3 дугаар ангийн сурагчдаас эрс ялгаатай болж ирнэ. Ялангуяа математик, байгалийн ухааны хичээлийн үүрэг чухал болно.

Оюун ухааны хөгжлийн онцлог (13-16 нас)

- Хүртэж байгаа юмс, үзэгдлийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвартай болно. Иймээс байгалийн бодит юмс, үзэгдлийг судлах арга барил, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх үйлд сургахад түлхүү анхаарах.
- Юмс, үзэгдлийг гол төлөв өрөөсгөл талаас нь тусгаж авдаг учраас хүртэхүйд гажуу тусгал явагдаж болзошгүйг багш анхааралдаа байлгах. Тухайлбал, хурц тод, онцгой сэтгэгдэл төрүүлсэн зүйлийг хамгийн түрүүнд тусган авч, тухайн юмны гол шинж чанар, харилцан холбоог анхаарахгүй байх гэх мэт.
- Тэд юмыг бодит байдлаас тусган хүртэж эхлээд, дараа нь тэдгээрийн харилцаа холбоо, шинж чанарыг логик сэтгэмжийн үндсэн дээр дүгнэж тогтоох чадвартай. Иймээс логик хүртэхүй нь бага ангийн хүүхдүүдээс тэднийг ялгана.
- Хэл ярианы хөгжил улам нарийсч хөгжинө. Иймээс хэл, ухагдахуун, цгээр илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд анхаарах. Ингэхдээ энгийн амьдралын ахуйн хэл ярианаас шинжлэх ухааны хэл, улмаар математик хэлэнд шилжих гэсэн дарааллыг баримтлах.
- Тогтоох, сэргээн санах, хадгалах ойн процессуудад үндсэн өөрчлөлт гарна. Иймээс бодох, бичих, сэтгэх, ангилах, системчлэх, ерөнхийлөх, дүгнэх зэрэг хараа, сонсгол, хөдөлгөөний хүртэхүйн хэлбэрүүдийг оролцуулдаг цйл ажиллагааг сургалтад өргөн ашиглах.
- Энэ насны хүүхдийн сэтгэцийн хөгжилд хүрээлэн буй орчин, нийгмийн харилцан хамаарал, харилцаа гол үүрэгтэй. Иймээс бидний болон нийгмийн амьдралд тохиолдож буй асуудлуудад тэднийг хандуулах, сөрөг үр дагавруудыг илрүүлэх, хамгаалах арга замуудыг эрж хайх байдалд хүргэх, идэвхийг өрнүүлсэн байхаар хичээлийг зохион байгуулах, хичээл хоорондын холбоог сайтар тооцох шаардлагатай.
- Өөрсдийгөө насанд хүрсэн хүн гэж тооцдог тул мэдлэг, чадвар, дадал шаардсан даалгавар өгөхөд дуртай хүлээн авдаг. Иймээс суралцагчдынхаа гүйцэтгэлийн чадварт итгэж, зоригжуулан зөв сэдэл тэмцлэл төрүүлэх. Гэхдээ өсвөр насны хүүхэд юмс, үзэгдлийг түүний бүхэл шинжүүдийн

цогцоор нь нэгтгэн дүгнэх, нэгэн бүхэл зүйл болгож үнэлэх талаар дутмаг байдгийг ямагт тооцох.

- Орчин үеийн өсвөр насны хүүхдүүд рок, поп, хип поп, техно гэх мэт хөгжмийн урсгалууд, интернет, компьютер маш их сонирхдог болжээ. Иймээс сургалтанд *мэдээллийн дэвшилт технологи аль болох ашиглах* боломжийг бүрдүүлэхэд анхаарах.
- Ёс суртахуун, ухамсар, үзэл санаа, итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзэл анхлан бүрэлдэн тогтоно. Ялангуяа хүн, амьдрал хэрхэн үүссэн, хүний үүсэл хөгжил, од гаригийн бүтэц, г.м. *ертөнцийг таних сонирхол, эрмэлзэлд автах* тул байгалийн ухааны хичээлийн хэрэгцээ, үүрэг чухал болж ирдэг.
- Байгалийн үзэгдлийг танин мэдэхэд чиглэсэн танин мэдэх сонирхол нь тэдэнд шинжлэх ухааны үндсийг судлах явцад үүсэж хөгжинө. Өсвөр насны хүүхдийн *танин мэдэх сонирхол нь шилэн сонгох шинж чанартай*. Иймд хүүхэд өсвөр насны үед заагддаг хичээлийн дотроос зарим хичээлийг илүү сонирхон, тэр салбарыг судалж эхэлдэг.

Энэ нас нь сэтгэл судлалын ухааны ангиллаар өсвөр насныхан гэсэн ангилалд хамрагддаг. Энэ насны хүүхдүүдийн хувьд бие бялдрын өсөлтийн гол онцлог нь бэлгийн бойжилт явагдаж, саатлаас хөөрөх процесс давуу байдаг тул сэтгэлийн хөдөлгөөн маш оргилуун, биеэ барих, өөрийгөө хянах чадвар сулардгаас тэдний сэтгэлийн хөдөлгөөнийг удирдан жолоодоход төвөгтэй болдгоос гадна оюуны хөгжлийн хурд түргэсэж, тархины үйл ажиллагаа идэвхжиж ухамсарт үйлд удирдан оруулдаг, дохионы 2-р системийн үүрэг ихсэж, үг ярианы цочроогч нь дохионы системд шийдвэрлэх үүрэгтэй болж ирнэ.


Энд “хичээлийн судалгаа”, “хүүхдийн хөгжил”, “хүүхдийн танин мэдэх онцлог” гэсэн түлхүүр үгүүд, голчлон хэрэглэгдэж хичээлийн бэлтгэл судалгааны нэг хэсэг нь суралцагчдаа судлах судалгаа гэдэг нь ойлгогдсон байх. Хичээлийн судалгаа хийснээр багшлах аргаа өөрчлөнө, багшлах арга өөрчлөгдсөнөөр хүүхдүүд хөгжинө. Мэдээж багшийн багшлах арга өөрчлөгдөхгүй бол хүүхэд өөрчлөгдөхгүй гэсэн үг. Хүүхдийн танин мэдэхүйн онцлог, түвшнийг (өсөлт хөгжил) мэдэж, түүнд суурилан хичээлийн судалгааг төлөвлөж, явуулах нь хичээлийн үр дүнд чухал нөлөөлөх нь тодорхой байна. Багш суралцагчийн нас сэтгэхүй, танин мэдэх онцлогийг тооцсон үед л тухайн зорилт биелэгдэх боломж бүрдэж, агуулгыг суралцагчид ойлгон хүлээж авах эсэх нь тодорхойлогдож, улмаар ямар асуулт асууж, хариултаа яаж авах, ямар тайлбар хийвэл амархан ойлгогдох, хичээлийн хэлэлцүүлгийг хийх нарийн дараалал, аргачлал зэргийг нарийн тунгаан бодож төлөвлөх боломжтой. Гэтэл бид хичээлийн зорилгыг дэвшүүлэх, агуулгыг сонгож боловсруулахдаа олон жил зөвхөн судлагдахуунаа гол болгож, өөрийн хур туршлагад дулдуйдаж ирсэн байна. Сэдвийн эхэнд тавьсан асуултаа эргэн саная. Өөрөөр хэлбэл *Хүүхдэд яаж заах вэ? гэдгээ гол болгожээ. Энэ насны хүүхэд хэрхэн яаж суралцдаг вэ?* гэдэг нь цаашид хичээлийн судалгааны бас нэг гол хэсэг байхыг анхааралдаа авахыг зөвлөж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙХ АРГА ЗҮЙ

Хичээлийн судалгааг чухалчлан авч үзэх үндэслэл:

Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн бид багш нарын арга зүйг хөгжүүлэх, сургалтын аргын чиглэлээр олон төсөл хэрэгжүүлж, сургалт, семинар зохион байгуулж ирсэн. Гэвч багш нарын арга зүйд төдийлэн бодитой хөгжил харагдахгүй байгаа билээ. Үүний нэг учир шалтгаан нь эдгээр төсөл, сургалт, семинар нь дээрээс доош чиглэсэн үйл ажиллагаагаар буюу БШУЯ, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс сургууль, багш руу чиглэсэн хэлбэрээр явуулж байсантай шууд холбоотой байж мэдэх юм. Тухайн сургууль, багш нар төсөлд хамрагдахаар сонгогдсон учраас хамрагдсан, сургалтад суу гэсэн учраас суусан гэсэн сэтгэлгээгээр хандаж, арга зүйгээ шинэчлэх зорилго, хэрэгцээгээ төдийлэн сайн ойлгоогүй байснаас бодитой үр дүнд хүрэхүйц ажиллахгүй байсан бизээ. Өөрөөр хэлбэл, бидний зүгээс ЕБС-ийн багш нарт явуулдаг байсан хүүхэд төвтэй сургалт, мэдлэг бүтээх арга зүй гэх мэт сургалтууд явуулахдаа өөрсдөө уламжлалт буюу лекцдэх, онолдох байдлаар зохион байгуулдаг, багш нар сонсогч байдлаар оролцдог байсантай ч холбоотой байж болно.



Иймээс БШУЯ, ЖАЙКА байгууллагын хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн гол санаа нь доороос дээш чиглэсэн үйл ажиллагаа явуулах, тухайлбал, үнэхээр төсөл хэрэгжүүлэх замаар багш нарын арга зүйгээ хөгжүүлэх хүсэл, сонирхолтой сургууль багш нарыг сонгох, улмаар эдгээр төслийн хүрээнд явуулж буй сургалтуудаа аль болох мэдлэг бүтээлгэх, багш нарт өөрсдөд нь мэдрүүлсэн, идэвхтэй ажиллуулах хэлбэрээр явуулахад оршиж байсан. Өөрөөр хэлбэл, сургууль, багш нарын зүгээс санаачлагатай ажиллаж сургуульд суурилсан судалгаа явуулах, багш нар хамтран арга зүйгээ хөгжүүлэх, туршлага хуваалцах үйл ажиллагаа явуулах нь арга зүйн хөгжлийн үйл явцыг түргэсгэх боломжтой юм.

Багш нар сургуульд суурилсан судалгаа явуулж, хамтран арга зүйгээ хөгжүүлэх боломж нь хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгаа хийж хэвших явдал билээ. Энэ нь өмнөх төслийн үр дүнгээс харагдсан. Иймээс хичээлийн судалгааны арга зүйг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх тогтоцлоог бүрдүүлэх нь эрхэм зорилго мөн.

Хичээлийн судалгааг чухалчлахын ач холбогдлыг харуулсан нэгэн жишээг танилцуулж байна.

Жишээ 1. “...2000 оны 9 сарын нэгэн өдрийн үдээс өмнө сургуулийн багш нарын өрөөнд Японы 8 багш “Пропорц” сэдэвт 12 цагийн нэгж хичээлийн эхний цагийн хичээлийг хамтран төлөвлөж байгааг ажиглаж байв. Энэ хичээлээр сурагчид шугаман болон шугаман бус хамаарлын хоорондын ялгааг тодорхойлох, үсгээр тэмдэглэх санаатай анхлан танилцах байв. Тэр багш нарын 2 цаг гаран ярилцсан хэлэлцүүлгээс товчхон иш татвал:

Б-1 (нэгдүгээр багш): Бид сурагчдын өдөр тутмын амьдралд ойр жишээ авах хэрэгтэй байна. Гол асуудал бол хүчхэд янз бүрийн жишээ гаргах боломжтой байхаар асуултаа яаж томъёолох вэ? гэдэгт байна. Хирано багш та өнгөрсөн жил энэ сэдвийг хэрхэн заасан бэ?

Б-3: Би зураг ашигласан. Жишээлбэл, зам дээр явж буй машины зураг гэх мэт. Сурагчид эхлээд зам болон хугацааны талаар ойлголт авна. Гэвч би тэдэнд бодох хугацаа өгөх тусам тэднээс өөр өөр шинэ санаа гарч байсан. Тухайлбал хугацаа болон энерги зарцуулалт гэх мэт.

Б-1: Хэмжигдэхүцний өөрчлөлтийг төсөөлүүлэхийн тулд зураг ашигласан юм байна. За, өөр санаа байна уу? Арай өөр арга, арай өөр санаа ашиглая.

Б-4: ... Сурагчид сургууль дээрээ шарсан төмс хийдэг. Шарсан төмс янз бүрийн өнгөтэй байдаг. Тэгэхээр бид сурагчдаас шарсан төмс яагаад ийм өөр өөр өнгөтэй болоод байгааг асууж болох юм. Ингэхэд тосонд шарсан хугацаа болон тосны температур зэргээс болоод өөр байдаг байх гэсэн хариултууд гарч болно. Бид эдгээр өөрчлөлтийн нэгийнх нь талаар авч үзэж болох юм.

Б-1: Тэгвэл бид асуултаа: Энд олон янзын шарсан төмс байна. Гэвч яагаад өнгө нь өөр байгаа юм бол? гэсэн байдлаар томъёолж болох уу?

Б6: ...Би бол зураг биш, бодит зүйл ажиглуулах нь илцү чухал гэж бодож байна. Жишээлбэл, гоожуураас ус гоожуулж, усны эзэлхүцний өөрчлөлтийг судлуулах байж болно.

Б8: Гэхдээ бид тодорхой объект авбал хүчхдүд өөрсдөө биеэр туршиж үзэхийг хүснэ. Иймээс бид тодорхой биет зүйл авахаас зайлсхийж Хирано багшийн авсан шиг зураг ашигласан нь дээр байх. Ингэвэл хүчхдүд олон янзын хувилбар гаргаж ирэхэд хялбар болох байх.

Б1: Миний хувьд Сато багшийн гаргасан шарсан төмсний санаа сонирхолтой байлаа. Гэхдээ шууд хэлэхэд шарсан төмсний өнгө ажиглаж шинж чанарын өөрчлөлтийг судлах нь хүчхдийн хувьд нэлээн хүнд даалгавар болно.

Б 4: Тиймээ. Мөн хүчхдүд энэ ажиглалтаас шугаман хамаарлыг олж харж чадахгүй байх вий гэдгээс болгоомжлох хэрэгтэй...

Ийм яриа, хэлэлцүүлэг Японы олон сургууль дээр явагддаг байна. Энэ нь “хичээлийн судалгаа” гэж нэрлээд байгаа, Япон багш нар багшлахуйн чанар болон сурагчдын суралцах үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд хэрэглэдэг үйл ажиллагаа байсан билээ. Хичээлийн судалгаа нь зөвхөн хамтарч хичээлийн төлөвлөлт хийхээс гадна энэ хичээлээ ажиглах нээлттэй хичээл явуулж, ажиглалтын үр дүнгээ дараа нь хэлэлцэх үйл ажиллагааг хамардаг байна.

¹ Clea Fernandez, Makoto Yoshida. ‘Lesson study: A Japanese Approach to Improving Mathematics Teaching and Learning’

2.1 Хичээлийн судалгааны товч түүх

Хичээлийн судалгаа нь XIX зууны сүүл үеэс эхэлсэн. Тэр үеэс эхэлсэн Японы боловсролын түүхийн талаар товчхон танилцуулж байна.

1. Ганцаарчилсан сургалтаас танхимын сургалт хүртэл:

Багшлах арга зүйд суралцсан нь

260-аад жилийн өмнө ангийн систем ноёрхож байсан Edo²-гийн үеийн дараагийн үе болох Meiji³-ийн үеийн засгийн газар 1868 онд орон даяар сүмийн сургуулиудыг олноор нээж, харц ардын хүүхдүүдийг бичиг үсгийн боловсрол болон математикт сургаж эхэлжээ. Өмнө нь сүмд зөвхөн самурай нарын хүүхдүүд сурдаг байжээ. Edo-ийн сүүл үед худалдаа наймаа цэцэглэж, ангийн систем задран унасан ба энэ үеийн боловсрол, сургалтаар ажилд ороход шаардлагатай хувийн мэдлэг, чадвар олгоход анхаарч байв. Энэ үеэс сүмийн сургуулиуд олноор байгуулагдаж эцэг эхчүүд хүүхдүүдээ сайн дураар сургуульд явуулах болсон ба Edo-ийн сүүл үе гэхэд эрэгтэйчүүдийн 43%, эмэгтэйчүүдийн 10% нь бичиг үсэгтэй болж Япон улс дэлхийн хамгийн боловсролтой орны тоонд орох болжээ.

1872 онд Meiji-ийн засгийн газар “Боловсролын хууль” гаргасан ба Токио хотод анх удаа багшийн сургуулийг байгуулжээ. Өрнөдийн орнуудтай харилцаагаа сайжруулах, тэдгээр улс орноос суралцахын тулд засгийн газар гадаадын багш нарыг өрнөдийн хичээлүүдийг заахаар урьж байв. Гадаадын багш нар өрнөдийн орнуудад дэлгэрээд байгаа танхимын сургалтыг багшийн сургуульд танилцуулсан байна.

Өмнө нь зөвхөн хувийн, ганцаарчилсан сургалт явуулж байсан Япон багш, сурагчид багшийн сургуулиас зөвхөн хичээлийн мэдлэг, чадвар сурахаас гадна багш нарынхаа хичээл зааж буй байдлыг ажиглаж, багшлах аргад мөн суралцаж байв.

Гадаад багш нар зөвхөн хичээл заахаас гадна багшлах аргыг зааварчилсан сурах бичгүүд бичдэг байжээ. Бүлгээр ажиллуулах загвар (танхимын сургалт)-ын хичээл Токиогийн багшийн сургуулиас эхлэн орон даяар бусад багшийн сургуулиудад тархаж эхлэв. Гэвч 1880 онд эдийн засаг, санхүүгийн хүндрэлээс шалтгаалан Токиогийн багшийн сургуулиас бусад багшийн сургуулиудыг бүгдийг хаажээ. Гэсэн хэдий ч багшийн сургуулийн ажилласан 10 жилийн хугацаанд бүлгээр хичээллэх туршлага нь багшийн сургуулийн төгсөгчид, хуйлмал зургууд, сурах бичгүүдээр дамжин улс даяар түгэн дэлгэрсэн байна.

2. Токиогийн багшийн сургуулиас бага сургуулиуд руу хичээлийн судалгааны туршлага түгэн дэлгэрсэн нь

Японд орчин үеийн сургуулийн тогтолцоо бүрэлдэн буй болж эхэлсэн 1871 оноос хойш аажмаар төрийн хяналт, нэгдсэн удирдлагын тогтолцоо бэхжиж иржээ. 1886 онд бага сургуулийн тухай тушаал гарч, бага сургуулиуд эзэн хаанд үнэнч ард иргэдэд боловсрол олгох сургалтын төвийн шинжийг хүчтэй илтгэх болсон байна. 1880 он гэхэд бүлгийн хэлбэрээр хичээл заах талаарх судалгаа, түүний хэрэгжилт нэлээн өндөр түвшинд очсон ба гадаад орнуудад суралцахаар явсан хүмүүс эргэж ирэн, багшийн сургуульд багшаар ажиллаж байсан төдийгүй мөн бага сургуулиудад уригдан ажилладаг байв. Энэ үед мөн “Pestalozzi-ийн Туршлагад чиглэсэн багшлах арга зүй” гэх мэт арга зүйн номууд хэвлэгдэн гарч эхэлжээ. Энэ номд сургалтын хэрэглэгдэхүүн, хичээлд ажиглалт хийх заавар болон хэлэлцэх заавар зэргийг багтаасан байна. Боловсролын Яамны зааврын дагуу энэхүү арга

² Японы түүхийн 1603-1868 он хүртэлх үе

³ Японы түүхийн 1868-1912 он хүртэлх үе

зүй нь нийт Япон даяар загвар болон хэрэглэгдсэн байдаг. Энэ нь хичээлийн судалгааны эхлэл болжээ. Засгийн газраас хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны багийн идэвхтэй үйл ажиллагааны дүнд хичээлийн судалгааны эхлэл болсон нээлттэй хичээлээр дамжуулан багшлах шинэ арга зүй болон шинэ хөтөлбөр боловсруулан хөгжүүлж эхэлжээ. Meiji-гийн үеэс эхлэн өнөөг хүртэл явагдаж буй уламжлал болсон үндэсний хэмжээний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үеэр 100 ажиглагч багштай судалгаат хичээл, бүр 1200 ажиглагчтай судалгаат хичээл хүртэл зохион байгуулдаг. Энэ тохиолдолд судалгаат хичээлийг театрын тайзан дээр зохион байгуулж ажиглагч багш нар үзвэр үзэж буй мэтээр ажиглалт хийдэг байна.

Улс орон хөгжихийн хирээр бага сургуульд элсэн орох, төгсөх боломж хүн бүрт бий болжээ. 1920-иод оны үеэс John Dewey⁴-ийн боловсролын философид үндэслэсэн шинэ арга зүй хөгжиж эхэлсэн ба засгийн газрын бус хэвшлийн сургуулиуд өөрсдийн арга зүйг нэвтрүүлж эхэлсэн байна. Энэ үед шинэ арга зүй нь суралцахуйг сайжруулах, хөгжүүлэхийг санал болгож байлаа. (Зураг-4).

Энэ нь сурагчдад өөрсдөө суралцах асуудлаа тодорхойлоод бусадтайгаа хэлэлцэн судлах асуудлаа сонгох хэлбэртэй байжээ. Ингэж сонгох нь өнөөдрийн дэлхий нийтээр анхаарч буй конструктив арга зүйн загвар болсон асуудал шийдвэрлэхэд чиглэсэн багшлах арга зүйг хөгжүүлэх эхлэл болжээ. Дэлхийн II дайны дараа багш нарын холбоо хичээлийн судалгааны талаар багш нарын дунд халуун хэлэлцүүлэг эхлүүлсэн. Багшлах арга зүй нь өмнөх мэдлэгээ хэрэглэн шинэ мэдлэг бүтээх, асуудал шийдвэрлэх (бодлого бодох)-д чиглэж байлаа.

1920-1930 онд хүүхэд төвтэй тогтолцоо, сурагчийн үйл ажиллагаанд анхаарал хандуулсан сургалтыг зохион байгуулж байсан боловч, удалгүй цэргийн дэглэм ноёлох болсноор бага боловсролд ч үндсэрхэг үзлийн шинж чанар давамгайлж ирсэн.

Энэ цаг үеийн хичээлийн судалгаа нь Японы Улсын хэмжээнд нэгдсэн нэг боловсролын агуулгыг дэлгэрүүлэх үүрэг гүйцэтгэсэн гэж болно. Өөрөөр хэлбэл, хичээлийн судалгаа нь их хэмжээний мэдлэгийг хүүхдэд үр өгөөжтэй дамжуулах аргыг түгээн дэлгэрүүлж байжээ. Мэдээж зарим бага сургуулиуд багшийн бие даасан шийдвэр болон сонголтыг хүндэтгэн үзсэн хичээлийн судалгааг ч зохион байгуулж байсан ч цэргийн дэглэм ноёлсноор арга буюу орхиход хүрчээ.

1945 онд дэлхийн II дайнд ялагдал хүлээсэн Япон Улс ардчилсан тогтолцоонд шилжин орлоо. Хатуу чанд баримтлах ёстой сургалтын агуулга хэмээн бодож байсан боловсролын стандарт ч шинэчлэгдэн, сургуулиуд чөлөөтэйгээр киррикулүмээ боловсруулах болсон байна. Харин 1958 онд дахин багш нарт боловсролын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэжээ.

Энэ мэт нөхцөл байдал дунд сургуулийн түвшинд “Юуг яаж заах вэ?” гэдгээ судлах, боловсролын стандарт болон сурах бичигт шүүмжлэлтэй хандах завшаан тохиох болж, 1950-1960 онд янз бүрийн хувийн хэвшлийн боловсролын судалгаа шинжилгээний байгууллагууд бий болж, хичээлийн судалгааг түлхүү зохион байгуулж эхэлжээ. Мөн үндэсний хэмжээний хичээлийн судалгааны нийгэмлэг (1962 он) болон Боловсролын арга зүйн үндэсний нийгэмлэг (National Association for the Study of Educational Methods, 1964 он) байгуулагдаж, эдгээр боловсролын судалгаа шинжилгээний байгууллагуудын туршлага солилцоо, судалгаа шинжилгээний хамтын ажиллагааны тогтолцоог бий болгоход хувь нэмрээ оруулсан байна. Тухайлбал, адил хичээлүүдийг хооронд нь харьцуулах, сурах бичигт шүүмжлэлтэй хандах судалгаа явуулах зорилготой хичээлийн судалгаануудыг зохион байгуулж байлаа. Эдгээр судалгааны үр дүнг жилд нэг

⁴ Америкийн философич, психологич (1859-1952)

удаа хичээлийн судалгааны тайлангийн хурал дээр танилцуулж, тайлан эмхтгэл хэвлэн гаргах болсон.

Нөгөөтэйгүүр 1970 оноос хойш төрийн байгууллагуудын зүгээс ч хичээлийн судалгааг хөхиүлэн дэмжих болов. Дэлхийн II дайны дараа, багш бэлтгэх сургуулиудаас бусад ердийн их дээд сургуулиуд ч багшийн эрх олгох болсноор багш нараас багшлах ур чадвараа улам бүр дээшлүүлэхийг шаардах болжээ. Боловсролын зөвлөлийн зохион байгуулдаг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт болон сургууль дээрх сургалтуудад хичээлийн судалгааг ашиглах болсон байна.

Түүнчлэн БШУЯ-ны судалгаа шинжилгээ хийх сургуулийн тогтолцоо, Боловсролын бодлогын үндэсний хүрээлэн болон Хот мужийн боловсролын зөвлөл зэргээс хэрэгжүүлдэг судалгаа шинжилгээ хийхээр заагдсан сургуулийн тогтолцоо ч хичээлийн судалгааг хөгжүүлэх хүчин зүйл болж байна. Судалгаа хийх сургуулиар сонгогдсон тохиолдолд холбогдох байгууллагууд зөвлөгөө өгөх, судалгааны зардал төсөв нэмж олгох болсон зэргээр сургуульд суурилсан хичээлийн судалгааг хөхиүлэн дэмжих болсон.

Ийм маягаар хичээлийн судалгаа нь хэн ч хийж болох, тодорхой үр дүн гарахуйц хэлбэрээ олжээ. 1990-ээд он гарахад, хичээлийн судалгаа нь “Lesson Study” гэдэг нэрээр дэлхийд танилцуулагдан эдүгээ олон улсад эрчимтэй зохион байгуулагдаж байна. Нөгөө талаар, Японы хувьд хичээл зохион байгуулах арга, судалгааны аргачлалд өөрчлөлт орохгүй байна гэх мэтийн судалгаа зогсонги байдалд орох, сургууль багш нарын доороосоо санаачлагатай хамтын ажиллагаа багасах, ээлжит хичээлийг сайжруулах төдийхнөөр сургуулийн шинэчлэлтэй холбогдож өгөхгүй байх зэрэг сургуулийн түвшний тулгамдсан асуудлууд ч тулгарсаар байгаа юм.

Ашигласан материал:

- Сайто Ясүо (SAITOH Yasuo) “Японы боловсролын хөгжлийн түүх (The History of Japanese Educational Development)” 2007 он
- Японы боловсролын арга зүйн эрдмийн зөвлөл “Японы хичээлийн судалгаа (Lesson Study in Japan)” 2009 он
- Михаши Коичи (MIHASHI Koichi) “Японы хичээлийн судалгааны гарал үүслийн зураглалын тойм” “Японы хичээлийн судалгааны арга зүйн системчлэл ба гарал үүслийн хөгжлийн судалгаа (Development Research on Genealogy and System of Methodology in Research on Teaching in Japan)” 2003 он
- Мурата Ёкүо (MURATA Yokuo), Ямагүчи Мицүрү (YAMAGUCHI Mitsuru) “Хоёр хэл дээрх бичиглэл: Орчин цагийн Япон хэлний боловсрол <Тогтолцоо ба агуулга>” Тошиндо, 2010 он

3. Хичээлийн судалгаа АНУ-д түгэн дэлгэрсэн нь

Хэдхэн жилийн өмнө гэхэд Америкт хичээлийн судалгааны талаар юу ч мэддэггүй байв. Энэ тухай James Stigler, James Hiebert нар “The Teaching Gap: Best Ideas from the World’s Teachers for Improving Education in Classroom” (1999) бүтээлдээ дурдсан байдаг. Одоо бол Америкийн багш нар тэднийг хамтран ажиллах, туршлага хуваалцах, ялангуяа нэгнийхээ хичээлийг ажиглах боломж олгосон энэ аргыг маш ихээр сайшааж байгаа. Япон багш нар энэхүү мэргэжлийн үйл ажиллагаандаа дуртай бөгөөд ихэнх багш нар нь үүнгүйгээр өөрийгөө төсөөлөхгүй болсон байгааг бид мэдэж байна” гэсэн байдаг. 1990-ээд оны эхэн үед Макото Ёшида Чикагогийн их сургуульд Япон, Америкийн математикийн сургалтын харьцуулсан судалгааны чиглэлээр хийсэн Ph.D-ийн ажилдаа Японы хичээлийн судалгааг авч үзжээ. Тиймээс түүнийг АНУ-д Японы хичээлийн судалгааг танилцуулсан хүн гэж хүлээн зөвшөөрдөг. Тэрээр Ph.D-ийн судалгааны ажилдаа Японы “jogyokenkyu” хэмээх


үгийг англи дээр “lesson study” гэж орчуулан хэрэглэсэн байдаг.

АНУ-д хичээлийн судалгааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтдийн нэг нь Mills-ийн коллежийн профессор Катерин Льюис (Catherine Lewis) юм. Тэрээр 1995 онд хэвлүүлсэн “Educating Hearts and Minds” номдоо хичээлийн судалгааны талаар анх дурдсан байдаг. Унаган япон хэлтэй Катерин Льюис 1996 оноос Японы байгалийн ухааны боловсролын өөрчлөлт шинэчлэлийг судалж эхэлсний дотор хичээлийн судалгаа томоохон байр суурь эзэлдэг. Өдгөө Catherine Lewis АНУ болон Японд хичээлийн судалгаа хийж удирдсан 25 жилийн туршлагатай томоохон эрдэмтдийн нэг юм.

1999 оны намар Фернандез, Ёшида нар хамтран Грийнвич дэх Япон сургууль болон Нью Жерси мужийн Патерсоны 2-р сургууль дээр анхны хичээлийн судалгааны хамтарсан багийг удирдан ажиллуулж эхэлсэн. Улмаар хичээлийн судалгааны олон багууд ажиллах болжээ. Үүнд:

- 2000 оны 5 сар – Колумбийн багшийн коллежийн хичээлийн судалгааны судлаачдын баг, Грийнвич дэх Япон сургууль хамтран Paterson-ий сургууль дээр анх удаа олон нийтэд зориулсан том хэмжээний нээлттэй хичээлийн судалгааг зохион байгуулсан байна. АНУ-ын New Jersey-ийн математикийн багш нар жил бүр ийм уулзалтыг зохион байгуулдаг болсон байна.
- 2000 оны 9 сар – мужийн хэмжээний хичээлийн судалгааны анхны санаачлагыг Delaware-д эхлүүлсэн.
- 2000 оны 9 сар – Дүүргийн хэмжээний хичээлийн судалгааны анхны санаачлагыг Вашингтоны Bellevue сургуулийн дүүрэг 5 гаргажээ.
- 2000 оны 11 сар – Фернандез, Ёшида нарын хичээлийн судалгааны судлаачдын баг, Грийнвич дэх Япон сургуультай хамтран хичээлийн судалгааны анхны үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан байна.

АНУ дахь хичээлийн судалгааны хамрах хүрээ 2002-2004 онд хэрхэн өргөжин тэлснийг дараах зургаас харж болно.



⁵ Bellevue сургуулийн дүүрэг нь нийт 4 ахлах, 5 дунд, 15 бага сургуультай.

4. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (JICA)-аас боловсролын салбарт хэрэгжүүлж буй "Хичээлийн судалгаа"-г ашигладаг төслүүд

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллагаас Бүх нийтийн боловсрол (EFA) болон Дакарийн тунхаглалд нийцүүлэн суурь боловсролын дэмжих дараах гурван үндсэн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

	Чиглэл	Үйл ажиллагаа
1	Бага, суурь боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх	Буцалтгүй тусламжаар сургуулийн барилга барих, олон нийтийн оролцоот сургуулийн удирдлага менежментийн тогтолцоо бүрдүүлэх г.м.
2	Бага, суурь боловсролын чанарыг дээшлүүлэх	Суралцагч төвтэй багшлахуй арга зүйг дэмжих, багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах, сурах бичиг болон багшлахуй гарын авлага боловсруулах, ханган нийлүүлэх г.м.
3	Боловсролын менежментийг сайжруулах	Сургуулийн менежментийн хүний нөөцийг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн боловсрол болон албан бус боловсролын нөөц г.м.

“Хичээлийн судалгаа” нь бага, суурь боловсролын чанарыг дээшлүүлэх, мөн хичээлийн түвшинд бодит практик дээр багш мэргэжлээ дээшлүүлэх чухал арга хэрэгсэл болдог. Түүнээс гадна, хичээлийн судалгаа нь лекцийн хичээл заах профессор багш, том өрөө танхим, тусгай тоног хэрэгсэл шаарддаггүй, хамт ажилладаг багш нартайгаа ажлын байран дээрээ зохион байгуулах боломжтой учраас бусад мэргэжил дээшлүүлэх сургалттай харьцуулбал зардал бага шаарддаг. Тиймээс ЖАЙКА-аас хөгжиж буй улсуудад хэрэгжүүлж буй боловсролын чанарыг дээшлүүлэх төслийн тогтвортой байдлыг хангахад “Хичээлийн судалгаа”-г хэрэглэж байна.

“Хичээлийн судалгаа”-г хэрэгжүүлдэг ЖАЙКА-ийн төслүүд

	Улс	Төслийн нэр	Хугацаа	Түвшин	Хамрах хүрээ
Ази	Филиппин	Филиппин улсын бага, суурь боловсролын математик, байгалийн ухааны багшийн сургуульд суурилсан тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалтыг бэхжүүлэх нь	2002 - 2005	Бага, суурь боловсрол	All schools in several provinces
	Индонез	- Индонез улсын бага, суурь боловсролын математик, байгалийн ухааны багшлахуйг хөгжүүлэх нь (IMSTEP) - IMSTEP төслийн үргэлжлэл - Математик, байгалийн ухааны багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт - Ахлах сургуулийн боловсролын чанарыг сайжруулах нь	1998 - 2013	Суурь боловсрол	7 provinces (1,277 schools)
	Камбож	Байгалийн ухааны багшийн боловсрол	2008 - 2012	Суурь боловсрол	1 хот, 2 мужийн зарим сургууль
	Вьетнам	Project for Strengthening Cluster-Based Teacher Training and School Management	2004 - 2007	Бага боловсрол	1 мужийн зарим сургууль
	Лаос	- Математик, байгалийн ухааны багшийн сургалтыг боловсронгуй болгох нь - Southern мужийн бага боловсролыг хөгжүүлэх олон нийтийн санаачлагыг дэмжих нь - Математик, байгалийн ухааны багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг боловсронгуй болгох нь	2004 - 2013	Бага боловсрол	3мужийн зарим сургууль
	Пакистан	Суралцагч төвтэй Inquiry-д суурилсан байгалийн ухааны боловсролыг дэмжих нь	2009 - 2012	Бага, суурь боловсрол	Нийслэлийн зарим сургууль
	Бангладеш	- Математик, байгалийн ухааны бага ангийн багшийн сургалтыг бэхжүүлэх нь - Багш бэлтгэх сургуулийн дидактикийн мэргэжлийн хүний нөөцийг бэхжүүлж хичээлийн чанарыг дээшлүүлэх нь	2004 - 2016	Бага боловсрол	7 хотын зарим сургууль
Өмнөд Америк	Болив	Бага сургуулийн боловсролын чанарыг сайжруулах нь	2003 - 2010	Бага боловсрол	Янз бүрийн бүсийн 150 орчим сургууль

Африк	Гана	- Мэргэжилдээшлүүлэх сургалтын бодлогын хэрэгжилтийг дэмжих нь - Багш бэлтгэх сургалтын менежментийн хүний нөөцийг бэхжүүлэх нь	2005 - 2013	Бага боловсрол	170 дүүрэг
	Мозамбик	Gaza мужийн бага боловсролыг бэхжүүлэх нь	2006 - 2009	Бага боловсрол	1 мужийн бүх сургууль
	Замби	- SMASTE ⁶ - сургуульд суурилсан тасралтгүй мэргэжил дээшлүүлэх нь төсөл - SMASTE - сургуульд суурилсан тасралтгүй мэргэжил дээшлүүлэх нь төсөл-2 - Сургуульд суурилсан тасралтгүй мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрөөр багшийн ажлын гүйцэтгэл, чадварыг бэхжүүлэх нь	2005 - 2015	Бага, суурь боловсрол	9 муж
	Өмнөд Африк	Mpumalanga мужийн байгалийн ухааны суурь боловсролын санаачлага	1999 - 2006	Суурь боловсрол	1 мужийн бүх сургууль



Индонезийн судалгаат хичээл



Пакистаны ХС-ны хэлэлцүүлэг

5. Хичээлийн судалгааны дэлхийн нийгэмлэг (WALS) ба хичээлийн судалгааны санал санаачлага

Хичээлийн судалгааны дэлхийн нийгэмлэг (The World Association of Lesson Studies-WALS) нь багшлахуй, суралцахуйн чанарыг дээшлүүлэх зорилт бүхий ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ практик үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээ-судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилготой 2000 оны эхэн үед байгуулагджээ. Үүсгэн байгуулагчид нь Австрали, Хонг Конг, Хятад (Шанхай, Бээжин), Япон, Сингапур, Швед, Их Британий нэгдсэн Вант улс, АНУ зэрэг улсын хичээлийн судалгааны чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийдэг боловсролын салбарын судлаачид байдаг. Энэхүү олон улсын нийгэмлэг нь судлаачдын хамтран ажиллах, харилцан туслах, мэдээлэл солилцох боломж олгодог. ХСДН-ээс жил бүр зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний хурал нь улс орнуудын боловсрол судлаачид, сургуулийн захирал, сургалтын менежер, багш нарыг нэгэн дор цугларч

хичээлийн судалгааны талаар харилцан туршлага солилцох, хамтдаа хөгжих, мөн урт хугацааны хөгжлийн хэтийн чиг хандлагын талаар хэлэлцэх өргөн боломжийг олгодог. ХСДН-ийн олон улсын жил бүрийн хурлыг 2007-2009 онд Хонг Конг, 2010 онд Бруней Даруссалам, 2011 онд Япон, 2012 онд Сингапурт тус тус зохион байгуулагдсан байна. Хичээлийн судалгаа болон хичээлийн судалгаагаар багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэх талаарх судалгааны дараах чиглэлүүд хөгжиж байна. Үүнд:

- Хичээлийн судалгаагаар суралцагчийн суралцахуйг гүнзгийрүүлэх (Deepening Student Learning through Lesson Study)
- Хичээлийн судалгааг дэмжих түншлэл (Partnerships to Sustain Lesson Study)
- Хичээлийн судалгаанд суурилсан сургуулийн реформ ба суралцахуйн хамтын нийгэмлэг (Learning Communities and School Reform through Lesson Study)
- Хичээлийн судалгаа, сургалтын хандлагыг дэмжсэн хэрэглэгдэхүүн болон артефактыг боловсруулах (Developing Tools and Artefacts for supporting Lesson Study and Instructional Approaches)

2011 оноос эхлэн боловсрол судлалын судалгаа, шинжилгээний мэргэжлийн “Хичээлийн болон суралцахуйн судалгааны олон улсын сэтгүүл” (**The International Journal for Lesson and Learning Studies - IJLLS**) хэвлэгдэж хичээлийн судалгаа болон суралцахуйн судалгааны талбарт хийгдсэн төрөл бүрийн судалгааны дүнг нийтэлж байна (<http://www.emeraldinsight.com/journals.htm?issn=2046-8253>).

Хичээлийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон олон улсын түвшний байгууллага, төсөл хөтөлбөрийн цахим хуудаснаас шинэ шинэлэг мэдээлэл авч, манай орны нөхцөлд хэрэглэх боломжтой туршлага сургамжийг судлаарай.

№	Цахим хуудас
1	http://www.rbs.org/Special-Topics/Lesson-Study/22/
2	http://www.lessonresearch.net/
3	http://www.tc.columbia.edu/lessonstudy/
4	http://www.lessonstudygroup.net/
5	http://lessonstudy.co.uk/
6	http://www.criced.tsukuba.ac.jp/math/apec/
7	http://www.lsalliance.org/
8	http://lessonnote.com/

Хичээлийн судалгаа - Монголд хэрэгжиж эхэлсэн түүх

2006-2009 онд БСШУЯ, JICA-ийн хамтран хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах арга зүйн хөгжил” төсөл нь Монголд анх хичээлийн судалгаа хийж эхлэх үндэс болсон. Тус төслийн хүрээнд 2006 оны намар хими, физик, математик бага, математик дунд, мэдээлэл зүй, төсөлт ажил, хүн байгал, хүн орчин зэрэг мэргэжлээр 10 судлаач Японы Токиогийн Гакүгэй Их сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. Энэхүү сургалтаар анх хичээлийн судалгааны талаар сонсож, Японы бага ангийн хичээлийн судалгааны үйл явцыг ажиглаж, суралцаж ирсэн. Тус төслийн хүрээнд дээрх хичээлүүдээр эхний жил Улаанбаатар хотын 45, 97, Сэтгэмж сургуулиудад анхны хичээлийн судалгааг хийж эхэлжээ. Энэ төслийн 3 жилийн хугацаанд ЕБС-ийн багш нар төдийгүй мэргэжлийн багийн судлаач багш нар хамтран хичээлийн судалгаа хийх үйл явцад суралцсан. Энэ үйл ажиллагаанд Гакүгэй Их Сургуулийн багш нарын зөвлөгөө ихээхэн үүрэг гүйцэтгэж байсныг дурдах нь зүйтэй. Төслийн хоёр дахь жилээс

төслийн загвар аймаг болох Сэлэнгэ, Дорнод аймгуудад хичээлийн судалгаа хийж эхэлсэн нь хөдөө орон нутагт хичээлийн судалгаа хийж эхэлсэн анхны үйл явдал болж байлаа.

Өдгөө тус төслийн үргэлжлэл “Багшлахуйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд үндэсний болон бүсийн хэмжээни сургалтууд удаа дараалан явуулж хичээлийн судалгааг нийт улс орон даяар хийж эхлээд байна. Ийнхүү Монголд анх хичээлийн судалгаа хийж эхэлж айсан хугацаа саяхан боловч хичээлийн судалгаа хийх сонирхолтой сургууль, багш нар олширч байгаа нь хичээлийн судалгааны цаашдын хөгжилд ирээдүй байгаа харуулж байна.

2.2 Хичээлийн судалгаа

1.Хичээлийн судалгааны үйл явц

Хичээлийн судалгаа нь:


1. Бэлтгэл (*preparation* - kyozaï kenkyu),
2. Бодит хичээл буюу хичээл заах, ажиглах (*actual class-koukai/kenkyu* jyuugo),
3. Хэлэлцэх, сайжруулах (*class review sessions* - jyuugo kentoukai) гэсэн гурван үе шаттай.

Бэлтгэл судалгаа хэсэгт үндэсний хөтөлбөр, сурах бичиг гэх мэт хөтөлбөрийн агуулгыг хичээлийн хөтөлбөрт тусган төлөвлөх үйл ажиллагаа хийдэг. Энэ үйл ажиллагаа нь хичээлийн зорилго, бүтэц хэлбэр, сурагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн материал (сургалтын хэрэглэгдэхүүн)-ыг сонгох эдгээр элементүүдийг хичээлийн хөтөлбөрт төлөвлөхөөс эхэлнэ.

Үүний дараа хөтөлбөрөөр хичээл заана. Энэ хичээлд бусад багш нар ажиглалт хийдэг ба заримдаа их дээд сургуулийн зөвлөх багш нар, боловсролын газрын арга зүйчид уригдан оролцдог.

Ажиглалтын дараа тухайн хичээл, хөтөлбөрийг хэлэлцэн сайжруулах талаар санал солилцоно. Энэ процессийг Диаграм-1-ээр үзүүлэв.

(1)-ээс (4) дүгээр алхам нэгдүгээр шатанд хамаарах бөгөөд (4) дүгээр алхамд хийсэн хэлэлцүүлгийн үр дүнг ашиглан (5)-аас (7) дугаар алхам буюу хоёрдугаар шатанд хичээлийг дахин боловсронгуй болгоно.



(1)Асуудлаа тодорхойлох, (2)Хичээлээ төлөвлөх, (3)Хичээл заах, (4)Хичээлээ хэлэлцэх, (5)Хичээлийг дахин сайжруулах, (6)Сайжруулсны дүнд дахин хичээл заах, (7)Үнэлгээ, дахин хэлэлцэх, (8)Үр дүнг тайлагнах, хуваалцах

Ажиглагчдад хичээлээс өмнө хичээлийн төлөвлөгөөг танилцуулсан байх ба уг төлөвлөлтөд хичээлийн үе шат бүрт хичээлийн хэрэглэгдэхүүн болон суралцагчдын төлөв байдлыг тодорхой тусгасан байдаг. Мөн бодлого тус бүрийн мөн чанар болон хичээл дээр явагдах үйл ажиллагааг тайлбарласан байна.

Хичээлийн дараах хэлэлцэх, сайжруулах шатанд багш хичээлийн талаар товч танилцуулж, хичээлийн зорилгыг тайлбарладаг. Үүний дараа бусад оролцогч өөрсдийн багшлахуйн туршлагад тулгуурлан санаагаа илэрхийлэх ба хичээл дээр өгөгдсөн бодлого, багшийн үүрэг, суралцагчдын санаагаа тайлбарлаж буй байдал, суралцахуйн үйл ажиллагааны талаар асуулт асууж хэлэлцэнэ.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь хичээлийн зорилго болон хичээлийн бодит үйл явцын хоорондын ялгаанд тулгуурлан хичээлийн төлөвлөлтийг хөгжүүлж, сайжруулахад чиглэнэ.

Хэлэлцүүлгийн үед хичээл дээр болон хичээлийн бэлтгэл судалгааны үед авч үзээгүй шинэ сэдэв, бодлогыг нээх, хөгжүүлэх нь багшийн чухал чадваруудын нэг болно.

1. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх түвшин

Хичээлийн судалгаа нь олон багшийг хамруулах үйл ажиллагаа боловч хэрэгжүүлэх түвшин, зохион байгуулагч нь янз бүр байдаг. (хүснэгт-1).

Хүснэгт-1

	Түвшин	Үндсэн зохион байгуулагч	Тайлбар
	Сургууль	Сургуулийн удирдлага, багш нар	Энэ нь үндсэн хэлбэр бөгөөд сургууль төвтэй, багш нар ажлын байран дээрээ хөгжих, мэргэжил дээшлүүлэх боломжийг олгоно.
	Аймаг, дүүргийн судалгааны баг	Аймаг, дүүргийн ЕБС-ийн багш нарын баг	Сайн туршлагатай багшийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх гэх мэт
	Аймаг, дүүргийн судалгааны баг	Боловсролын газар, ХС-ны аймаг, дүүргийн баг	Аймаг дүүргийн хэмжээний мэргэжил дээшлүүлэх сургалт, туршлага солилцох гэх мэт
	Нийт улс	Их дээд сургуулийн харьяа сургуулийн багш удирдлага	Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт
	Нийт улс	Хувийн байгууллага (нийгэмлэг, холбоо, сурах бичгийн компани, судалгааны төв)	Судалгааны зорилготой хичээлийн судалгаа

Хамгийн ерөнхий түвшин нь сургууль төвтэй хичээлийн судалгаа юм. Энэ түвшинд тухайн ангид хичээл заадаг багш өөрөө хичээл заах боломжтой боловч зарим тохиолдолд, тухайлбал, багш нарын хамтын судалгааны үед өөр багш тухайн ангид хичээл зааж болдог.

Бусад түвшний хичээлийн судалгаа нь ихэвчлэн холбоо, нийгэмлэг, судалгааны сайн дурын багийн үйл ажиллагаанд тулгуурладаг. Энэхүү олон түвшний

хичээлийн судалгаа нь Японы боловсролын хөгжил, боловсролын чанарт чухал нөлөө үзүүлсэн үндсэн хүчин зүйлүүдийн нэг юм.

Сургуулийн түвшний хичээлийн судалгааны чиглэлээ тогтоохын тулд сургуулийн бүх багш нарын уулзалт зохион байгуулдаг бөгөөд уг уулзалтаар багш нар сурагчдын суралцахуйн өнөөгийн төлөв байдал, суралцахуйд гарч буй доголдол, бэрхшээл, өөрсдийн дэмжлэг, туршлага зэргийг хэлэлцэн санал солилцоно. Үүний үр дүнд багш нараас сурагчдын суралцахуйг хөгжүүлэх ерөнхий чиглэлүүд гаргадаг байна.

Жишээлбэл: Японы Хирошима хотын “Цута” хэмээх бага сургууль хичээлийн судалгааны чиглэлээ тодорхойлохын тулд дээрх байдлаар хэлэлцүүлэг хийсэн ба хэлэлцүүлгийн үр дүнд:

“Манай сургуулийн сурагчид, хөгжилтэй, баяр баясгалантай, дуулгавартай, суралцах маш их урам зоригтой. Гэвч тэд нэг асуудлыг гүн гүнзгий анхаарах, бусад сурагчийнхаа тайлбарт анхаарал хандуулах, сонсох чадвар муу, бусад сурагчийн шүтмэлийг хүндэтгэн хүлээн зөвшөөрдөггүй. Ялангуяа 5 ба 6 дугаар ангийн сурагчид бусад сурагчдынхаа өмнө алдаа хийх, алдаа гаргахаас улам ихээр айдаг болж байна. Үүнээс шалтгаалаад тэд суралцах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хүсэл сонирхолгүй болж байна” гэж дүгнэжээ. Иймд хичээлийн судалгааны багийнхан судалгааны чиглэлээ “Сурагчдын өөрийнхөөрөө бодож, сэтгэх чадвар, нээлт хийх, бие биенээсээ суралцах чадварыг дэмжих” гэж тодорхойлж авч үзсэн байна.

Энэ сэдвийг тухайн хичээлийн онцлогт нийцүүлэн дэд зорилго тодорхойлжээ. Тухайлбал математикийн хичээлээр: “Сурагчдын бие даан сэтгэх, бодох чадварыг дэмжих, математикаар асуудал шийдвэрлэх сэдвийн дор бие биеэсээ суралцах, шинэ санаа олох” гэж тодорхойлсон байна.

Энэ сэдвийг сонгож хичээлийн судалгааг амжилттай хийснээр тус сургуулийн багш нар тэд сурагчдын суралцах хүсэл сонирхол хэрхэн өсөн нэмэгдэж буй, бусад сурагчийн алдаанаас хэрхэн суралцаж буй, бүх сурагчдын амжилтыг мэдэрч буй баяр баясгаланг мэдэрсэн байна.

2. Хичээлийн судалгааны төрөл

Хичээлийн судалгааг зорилго болон хийх зориулалтаар нь нь дараах төрлүүдэд ангилж болно.

1. Шинэ арга зүйг олж судлахад зориулсан
2. Сургалтын зорилготой
3. Туршлагатай багш нар залуу багш нараа сургахад зориулсан
4. Залуу багш нар туршлагатай багш нараасаа санал зөвлөмж авахад зориулсан
5. Ижил түвшний багш нар бие, биеэсээ суралцахад зориулсан

Эдгээр төрөл тус бүрийг товч тайлбарлая.

1. Шинэ арга зүйг олж судлахад зориулсан хичээлийн судалгаа:

Энэ нь их дээд сургуулийн дидактикийн багш, судлаач, ЕБС-ийн багшийн хамтран, судалгааны багийн түвшинд хийх хичээлийн судалгаа юм. Ийм төрлийн хичээлийн судалгааны зорилго нь шинэ арга зүй, шинэ хэрэглэгдэхүүн турших, нээж илрүүлэх, үүний үр дүнд сургалтын шинэ арга зүй, хэрэглэгдэхүүнийг олон нийтийн хүртээл болгоход оршино.

2. Сургалтын зорилготой

Энэ төрлийн хичээлийн судалгаа нь багш нарын мэргэжил дээшлүүлэх янз бүрийн

түвшний сургалт, эсвэл багш нарт үзүүлэх хичээл заах гэх мэт байдлаар хэрэгждэг. Өнөөгийн манай нөхцөлд ийм төрлийн хичээлийн судалгаа нь хэрэгцээтэй байна. Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцогч багшид хичээлийн судалгааны ач холбогдлыг ойлгуулах, мөн хичээлийг ажигласнаар шинэ арга зүй, хэрэглэгдэхүүн, багшлахуй болон суралцахуйн шинэ санаа гэх мэт олон зүйлийг нүдээр үзэж, биеэр мэдрэх боломж олгодгоороо онцлогтой.

3. Туршлагатай багш нар залуу багш нартаа сургах

Энэ нь туршлагатай, тэргүүний шилдэг арга зүйтэй багш нар хичээлийн судалгаа зохион байгуулж, залуу багш нарыг туршлага судлуулах зорилгоор зохион байгуулах төрлийн хичээлийн судалгаа болно. Өөрөөр хэлбэл, судалгаат хичээлийг заах багш нь тухайн хичээлд ажиглалт хийж буй багш нарт арга зүйн туршлага түгээхүйц сайн багш байх хэрэгтэй.

4. Залуу багш нар туршлагатай багш нараасаа санал зөвлөмж авах

Энэ нь залуу багш нар арга зүйгээ хөгжүүлэхийн тулд туршлагатай багш нараас санал, зөвлөгөө авахын тулд зохион байгуулах хичээлийн судалгааны хэлбэр болно. Энэ төрлийн судалгаат хичээлд ажиглалт хийх багш нар нь залуу багш нарт зөвлөгөө өгөх, хичээлийн явц, багшийн болон сурагчийн төлөв байдлын талаар хангалттай зөвлөх чадвартай багш байх хэрэгтэй болно.

5. Ижил түвшний багш нар бие биеэсээ суралцах

Энэ нь багш нар хамтран арга зүйгээ сайжруулах, тухайн сэдвийг заах шинэ арга зүй, хэрэглэгдэхүүн судлах зорилготой хичээлийн судалгааны хэлбэр болно.

2.2.1 Хичээлийн бэлтгэл судалгаа хийх

Хичээлийн бэлтгэл судалгаа - Кюзай Кенкю гэж юу вэ?

Үүнийг галигчилбал Кюзай Кенкю гэх бөгөөд энэхүү Япон үгийг бид хэрэглээд 3 жил гаруй болж байна. Кюзай Кенкю гэдгийг үгчлэн орчуулбал “хэрэглэгдэхүүний судалгаа” гэсэн утгатай үг юм. “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд боловсруулсан зөвлөмжүүдэд үүнийг “Хэрэглэгдэхүүний судалгаа”, “Сургалтын материалын судалгаа”, “Хичээлийн бэлтгэл - хэрэглэгдэхүүний судалгаа”, “Хэрэглэгдэхүүний төлөвлөлтийн судалгаа” гэсэн утгаар бичиж, өөр өөрийнхөөрөө ойлгож хэрэглэж байна. Хичээлийн онцлогоос хамааран Кюзай Кенкю янз бүрийн утгаар илүү хэрэглэгдэж байж болох ч Японы нийгэм ахуй - соёлын түүхэн орчинд төлөвшиж, өөрийн өнгө төрхөө олсон технологийн утга учрыг алдагдуулахвий гэсэн үүднээс энэхүү нэр томъёоны ерөнхий утга учрыг тодруулахыг хичээлээ.

Кюзай кенкю - г сургалтын орчны судалгаа гэж үзэх нь

Японд системтэй боловсролыг хуульчлах болсноор “Сурах бичиг – хичээлийн хэрэглэгдэхүүн – арга зүй”-г нэгэн багц болгосон. Хүүхэд төвтэй сургалтыг чухалчлах болж, хичээлийн судалгаа хүчтэй хөгжиж сургууль бүрт түгэх болжээ. Энд хувь хүний хөгжил ба нийгэмшихүйн орчны харилцааг чухалчлан үзэх болсон.


Юуны төлөө Кюзай Кенкю хийдэг юм бэ? Үндсэн зорилго нь хүүхдийн онцлогийг хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх, албадлагагүй суралцах эрмэлзэл бий болгох багшлах аргазүйг улам сайжруулахын тулд юм. Энэ утгаар судалгааны гол элемент болгож хүүхэд, багш, орчин, хичээлийн хэрэглэгдэхүүнийг авч үздэг [7].

Хүүхэд: Хүчхдийн мэдлэг, чадвар, сонирхол, бие даах чадвар, хүчхэд хоорондын харьцаа, жендерийн асуудал, харилцан суралцах, багаар ажиллах чадвар

Багш: Багшийн харьцаа, хандлага, тавих асуулт, зааварчилгаа, ганцаарчлах ба бүлгээр ажиллуулах чадвар, багш нарын хамтын ажиллагаа, нэгдмэл байдал, харилцан суралцах чадвар

Хэрэглэгдэхүүн: Сурах бичиг, материал, туршилтад хэрэглэх хэрэглэгдэхүүн, асуулт, бодлого. Үүнд байгаль орчин, цйлдвэр аж ахуйн газар, музей зэрэг хамаарна.

Орчин: Материаллаг орчин (Ангийн гэрэлтцүлэг, тохижилт, агааржуулалт, ширээ, сандал, кабинет, цзүцлэн, багаж төхөөрөмж, хувилагч, принтер), сэтгэл зүйн орчин, цүйлийн орчин



Эдгээр дөрвөн хүчин зүйл, тэдгээрийн шүтэн барилдлагаас Кюзай кенкю - гийн гол санаа урган гарах боломжтой. Иймд Кюзай кенкю гэдгийг өргөн утгаар нь сурагчийн төлөвшил хандлагад нөлөөлөх хүчин зүйлүүдийг уялдаа холбоонд нь судлахыг хэлдэг. Жишээлбэл, багшийн бодлоор боловсруулсан хичээлийн хэрэглэгдэхүүн хүүхдийн өнцгөөс ямар харагдах бол, хүүхэд юу бодож өөрийгөө хэрхэн илэрхийлэх бол, хэрхэн үйлийн орчин бүрдүүлэх вэ гэсэн байр сууринаас харж судалж болно.

Хүүхэд, багш, сургууль бүр өөрийн онцлогтой. Сургууль, багш нар Кюзай кенкюг хэлэлцэн сайжруулах арга зүйн үндсэн зарчмуудыг ойлгож, өөрийн онцлогийг тооцон хэрэгжүүлэх ёстой.

Кюзай кенкю - г хичээлийн хэрэглэгдэхүүний судалгаа гэж үзэх нь



Хичээлийг динамик процесс гэж үзвэл оролт-явц-гаралт гэсэн үе шатад хувааж болно. Хичээлийн судалгааны үе шат үүнтэй холбоотой байдаг. Хичээлийн үр дүн оролтын хэсэг буюу хичээлийн бэлтгэлээс голлон хамаарах учраас хичээлийн бэлтгэл судалгааг бие даасан судалгаа гэж үздэг судлаач байдаг. Ингэсэн нөхцөлд хичээлийн бэлтгэл судалгаа нь хичээлийн судалгааны эхний үе шат болно.

Асуудалд бас өөр өнцгөөр хандаж болох юм. Хичээл гэдэг машин руу юу орж, ямар боловсруулалт хийгдэж, ямар бүтээгдэхүүн гардаг юм бэ? Багш та энэ талаар бодлоо тунгаагаарай.

Хичээл дээр мэдлэг бүтээгдэх процесс явагдаж, сурагчдын мэдлэг чадвар, хандлагад өөрчлөлт орж, чанарын ахиц гарах ёстой. Энэхүү танин мэдэх үйл ажиллагааг амжилттай удирдан явуулахын тулд бидэнд энэ хичээлийн агуулгын санааг шингээсэн, сайтар элементарчилагдсан хэрэглэгдэхүүн, түүнийг ашиглаж

танин мэдэх үйлийг удирдах технологи хэрэгтэй. Сургалтын хэрэглэгдэхүүн нь танин мэдэх процесс явуулахад туслах үүрэг гүйцэтгээд хичээлийн гаралт дээр өөрөө үлддэгээрээ химийн урвалын эцэст үлддэг катализатортай төстэй юм. Энэ утгаараа хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэж боловсруулах, ашиглах асуудал өөрөө зангилаа асуудал болж байна. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг хичээлийн өмнө бэлтгэдэг хэдий ч, хэрэглэгдэхүүний асуудал хичээлийн оролт, явц, гаралтад бүгдэд нь хамаатай байна.

Кюзай кенкю - г мөсөн уултай харьцуулах нь байдаг. Мөсөн уулын 90% нь усан доор харагдахгүй байдаг шүү дээ. Үүний адилаар Кюзай кенкюгийн өчүүхэн хэсгийг хичээлийн судалгааны үед харах боломжтой байдаг.


Энэ утгаар нь Кюзай кенкю - г дуурайхад хэцүү, бараг боломжгүй гэж үздэг. Кюзай кенкю тухайн багшийн олон жилийн туршлага, ажиглалт, бүтээлч ажиллагаа, судалгааны үр дүнтэй салшгүй холбоотой байдаг.

Багш тухайн ангийн хүүхдүүдийн онцлог, хичээлийн зорилго, техникийн бодит боломждоо нийцүүлж тухайн хичээлийн хэрэглэгдэхүүнээ сонгодог.

Хэрэглэгдэхүүн нь хичээлийн зорилгыг биелүүлэх хэрэгсэл болдог. Хичээлийн хэрэглэгдэхүүн зорилгоо биелүүлэхэд тусалж чадаж байна уу, үгүй юу гэдгийг микро хүчин зүйлүүдийн уялдаа холбоонд судлах шаардлагатай болдог. Энэ явцуу утгаар нь кюзай кенкю - г хэрэглэгдэхүүний судалгаа гэж ойлгож болдог.

Математикийн хичээлийн хувьд нэг гол хэрэглэгдэхүүн нь бодлого юм. Иймд бодлогын сонголтыг судалгааны чиглэл болгон авч болох юм. Мөн сурагчдын математикийн хичээлийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилго бүхий янз бүрийн дидактик тоглоом, геометрийн дүрсийг сургалтанд нэвтрүүлэх чиглэлээр хичээлийн судалгаа хийж болох юм [5].

Кюзай кенкю - г хичээлийн бэлтгэл судалгаа гэж үзэх нь



Мөсөн уулын 90% нь усан доор оршдог.

Сургалтын хэрэглэгдэхүүнийг хэдийд ямар зорилгоор, хэрхэн хэрэглэх арга зүйг судлах Камата багш Япон төвд болсон 3-р зөвлөмжийн талаарх хэлэлцүүлэг дээр илтгэл тавихдаа Кюзай кенкю бол хичээлийн төлөвлөлтийн судалгаа гэж танилцуулж байсан [7].

Хичээлийг ямар зорилгоор, юуг заах, ямар аргаар заах, ямар туршилт үзүүлэх, хүүхдүүдийн сонирхол хэрэгцээг хэрхэн тооцох, сурагчдаас гарч болзошгүй хариу үйлдлийг тооцох гэсэн асуудлыг уялдаанд нь авч үзэх хэрэгтэй. Иймд сургалтад ямар хэрэглэгдэхүүн хэрэглэх вэ, яаж хэрэглэх вэ? гэдгийг кирикюлимийн бусад элементтэй нягт уялдаатай авч үзэх хэрэгтэй.

Хичээлдээ бэлтгэхдээ, төлөвлөхдөө, хичээлийг явуулахдаа, сурагчдын сэтгэгдэлд, хичээлийн үр дүнд судалгаатай

хандаж яавал сайн хичээл болгох вэ гэдэгт анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Энэ бүх судалгаа эргээд дараагийн хичээлийн бэлтгэлийг хийхдээ судалгааны үр дүнгээ тооцох гэсэн утгаараа хичээлийн бэлтгэл хийхдээ судалгаатай хандах гэсэн санааг агуулж байна.

Кюзай кенкю – г хичээлийн бэлтгэл судалгаа гэж үзсэн тохиолдолд дараах таван судалгааг уялдуулан явуулдаг байна [8]. Үүнд:

1. Агуулгын судалгаа
2. Мэдлэг эзэмшилтийн явцын судалгаа
3. Арга зүйн судалгаа
4. Хэрэглэгдэхүүний судалгаа

5. Үнэлгээний судалгаа

Багш ажилдаа туршлага хуримтлуулан чадваржихын хэрээр хичээлийн төлөвлөлт нь илүү дэлгэрэнгүй төлөвлөлтөөс хураангуй “mental map” буюу “Оюуны зураглал” төлөвлөлтөд шилждэг [9].

1. Судлагдахууны агуулгын судалгаа

Агуулгын судалгаа гэдгийг хэзээ юу үзэх вэ? Ямар дэс дараатай байх вэ гэдгээр хязгаарлах боломжгүй. Дээр үеэс л заах аргачид агуулгын залгамж холбоо, хичээл хоорондын холбоо гэдгийг ярьсаар ирсэн. Мэдээж залгамж холбоог сайтар тусгаж уялдаа холбоонд авч үзэх нь чухал. Юуны түрүүнд сонгосон агуулга нь тухайн хичээлийн судлагдахууны тогтолцоонд ямар байр суурь эзэлдгийг тодорхойлж, тухайн хичээлээр судлах агуулгын мөн чанарыг шинжлэх ухаан талаас нь авч үзэн, яаж агуулгын шинжлэх ухаанч чанарыг алдагдуулахгүйгээр хүүхдэд энгийн ойлгомжтой, хялбар болгох вэ, ямар нэр томьёо, үг хэллэг хэрэглэх вэ, өмнөх хичээлээр ямар агуулга судалсан, цаашид хэрхэн гүнзгийрэх зэргийг судална. Энд хэрэглэх нэр томьёогоо зөвхөн шинжлэх ухааны логикийн үүднээс хандвал өрөөсгөл болно.

Тэгвэл агуулга гэдгийн цаана юу ойлгох вэ гэдгийг бид шинээр авч үзэх хэрэгтэй.

Математикийн хувьд судлагдахууны агуулгын мөн чанарыг математикийн ухаан талаас нь авч үзэхдээ [3,5]:

Тухайн агуулгын түүхийг судлах

- Тухайн агуулгын математик утга, нарийн тодорхойлолт, чанар, теорем, мөрдлөгийг тодруулах
- Тухайн агуулгын гол математик сэтгэлгээ хэрэглэх хэсэг нь юу вэ гэдгийг тодруулах
- Тухайн агуулгыг заах нь нийгэмд хэр хэрэгцээтэй байгааг тодруулах
- Тухайн агуулгын ач холбогдлыг тодорхойлох ёстой гэжээ.

2. Мэдлэг эзэмшилтийн явцын судалгаа

Хүүхдийн танин мэдэх процессыг судална гэсэн үг. Асуудлыг ойлгосон, ойлгоогүй хүүхдийг тоолж процентолж, дүн тавьж анхааруулснаар сэтгэл ханаж болохгүй. Энэ бол бидний мэддэг хуучин арга юм. Сургалтын явцад хичээлийн агуулгыг сурагчид хэрхэн хүлээн авч ойлгох, тайлбарлах, ямар хариу үйлдэл үзүүлж болохыг урьдчилан таамаглаж, хүүхдийн үг хэллэг, яриа, сонирхол, байр суурь, хандлагад чухам ямар өөрчлөлт гарч мэдлэг чадварт тусаж байгааг судална.

Сургалтын үр дүн суралцагчдын оюуны, сэтгэл зүйн, бие бялдар, харилцааны онцлогоос шууд шалтгаалдаг. Мэдээллийг бэлэн дамжуулахгүй, мэдлэг бүтээх аргаар сургалтыг явуулж байгаа үед дээрх хүчин зүйлийг урьдчилан тооцох шаардлага зайлшгүй.

Сургалтын үед суралцагчдаас гарч болзошгүй хариу үйлдэл, алдаа, ташаа төсөөллийг судалж тооцно. Япон багш нар хүүхэд нэг бүрт ажиглалт тэмдэглэл хөтөлж юу чадаж мэдэж байгааг, юунд бүдэрч байгааг, ямар өөрчлөлт орж байгааг судалж хичээлдээ тооцдог юм билээ. Энэ явцад хүүхдэд ямар бэрхшээл учирч байгааг таньж мэдэх нь чухал. Эндээс хүүхдийн алдааг таньж мэдэх эхлэл тавигддаг. Төслийн хүрээнд явагдсан зарим туршилт хичээл дээр мэдлэг бүтээгдэх нөхцөл, үйлийн орчин бүрдүүлж чадахгүй байсан бөгөөд чухал агшин, сэжүүрийг багш мэдэрч чадаагүйн улмаас хичээлийн цаашдын өрнөлийг хөтлөхөд бэрхшээл учирч байсан [2].

Энд багшийн мэдрэмжийн асуудал чухал байдаг бололтой.

Сурагчдыг судлах нь дараах давуу талуудыг олгож байдаг [6]. Үүнд:

- Хичээлээ суралцагчдын бодит байдалд ойртуулах
- Мэдлэг бүтээгдэх үйл явцыг урьдчилан төлөвлөх, алхамчлах
- Мэдлэг бүтээгдэх бодит нөхцлийг бүрдүүлэх
- Багш хичээлийн процессыг удирдаж хөтлөх, хянах, судлах боломж

Когнитив онол: Когнитив онолд мэдлэг, когнитив бүтэц, мэдлэгийн тавил зэрэг тулгуур ухагдахууны тусламжтайгаар хүний мэдээлэл боловсруулах механизмыг тайлбарладаг. Энэ онолд суралцагч гадаад орчноос мэдээллийг хүлээн авч, боловсруулж, хадгалан, шаардлагатай үед хэрэглэх механизмыг дараах маягаар



тайлбарладаг (1-р зураг).

Сурагч чих, нүд зэрэг сэрж мэдрэх эрхтэнүүдийнхээ тусламжтайгаар багшийн бичсэн, ярьсан зүйлийг харж, сонсож мэдээллийг хүлээн авдаг.

- Эхлээд сурагчийн мэдрэх эрхтэнүүд хүлээн авсан их хэмжээний гадаад мэдээллийн тодорхой хэсгийг сенсор регистр (шалган нэвтрүүлэгч)-д дамжуулна.
- Сенсор регистрт бүртгэгдсэн мэдээллээс субъектийн зөвхөн анхаарч сонирхсон мэдээлэл нь богино хугацааны санамжид (энэ нь компьютерийн шуурхай санах ойтой төстэй) очно.
- Богино хугацааны санамжид орсон шинэ мэдээллийг нь урт хугацааны санамж (компьютерийн хатуу дисктэй төстэй) хадгалагдаж буй өмнөх мэдлэгтэй уялдуулан боловсруулж түүнийг утгажуулдаг. Богино хугацааны санамжид байгаа мэдээлэл (компьютерийн шуурхай санах ойд байгаа мэдээлэл хэлхээг салгах үед арилдагтай адил) утгачилагдаагүй бол амархан

мартагдана.

- Ийм мэдээллийн зарим хэсэг нь урт хугацааны санамжинд очиж хадгалагдана. Ингэснээр урт хугацааны санамжинд байгаа хур мэдлэг илүү эмх цэгцтэй гүн гүнзгий, өргөн хүрээтэй болж шинэчлэгдэн шаардлагатай үед сэргээгдэн дуудагдаж, асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх боломж нь сайжирч байдаг.

Багшийн самбар дээр бичсэн өгүүлбэр юм уу тайлбарласан бодлого нь багшид байгаа төсөөллийн хүрээнд тодорхой утга санааг илэрхийлж байгаа. Харин сурагчийн төсөөлөл багшийнхтай адил бус учраас багшийн бичсэн өгүүлбэр юм уу тайлбарласан бодлогод тэс өөр утгыг өгч болдог. Энэ нь багшийн мэдлэг тэр хэвээрээ сурагчид дамжих боломжгүйг харуулж байна. Бидний тархи зүгээр нэг идэвхгүй хүлээн авагч биш бөгөөд мэдээллийг боловсруулахад идэвхтэй оролцдог болох нь харагдаж байна. Ямар мэдээллийг цаашид боловсруулахаар дамжуулах вэ? гэдэг нь мэдээлэл хүлээн авагчийн хэрэгцээ, сонирхол, төсөөлөл зэргээс хамаарна.

Хүний урт хугацааны санамжид байгаа мэдлэгийг ерөнхийдөө өмнөх төсөөлөл гэж ойлгож болно.

Урт хугацааны санамжид байгаа мэдлэгийн бүтцийг ухагдахууны сүлжээ (**concept map**) хэлбэрээр төсөөлж болдог. Сүлжээний зангилаа цэгүүд нь ухагдахууныг төлөөлдөг. Тухайн ухагдахууны шинж, түүний бусад ухагдахуунтай холбогдох холбоо нь ухагдахууны утга санааг илэрхийлдэг. Эндээс суралцахуйг ухагдахууны сүлжээний бүтцийн өөрчлөлт гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, шинэ ухагдахуун өмнөх мэдлэгийн ухагдахуунуудтай шинэ холбоонд орж сүлжээний бүтцийг зохих хэмжээгээр өөрчилж шинэ мэдлэг бий болно.

3. Арга зүйн судалгаа

Үүнийг зааж сургадаг багш төвт уламжлалт аргын үүднээс биш, хичээлийг зохион байгуулах, явуулах, удирдах, хөтлөх арга гэсэн утгаар ойлгох нь зүйтэй. Хичээлийг хэрхэн хөтөлж ямар алхамтайгаар зохион байгуулбал сонирхолтой, ойлгомжтой болгож, гол зүйлд анхаарлыг төвлөрүүлж, **хэрхэн мэдлэг бүтээлгэж, ухааруулж, мэдрүүлэх вэ?** Жишээлбэл, ямар туршилт хийх вэ, хэдийд хийх вэ, хэрхэн хийлгэх вэ, юуг чухалчлах вэ, ямар үр дүнг хүсэж байна вэ гэдгийг тооцоод, хичээлийн явцад хүүхдүүд туршилтад хэрхэн хандаж байна вэ, юу алдаж байна вэ, түүнийг хэрхэн гэтлэн давах вэ? үүнийг хэрхэн тооцох вэ? гэх мэтээр судална. Үүнийг хичээлийнхээ төлөвлөлт, явц, үр дүнд анализ хийж илрүүлэх, тооцох боломжтой.

Судална гэдэг нь хэдэн хүүхдийн юм уу багшийн амжилтыг процентолж диаграмаар харуулах төдийг хэлэхгүй. Эцэст нь арга зүйн оновчтой шийдэлд, чадвал **дидактик шийдэлд** хүрэх нь судалгааны гол зорилго болно.

Энд Данида төслөөс суралцсан “булангийн”, KWL, INSERT гэх мэт зохион байгуулалтын аргыг дидактик аргаас ялгаж ойлгох, тэдгээрийг хослуулан хэрэглэх талаар анхаарах хэрэгтэй.

Боловсруулсан тухайн агуулгыг, тухайн суралцагчдад хүргэхийн тулд дидактикаар дахин боловсруулалт хийж, хичээлийн процессыг төлөвлөх шаардлага тулгардаг. Энд:

- Хэрхэн хичээлийг сонирхолтой болгох вэ? Яаж сэдэл төрүүлэх вэ?
- Ямар асуулт тавих, хариу үйлдлийг хэрхэн удирдаж хөтлөх вэ?
- Ямар сорил, туршилт, дасгал бодлогыг ямар дэс дараа алхамтай хийлгэх вэ?
- Албадлагагүйгээр, аль болох олон хүүхдийг хичээлд татан оролцуулахын тулд яах вэ?


- Суралцагчдаас ямар ямар болзошгүй хариу үйлдэл, санал гарч болох, түүнд ямар байр суурь баримтлах вэ?

Эдгээр асуудлаар судлаачдын байр суурь, багш нарын туршлагыг судалж, хичээлийн бүтцийн өөрийн гэсэн хувилбарыг бүтээдэг.

Хичээлийн агуулгыг дидактикаар дахин бүтээх арга

Хичээлийн агуулгыг хичээлийн зорилго ба сурагчдын сурах чадвар, сонирхол, бусад хүчин зүйл, бодит боломжийг тооцож энгийн хялбар, сонирхолтой болгож боловсруулах ёстой. Үүнээс үүдээд ямар ч сэдвийн хувьд **хичээлийн агуулгын бүтэц нь шинжлэх ухааны агуулгын бүтцээс өөр** байхад хүрдэг. Тухайлбал, шинжлэх ухааны хувьд чухал эсэхээс нь хамаарахгүйгээр энэ агуулгыг сурагчид эзэмших нь чухал уу, түүнийг эзэмшүүлэх бодит боломж байна уу гэдэг асуултыг багш өөртөө тавих нь зүйтэй. Багш шинжлэх ухааны агуулгыг хялбаршуулж, түүнийг сурагчид сурахад тохиромжтой, хүүхдэд ээлтэй байхуйцаар дидактикаар дахин бүтээж хичээлийн агуулгаа боловсруулах шаардлагатай болдог.

Иймээс хичээлийн киррикулим боловсруулах үйл ажиллагаа нь дээрээс доош нь бичээд ард нь гардаг үл буцах шууд процесс биш, харин хичээлийн элементүүдийн торгон холбоог дахин дахин сайжруулах замаар боловсордог цикл процесс юм. Иймээс тухайн шинжлэх ухааны агуулгыг хичээлийн агуулга болгон хувиргах процессыг дидактикаар дахин бүтээх гэж нэрлэдэг. Р.Дуитын боловсруулсан дидактик реконструкци буюу дидактикаар дахин бүтээх аргын загварыг дараах диаграмаар үзүүлэв [12, 13].



4. Хэрэглэгдэхүүний судалгаа

Ямар хэрэглэгдэхүүнийг ямар зорилгоор, хэдийд, яаж ашиглавал үр дүнтэй байх вэ, түүнийг улам боловсронгуй болох арга замыг судална. Энд ном, сурах бичиг, ашиглах үзүүлэн, хийх туршилт, киррикулим зэрэг бүх хэрэглэгдэхүүнийг хамааруулан ойлгож болно. Хэрэглэгдэхүүний судалгааг бусад судалгаатай уялдуулан судална.

Одоо жишээ үзье.

Физикийн модульд цахилгаан ба соронзон орон гэдэг биегүй, харагддаггүй, амтлагдахгүй атлаа бодитоор оршин байдаг материйн нэгэн хэлбэрийг 9 –р ангийн сурагчдаар хэрхэн мэдрүүлэх вэ гэдэг асуудлыг хөндсөн байна. Үүний тулд агуулгын босоо, хэвтээ залгамж холбоог физик талаас судалсны дээр, хичээлийн үед багш болон сурагчдын зүгээс элбэг гаргадаг шинжлэх ухааны алдааг судалж,

түүний шалтгааныг тайлбарласан байна. Энэ нь агуулгын шинжлэх ухааны тал ба сурагчдын өмнөх төсөөллийн судалгаанд хамаарна. Туршилтын гол санаа нь соронзон биет байхгүй хоосон зайд хүчний үйлчлэлд өртөөд байгаад анхаарлаа төвлөрүүлэхэд оршиж байв. Энд хэрэглэгдэхүүний утга учир оршино.

Биеийн цахилгаанжих механизмыг сурагчдад ойлгуулахын тулд төмөр самбар дээр цэнэгт бөөмийг байрлуулах аргыг хэрэглэсэн нь бөөмөн загварыг сурагчдаар бүтээлгэх боломж өгчээ. Энэ хэрэглэгдэхүүн үүргээ хэр биелүүлж байгааг хичээл дээр ажиглаж хэлэлцсэн байна. Хэрэглэгдэхүүний шинэ загвар бүтээх энэ оролдлого нь хэрэглэгдэхүүний судалгаанд хамаарагдана. Дунд ангийн математикийн хичээлд “эзэлхүүн” сэдвийг заахад хэрэглэсэн устай куб сав, тэгш өнцөгт биетийн систем нь сурагчдаар нээлттэй асуудал шийдэх аргыг бүтээлгэхэд чиглэсэн байв. V ангид байгаль шинжлэлийн хичээлээр “Сүүдрийн хэмжээ юунаас хамаарах вэ” гэсэн туршилтыг сурагчдаар хийлгэсэн. Энд эхний удаа гэрэл үүсгэгч, биет, дэлгэц ашигласан. Ихэнх хүүхдүүд сүүдрийн хэмжээ юунаас хамаарах тухай хангалттай сайн илэрхийлж байсан ч, зарим хүүхэд учрыг олоогүй болохыг багш анзаарсан. Иймд дараагийн удаа хэрэглэгдэхүүнээ бүх сурагчдад ойлгомжтой байлгах үүднээс гэрэл үүсгэгч ба биетийн гурван өөр байрлалд сүүдрийн хэмжээг нэгэн зэрэг харьцуулах боломжтой байхаар хэрэглэгдэхүүнийг өөрчилсөн. Энэ нь сурагчдад харьцуулсны үндсэн дээр асуудалд шинжлэх ухаанчаар хандах санаа олж авах, түүнийгээ үгээр илэрхийлэх боломж олгож байгаа юм. Ингэж хэрэглэгдэхүүнийг сурагчдад ээлтэй байдлаар боловсруулж, дахин дахин сайжруулах нь хэрэглэгдэхүүнийг судалгаанд хамаарна.

Эндээс үзэхэд хэрэглэгдэхүүний судалгаа бол хичээлд хэрэглэх бүр зүйлийн дидактикаар ширж бүтээсэн “утгажуулсан” систем гэж ойлгож болно.

5. Үнэлгээний судалгаа

Үүнийг суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлнэ, алдааг илрүүлж дүн тавина, дүнд анализ хийнэ гэвэл өрөөсгөл болно. Энд ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ чухал байр суурь эзэлдэг [13].

Зөвхөн хүүхдээ үнэлэх биш, зорилго, арга зүй, хичээлийн төлөвлөлт, сэдэл, гүйцэтгэсэн туршилтаа хэр үр дүнтэй болсныг, хэрхэн улам сайжруулах талаар үнэлбэл сайн. Ийм үнэлгээнд урьдчилан бэлтгэнэ.

Үнэлгээг хичээлийн өмнө, хичээлийн явцад, дараа нь хийх боломжтой байдаг. Суралцагчдаар хичээлээ үнэлүүлнэ. Санал авна. Саналын хуудас урьдчилан бэлтгэнэ.

Үнэлгээний материалын судлагаа нь **АГУУЛГА, АРГА ЗҮЙН СУДАЛГАА**-тай нягт уялдаатай хийгдэнэ. Суралцагчдын үнэлгээний материалыг боловсруулахдаа суралцагчид гарч байгаа ахиц дэвшил, сурах арга барилын өөрчлөлтийг бодитойгоор илрүүлэхэд анхаарах ёстой. Үүнийг сургалтын амжилтын оношлогоо, үнэлгээ гэж ойлговол өргөн утгатай болно. Энэ талаар бид маш бага мэдлэг, туршлагатай байгаа.

Энэ бүх судалгааны зорилго нь юунд оршиж байна вэ гэвэл бүхэлдээ сургалтын чанарыг сайжруулах, сайн хичээлийг явуулахад чиглэж байгаад оршино. Тэгвэл эдгээрийг дараах байдлаар загварчилж болох мэт. Гэхдээ эдгээрийг салангидаар биш цогцоор нь, уялдаанд нь авч үзэх хэрэгтэй. Тэгж гэмээ нь Кюзай кенкю учир утгатай болж, хэрэгжих боломжтой болно.

Сэдвийг боловсруулахад ашигласан материал

1. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Хими. Зөвлөмж II. БСШУЯ, Жайка. 2008.

2. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Физик. Зөвлөмж II. БСШУЯ, Жайка. 2008.
3. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Бага ангийн математик. Зөвлөмж II. БСШУЯ, Жайка. 2008.
4. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Хүн орчин. Зөвлөмж II. БСШУЯ, Жайка. 2008.
5. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Дунд ангийн математик. Зөвлөмж III. БСШУЯ, Жайка. 2009.
6. Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлах аргазүйн хөгжил. Хичээл: Мэдээлэлзүй. Зөвлөмж III. БСШУЯ, Жайка. 2009.
7. Арагаки Тадхико, Сатоманобү. Кюзай Кенкю гарын авлага. 2001.
8. Такахата Хироши. Kyozaï kenkyu –гийн тухай товч тайлбар. 2007.
9. Ажитэру Фүкүчи. Жайкагийн 2 дахь жилийн зөвлөмжийг турших, боловсронгуй болгох нэгдсэн сургалт семинарт тавьсан илтгэл. 2008.
10. Б.Бурмаа, Н.Нэргүй, У.Доед. Суралцахуй-концепцийн өөрчлөлт // Сургууль соёлын хөгжлийн чиг хандлага. УБ. 2002. х 38.
11. Б.Бурмаа, М.Ганбат. Сургалтын сэтгэл судлалын үндэс. 2004.
12. R. Duit. What is “good” physics instruction. МУИС –ийн их семинарт уншсан лекц. 2004.
13. Б.Бурмаа, М.Ганбат. Физик дидактик- хичээлийн практикт. 2006.
14. Камата Масахиро. Байгалийн ухааны хичээлд бэлдэхүй буюу кёзай кэнкю. Багш нарт өгсөн зөвлөмж. 2010.

2.2.2. Хичээл заах ба ажиглах

Энд бид “Хичээлийн судалгаа” буюу “сурагчдын суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй” бүхий сайн хичээлийг задлан шинжлэх (хичээлийг төлөвлөх, зохион байгуулах, үнэлж сайжруулах) зорилгын дор хийгдэж буй нарийн нийлмэл үйл”-ийн үндсэн хоёрдугаар үе шат болох судалгаат хичээлийг заах болон ажиглах талаар авч үзнэ. Нэгэнт мэдлэг нэг хүнээс нөгөөд шууд дамжихгүй учраас багш хичээлээр сурагчдад ямар нэг агуулгыг “зааж” өгөөд сурагч суралцахгүй гэдэгтэй бид нэгэнтээ санал нэгдсэн билээ. Хүн шинэ мэдлэгийг өөрөө өөртөө зохиомжлон бүтээж чадвал сая түүнд суралцдаг болохоор багш хичээлээр сурагчид тухайн шинэ мэдлэгийг “бүтээх” үйлийг удирдах, зохион байгуулах ёстой болно. Иймээс бид “хичээл заах” гэдгийг “хичээлийг зохион байгуулах” гэсэн агуулгаар түлхүү ойлгож явах болно.

Хичээлийн бэлтгэл судалгааны шатанд “сурагчдын суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй” боловсруулахад шаардлагатай бүхий л судалгааг хийж хамтран ажилласнаар зохих арга зүйг хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлттэй болсон байгаа. Нэгэнт нэг амьсгаагаар арга зүйгээ бүрэн шинэчлэх боломжгүй учраас хичээлийн судалгаанд тухайн хичээлийн жилд дэвшүүлсэн зорилгын хүрээнд хичээл заах багш болон ажиглагч нь Хэн? Юуг? Яаж? гэсэн асуултын дагуу үйл ажиллагаагаа хязгаарлаж, төлөвлөж ажиллавал зохино.

1а. Хэн хичээл заах (зохион байгуулах) вэ?

Хичээлийн судалгаагаар “суралцахуйг дэмжсэн арга зүйг хөгжүүлэх”-ийн тулд “суралцахуйг дэмжсэн арга зүй бүхий сайн хичээл”-ийг задлан шинжлэх нь бидний зорилго учраас энэхүү судалгаат хичээлийг нэлээдгүй хэдэн жил багшилсан, арга зүйн туршлага хуримтлуулсан, хамгийн шилдэг багш нар заах (зохион байгуулах) нь оновчтой байх болно.

Зөвлөгөө:

Хэн хичээл заах (зохион байгуулах) вэ?

- Багшлах арга зүйн хувьд аль болох хангалттай туршлагатай багш

Хэн хичээлийг ажиглах вэ?

- Хэрэгжүүлж буй арга зүйн давуу ба сул талыг илрүүлж харах хангалттай туршлагатай шилдэг багш нар
- Сайн хичээлийн арга зүйгээс суралцах шинэ залуу багш нар
- Хичээл хоорондын холбоог илрүүлж арга зүйг сайжруулах бусад хичээлийн багш нар
- Хичээлийн судалгаагаар багшлахуй аргазүйг хөгжүүлэх үйл явцыг чиглүүлэх арга зүйчид болон сургалтын менежер, захирал
- Мэргэжил, арга зүй, суралцахуйн сэтгэл судлалын чиглэлээр зөвлөх үүрэгтэй судлаачид

16. Хэн хичээлийг ажиглах вэ?

Судлаачид хичээлийн судалгааг зориулалтаас нь:

- Суралцах (хамтран суралцах, бусдаас суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалт)
- Хуваалцах (ижил түвшний багш нар харилцан туршлага солилцох)
- Түгээн дэлгэрүүлэх (сайн туршлага, тодорхой арга зүйг түгээх)
- Хөгжүүлэх (тодорхой арга зүйг сайжруулах)
- Бүтээх (шинэ, шинэлэг арга зүй, хэрэглэгдэхүүн, дидактик шийдэл г.м.) гэх зэргээр нэрлэсэн байдаг.

Эдгээрийн аль ч төрөлд “суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй”-г хичээлээр хэрэгжүүлэх явцын давуу сул талыг олж илрүүлэх, сурагчийн хариу үйлдлийг нарийн таньж барих хангалттай туршлагатай ажиглагч багшийн үүрэг маш чухал юм.

“Сайныг дагавал сарны гэрэл” гэсэн монгол ардын зүйр цэцэн үг байдаг ёсоор арга зүйтэй багшийн судалгаат хичээлээс залуу багш нар маш олон зүйлийг сурч мэдэж, шинийг өөртөө нээх учраас залуу багш бол аль ч түвшний хичээлийн судалгааны ажиглагч байх ёстой.

Төслийн 1-р шатанд эхэн үед зарим багш нар мэргэжлийн бус хичээлээ ажиглахаас татгалзах тохиолдол гарч байсан ч цөөхөн хичээлд ажиглалт хийснийхээ дараа ингэж цааргалах нь буруу байсныг бид бүгдээрээ ойлгосон юм. Байгалийн ухаан, математик, мэдээлэл зүйн гээд бүхий л хичээлээр бид ярих, бичих, унших үйл ажиллагаа хийдэг учраас Монгол хэлний багш нарт аль ч төрлийн судалгаат хичээлийг ажиглах, сурагчдын чадвар, хөгжил, гаргаж буй алдааг олж илрүүлэх боломжтой байдаг. Эндээс харин ч монгол хэлнийхээ хичээл, арга зүйгээ хэрхэн сайжруулах талаар шинэ санаа олсон олон тохиолдол гарсан. Мөн хими, физик, биологи, газар зүй зэрэг байгалийн ухааны хичээл нь агуулга, нэр томьёо, хэрэглэдэг математик аппаратынхаа хувьд нягт холбоотой учраас багш нар хичээл хоорондын залгамж холбоог агуулгын болоод арга зүй, хэрэглэгдэхүүний түвшинд гаргах, сурагчдынхаа авьяас чадвар, алдаа оноог олж харах боломжийг олгож байсан. Иймээс тухайн ангид хичээл заадаг бусад мэргэжлийн багш нар нь хичээлийн судалгааны маш чухал үүрэгтэй ажиглагч юм.

“Суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй”-г хөгжүүлэх, “багшлахуй арга зүйн хөгжил”-ийг түгээн дэлгэрүүлэхэд арга зүйчид болон сургалтын менежер,

захирлын үүрэг чухал бөгөөд хичээлийн судалгааны зорилго нь угаас тухайн сургуулийн ерөнхий зорилготой уялдсан байх учир удирдлагын босоо холбоог бодитоор хангах, сургуулийн нийтлэг арга зүйн үнэт зүйл, соёлыг бүтээхэд тэдний ажиглагчийн үүрэг маш их байна.

Тухайн шинжлэх ухааны агуулгын тодорхой хичээлээр, тодорхой насны сурагчдад ойлгомжтой болгон хялбаршуулах (элементарчлах) гэх мэт олон төрлийн дидактик боловсруулалт хийхэд их дээд сургуулийн нарийн мэргэшлийн профессор багш нарын мэргэжлийн зөвлөгөө маш чухал байдаг. Мөн сурагчдын гаргадаг зарим алдааны суурь шалтгаан нь олон хүчин зүйлээс хамааралтай байх зэрэг зайлшгүй суралцахуйн сэтгэл судлал, хэд хэдэн шинжлэх ухааны заагт асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байдаг. Түүнчлэн манай орны хувьд хичээлийн судалгааны арга зүйг шинэ тутам хэрэгжүүлэх гэж байгаа одоо үед судлаачдын ажиглагчийн хариуцлага маш өндөр байна.

Хичээлийг заах (зохион байгуулах) багш, ажиглах гишүүд нь нэг багийн гишүүн байж тэрхүү хичээлийн төлөвлөлтийг хамтран хийсэн байх нь маш чухал болохыг ямагт санаарай.

2а. Багш юу заах (зохион байгуулах) вэ?

Зорилгоо дахин нэг саная. “Сурагчдын суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй бүхий судалгаат хичээлийг задлан шинжлэх замаар арга зүйгээ хөгжүүлэх нь бидний зорилго билээ. Суралцахуйг дэмжсэн арга зүй бүхий хичээл заахын тулд суралцахуйг яаж дэмжих вэ? гэдгийг суралцахуйн сэтгэл судлалын зарим онолын хувьд товч авч үзье.

Ж.Пиажегийн тэнцвэрийн онолд хүний мэдлэг нь тодорхой бүтэцтэй байх бөгөөд хүн гаднаас ирж буй шинэ мэдээллийг өөрийн мэдлэгийн бүтцээс хамааран ассимиляцилах, эсвэл аккомодацилах гэсэн хүний сэтгэхүйн дасан зохицохуйн харилцан шүтэлцээт үйл явцын дүнд боловсруулж өөртөө мэдлэг болгон зохиомжлон бүтээдэг гэж үздэг байна. Хүүхдийн амьдралаас олж авсан мэдлэгийн агуулга (өмнөх төсөөлөл) нь шинжлэх ухааны хувьд гол төлөв буруу байдаг бөгөөд энэ мэдлэгийн бүтцийг аккомодацид оруулахгүй л юм бол бид хичнээн ч сайн сайхан зүйл заагаад хүүхэд өөрийн боломжийн хэрээр, хуучин мэдлэгийнхээ бүтцээр шинэ мэдээллийг ассимиляцилах учраас мэдлэг бүтээх идэвхтэй үйл ажиллагаа явагддаггүй, улмаар өмнөх төсөөлөл нь ч өөрчлөгддөггүй. Тэгэхээр багш таны өмнө “хичээлийн бэлтгэл судалгаа”-ны алдааны шинжилгээгээр оношилсон сурагчийн өмнөх төсөөллийг шинжлэх ухааны агуулгатай болгохын тулд хийсэн дидактик төлөвлөлтөө хэрэгжүүлэх ёстой болно.

Зөвлөгөө:

Багш юуг заах (зохион байгуулах) вэ?

- Мэдлэг бүтээх үйл явц
- Үйлийн баримжааг хэрэглэж, эзэмших үйл явц

Ажиглагч юу ажиглах вэ?

- Багшийн асуулт, суралцагчдын хариулт
- Самбар ашиглалт
- Суралцагчдын дэвтэр хөтлөлт
- Багш сурагчийн харилцаа
- Сорил туршилтыг гүйцэтгэж буй байдал
- Ангийн тодорхой сурагчийн идэвхи оролцоо
- Хүүхдүүдийн алдаа, өмнөх төсөөлөл, санаа
- Хичээлийн элементийн тодорхой хэсэг
- Хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын орчин
- 1 баг, 1 хүүхэд
- Хүүхдүүдийн шивнээ яриа
- Цаг ашиглалт

Л.Выгодский хувь хүний мэдлэг бүтээх үйл ажиллагааг социаль орчны нөлөөгөөр оновчтой зохион байгуулж, идэвхжүүлснээр хүний физиологи, сэтгэцийн хувьд хүрэх боломжоос илүү давуу хөгжилд хүрч болно гэж үзсэнээрээ конструктивизмын онолын өмнө тавигдсан “Хүн төрөлхтөний олон зуун жилийн турш хуримтлуулсан мэдлэгийг хүүхэд ганцаараа өөрөө бүтээж чадах уу?” гэсэн асуудалд хариулт өгсөн гэж хэлж болно. Үйл ажиллагааны баримжааны үндсийг тодорхойлдог тогтолцоот, учир шалтгаант, ухамсарласан, ерөнхийлсөн, шинжлэх ухааны үндэстэй байх шинжүүдээс субъект (суралцагч)-ын хөгжих эсэх нь хамаардаг бөгөөд субъектыг хөгжүүлэх, өөрөөр хэлбэл, суралцагчийн сэтгэхүйг хөгжүүлэх тийм баримжааг шууд өгснөөр биш, харин суралцагч түүнийг хувийнхаа үйл ажиллагаагаар баталсан тохиолдолд сэтгэхүйд нь чанарын өөрчлөлт гарч хөгждөг. Иймд багш та хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнд суралцагчийнхаа сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэгээ өөрөө бүтээхэд нь дэмжлэг болох үйлийн баримжааг ялгаж боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Когнитив онолын хүрээнд гарч ирж буй шинэ чиглэл болох “Мэдээллийн идэвхтэй боловсруулалт”-ын онолд хүрээлэн байгаа бодит ертөнц, юмс үзэгдлийн талаар таньж мэдсэн бүхий л зүйл нь тухайн хүний мэдлэгийн бүтэц буюу удаан хугацааны санамжид байгаа мэдлэгийн агуулгыг тодорхойлдог. Энэ онолоор мэдлэгийг хэлбэрийн хувьд салангид болон тогтолцоот мэдлэг гэж ангилдаг. Тогтолцоот мэдлэгийг дотор нь агуулгын хувьд декларатив, процедурал гэж ангилдаг. Хүн бүрт байх салангид мэдлэгийн цар хүрээ багтаамж нь харилцан адилгүй бөгөөд ийм мэдлэгийн хэмжээ толь бичгийн хэмжээтэй их байлаа ч гэсэн үр ашиг багатай гэж үздэг. Харин тогтолцоот мэдлэг нь эмх цэгцтэй, хэрэглэхэд бэлэн байхаар зохион байгуулагдаж хадгалагдсан байдаг бөгөөд ийм мэдлэгтэй хүн л аливаа асуудлыг шийдвэрлэхэд тогтолцоот мэдлэгээ ашиглаж илүү бүтээлч байдаг. Иймд хичээлийн бэлтгэл судалгааны агуулгын судалгаагаар тодорхойлсон тогтолцоот агуулгыг сурагчид өөртөө зохиомжлон бүтээх дидактик шийдлийг хэрэгжүүлэх ёстой болно.

Когнитивизмын хүрээнд үүсэн хөгжиж буй репрезинтацын онолд мэдлэгийн тавил гэсэн ухагдахууныг авч үздэг бөгөөд мэдлэгийн гадаад, дотоод гэсэн хоёр төрөл байдаг гэж үздэг. Үг яриа, үсэг тэмдэг, томьёо дүрслэл нь мэдлэгийн гадаад тавилын хэлбэрүүд болно. Харин хүний мэдлэгийн дотоод тавил нь төсөөлөл байдлаар ментал загварын хэлбэртэй байна. Мэдлэгийн гадаад тавилын зарчим болон бүтэц нь дотоод тавилынхтай ойролцоо байх үед тэдгээр нь резонансад орж дотоод тавил өөрчлөгдөн мэдлэгийн шинэ бүтэц үүсдэг. Хүнд байгаа мэдлэг болон түүний сэтгэн бодох үйл явцын алинд нь илүү ач холбогдол өгч байгаагаас хамаарч мэдлэгийн когнитив бүтцийг авч үзэхдээ мэдлэгийн бүтэц, сэтгэх бодох бүтэц гэсэн ухагдахууныг сонгон хэрэглэж байна. Шинэ мэдлэг нь өмнө байсан мэдлэгийн бүтцэнд интегралчлагдан улмаар уг бүтэц өөрчлөгдөн, өргөсөж боловсронгуй болж байдаг. Харин мэдлэгийн гадаад болон дотоод тавилын зарчим болон бүтэц нь хоорондоо нийцээгүй байх үед мэдлэгийн шинэ бүтэц үүсдэггүй. Өөрөөр хэлбэл, багш тухайн агуулгыг хичнээн ч нарийвчлан боловсруулж заалаа гэсэн хүүхдийн толгойд өмнөх мэдлэгийн нь бүтцэд интегралчлагдан багшийн хүссэнээс өөрөөр буух магадлал байна. Ийнхүү зааж, зааварлах аргаар хүнийг сургах нь хязгаарлагдмал учраас зааж сургаж зааварлахаас гадна өөрийн боловсруулсан мэдээллийг гадаад тавил (үйлийн баримжаа)-аар нь шинэ агуулгаар ойлгоход туслах буюу суралцагчийн гадаад тавилыг мэдлэгийн шинэ бүтэц болгож авах үйл явцыг дэмжиж удирдан чиглүүлнэ гэсэн үг.

Нэгдүгээрт, хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнд боловсруулсан хичээлийн төлөвлөлт, судлах гэж буй арга зүйгээ сайтар танин барих, эзэмших нь зүйтэй юм.

Хоёрдугаарт, Тухайн хичээлийн агуулгыг шинжлэх ухааны агуулгын хувьд, сурагчдаар мэдлэг бүтээлгэх агуулгын хувьд, дидактик шийдлийн хувьд бүрэн танин барьж эзэмшсэн байх нь зүйтэй юм.

26. Ажиглагч юу ажиглах вэ?

Судалгаат хичээлийн ажиглалтыг явуулахдаа хамгийн эхэлж анхаарах ёстой зүйл бол тухайн судалгаат хичээлээр чухам юуг илрүүлэх гэж байгааг тодруулах явдал юм. Өөрөөр хэлбэл, судалгаат хичээлийнхээ зорилгыг тодорхой болгох хэрэгтэй. Тухайлбал,

- Багшийн үйл ажиллагааг бүхэлд нь ажиглах уу?
- Сурагчдын үйл ажиллагаа болж байна уу?
- Сэдэлжүүлэх хэсгийг явуулж болж байна уу?
- Хүүхдэд тавих асуулт оновчтой байна уу?
- Хүүхдэд ойлгомжтойгоор самбарыг хэрэглэж байна уу?
- Мэдлэг бүтээлгэх арга зүйг оновчтой төлөвлөсөн эсэх, сурагчдад тохирч байгаа эсэх
- Сурагчдын сорил гүйцэтгэх чадвар, илэрч буй өөрчлөлт, хөгжил
- Сурагчдын таамаглал дэвшүүлэх чадвар гэх мэт

Ингэж зорилго тодорхой болсноор ажиглалт хийх багш нар нэгэн зорилгын дор үр дүнтэй судалгаа хийх болно. Бидний уламжлалт хийдэг байсан нээлттэй хичээлийн үед гардаг гол алдаа нь бид ийм тодорхой зорилго, үүрэг даалгаваргүй сууж ажиглалт хийгээд анхаарах ёстой гол хэсгийг илрүүлэлгүй нэг л зүйлийг давтан ярих магадлалтай байдаг ба сүүлийн багш нар нь тодорхой хэлэх зүйлгүй “санал нэг байна” гэсээр ярилцлага дуусдагт оршино.

Хичээлийн судалгааны багийн ажиглагч гишүүд нь судалгаат хичээл заах багштай хамтран хичээлийн төлөвлөлт хийсэн төдийгүй бас энэ үйл ажиллагаанд оролцоогүй хүмүүс ч байж болно. Иймээс ажиглалт хийх нийт хүмүүст тухайн судалгаат хичээлээр ямар зорилгоор юуажиглахыг тодорхой танилцуулсан байх хэрэгтэй. Тухайн судалгаат хичээлийн зорилгоосоо хамаараад дараах зүйлсээс сонгож аваад ажиглана.

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал:

- Хөтөлбөрийн цагийн төлөвлөлт оновчтой болсон эсэх: *Хичээлийн элемент бүрийн цагийн хуваарилалтыг хэр бодитой тооцож чадсан эсэхийг анзаарна.*
- Зорилго, зорилтын томъёолол оновчтой болсон эсэх: *Хичээлийн хэрэгцээнд суурилан зорилгоо зөв тодорхойлсон эсэхийг анзаарна. Зорилго зорилт нь хоорондоо уялдсан эсэх. Өөрөөр хэлбэл, дэвшилцсэн зорилгын хүрээнд зорилтоо зөв тодорхойлж чадсан уу гэдгийг анзаарах хэрэгтэй. Багш нарын хөтөлбөрийг харахад том зорилго тавиад жижиг зорилтыг дэвшилцсэн, эсвэл жижиг зорилгын доор том зорилт тавьсан, цг өгцүлбэрээ буруу томъёолсон байдаг. Энэ нь хөтөлбөрийн судалгааг бодитой хийгээгцүтэй холбоотой. Зорилго зорилтоо оновчтой зөв тодорхойлсноос хичээлийн дараагийн үйл ажиллагаа хамаарна.*
- Хичээлийн эхлэл, зохион байгуулалтын төлөвлөлт: *Анги зохион байгуулалт, багийн зохион байгуулалт зэрэг нь тухайн хичээлийн агуулга, арга зүй, хэлбэртэй холбоотой байсан эсэхийг анзаарна.*
- Сэдэлжүүлэлтийг оновчтой хийсэн эсэх: *Сурагчдын сонирхлыг хэр татаж*

хичээлийг ямар нэгэн асуудалгүй тасралтгүйгээр цргэлжлүүлэх эхлэлийг тавьж чадсан эсэхийг анзаарна.

- Шинэ мэдлэг эзэмших үйлийг оновчтой төлөвлөсөн эсэх: Сурагчдаар мэдлэг бүтээлгэхээр төлөвлөсөн байдлыг анзаарна. Мэдлэг бүтээлгэх гэж бичсэн хэрнээ мэдлэг олгохоор төлөвлөсөн байх нь элбэг тохиолддог.
- Бататгах дасгал даалгаврууд оновчтой эсэх
- Хичээлийн үнэлгээ, дүгнэлт хийсэн байдал: Хичээлийн үнэлгээ нь зорилттойгоо тохирч байгаа эсэхийг анзаарна. Анх дэвшилцсэн зорилттойгоо уялдаагүй бол хичээлийн зорилго биелсэн эсэхийг тооцоход бэрхшээлтэй байх болов уу.
- Гэрийн даалгаврын төлөвлөлт: Гэрийн даалгавар нь өнөөдрийн хичээлийг бататгасан, хэрэглээ дадал болгоход чиглэсэн, мөн дараагийн хичээлтэй холбогдож байгаа эсэхийг анзаарна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг ажиглах хцн тухайн хичээлийн хөтөлбөрийг урьдчилан авч сайтар судалсан байх ёстой. Тэгээд эхний байдлаар өөрийн дүгнэлтийг бичиж, онцолж харах зүйлээ тодорхой болгосон байвал зүгээр. Хичээл заах явцад хичээлийн хөтөлбөрт тусгагдсан элемент бүр хэр оновчтой, зөв болж байгааг анзаарч тэмдэглэл хөтөлнө.

2. Хичээлийн агуулга:

- Агуулга нь тодорхой зорилго чиглэлтэй эсэх
- Хичээлийн шинжлэх ухааны агуулга оновчтой эсэх
- Тухайн ангийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
- Агуулга нь бүх талыг хамарсан эсэх
- Агуулгын систем дэс дараа, уялдаа холбоотой байдал
- Амьдралтай холбосон эсэх

Хичээлийн агуулга нь хичээлийн хэрэгцээ, зорилго, зорилттойгоо уялдаж чадсан эсэхийг хамгийн гол нь анзаарах хэрэгтэй.

3. Сургалтын аргын оновчтой байдал

- Сургалтын аргуудыг хослон болон дангаар хэрэглэсэн байдал
- Арга нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
- Арга нь хичээлийн сэдэв, зорилго, агуулгатай зохицсон байдал
- Аргыг хэрэглэх багшийн туршлага, ур чадвар
- Аргыг бүтээлчээр хэрэглэсэн байдал

Тухайн сэдэвтэйгээ уялдан сурагчдаар мэдлэг бүтээлгэх цйлд тохирсон аргыг сонгож чадсан эсэхийг анзаарна.

4. Багшийн үйл ажиллагааг ажиглах

- Сурагчдад сургалтын зорилго, зорилтыг танилцуулсан байдал /сэдэл хэрэгцээг төрүүлсэн/
- Шинэ мэдлэгтэй танилцуулсан байдал
- Мэдлэг, чадвар эзэмшүүлэх үйл явцыг удирдсан байдал
- Шинжлэх ухааны зүй тогтлыг ухамсарлуулах үйл явцыг удирдсан байдал
- Онолоос практикт шилжих үйл явцыг удирдах
- Эрэн сурвалжлах ба судалгааны үйл ажиллагааг зохион байгуулах

- Суралцагчдын хөгжил, сургалтын явцад гарсан өөрчлөлтийг шалгах үнэлэх

5. Сурагчийн үйл ажиллагааг ажиглах

- Сурах эерэг сэдэл бий болох үйл ажиллагаанд орсон эсэх
- Шинэ мэдлэг, чадварыг ойлгож ухамсарласан байдал
- Анализ, синтез хийх, харьцуулах системчлэх үйл ажиллагаа
- Зүй тогтол хуулиудыг ухамсарлах, шалтгаан үр дагаврын холбоог ойлгосон эсэх
- Мэдлэг чадвараа ашиглах байдал
- Бие даан практик үйл ажиллагаанд орох, үүссэн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвар
- Өөрөө өөрийгөө хянах оношлох байдал

6. Цаг ашиглалтын байдал

- Хичээлийн үе шат бүрт зарцуулсан хугацаа
- Багшийн (ярих, бичүүлэх, тайлбарлах) үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа
- Сурагчийн (бие даан болон хамтран ажиллах, ярих, бичих, тайлбарлах) үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа
- Дидактик алхмуудад зарцуулсан хугацаа нь тохирсон эсэх

7. Сургалтын хэрэглэгдэхүүн

- Сургалтын ямар хэрэглэгдэхүүнийг ашигласан
- Сургалтын агуулга, дидактик зорилтод нийцэж байгаа эсэх
- Сурагчийн мэдлэг бүтээхэд дэмжлэг болж байгаа байдал
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
- Өнгө, үзэмж, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал
- Бодитой, үр дүнтэй хэрэглэсэн эсэх.

Ажиглах зүйлийг ийнхүч хуваарилан ажиглах хэдий ч, тухайн зүйлд л зөвхөн хязгаарлагдах нь зохисгүй. Жишээлбэл, цаг ашиглалтыг ажиглах үүрэгтэй хүн зөвхөн цагаа л хараад хичээлийн ерөнхий байдлыг харахгүй өнгөрөх нь буруу юм. Цаг ашиглалтыг голчлон ажиглангаа хичээлийн ерөнхий байдлыг харах хэрэгтэй. Учир нь хичээлийн ерөнхий байдлыг харалгүйгээр хичээлийн сайн, муу мэдрэх боломжгүй бөгөөд ажиглагчдад шинэ зүйл суралцах боломжийг ч олгохгүй юм.

За. Багш яаж заах (зохион байгуулах) вэ?

Судалгаат хичээл заах үед хүүхдийн оролцоо идэвх, чадамжаас хамааран бэлтгэл судалгаагаар боловсруулсан төлөвлөлтөө баримтлахдаа уян хатан хандана. Мөн багшийн ур чадвар үүнд маш чухал үүрэгтэй бөгөөд суралцагчдын хурд, чадвараас хамаарч хичээлийн тухайн нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөлтөд өөрчлөлт оруулж, оновчтой шийдвэрийг газар дээр нь гаргах боломжтой юм. Хичээлийн бэлтгэл судалгаанд үндэслэн боловсруулсан төлөвлөлт бол таны хамгийн чухал баримтлах удирдамж бөгөөд хичээлийн үед дидактик шийдлийн шинэ санаа орж ирсэн ч түүнийг шууд хэрэгжүүлэх гэж хэт яарах нь багийн ажлыг үр дүнгүй болгож мэднэ. Магадгүй агшин зуурт орж ирсэн энэ санааг дараагийн, сайжруулсан төлөвлөлтөд тусгах талаар хичээлийн хэлэлцүүлгийн үед хамтран ярилцаарай. Харин хичээлийн төлөвлөлтөд тусгасан “ирэх байх” гэж тооцсон хариу үйлдлээс

ялгаатай хариулт, хариу үйлдэл, асуулт, шийдэл сурагчдаас гарч ирвэл зайлшгүй богино хугацаанд оновчтой шийдэл гаргах хэрэгтэй болно. Энд багшаас хурд, ур чадвар, академик мэдлэг зэрэг олон талын мэдлэг, чадвар шаардсан нөхцөл байдал үүсч мэднэ.

“Сурагчдын суралцах үйл ажиллагааг дэмжсэн арга зүй” бүхий судалгаат хичээлийг задлан шинжлэх замаар арга зүйгээ хөгжүүлэх нь бидний зорилго болохыг дахиад нэг саная. Суралцагч нэг удаагийн үйлдлээр арга, арга зүйд суралцахгүй гэдэгтэй хэн ч маргахгүй. Түүнтэй нэгэн адил багш нэг удаагийн 40 минутын хичээлээр тодорхой нэг арга зүйг бүрэн хэрэгжүүлж, эзэмшиж бас чадахгүй. Жишээлбэл, сорил туршлагаар мэдлэг бүтээх арга зүйг хөгжүүлэх зорилготой хичээлийн судалгаа эхлүүлж байна гэж үзье. Тэгвэл хамгийн эхний судалгаат хичээлээр сурагчдын ажиглах, ажигласан зүйлээ бүтэн өгүүлбэрээр илэрхийлэх, таамаглал дэвшүүлэх, сорил туршилт гүйцэтгэх суурь чадварыг ажиглаж болно. Эндээс ангийн нийт сурагчдын сорил туршилтын чадварын ерөнхий түвшнийг тогтоож, дараа дараагийн сорил туршилттай хичээлээр юу юунд анхаарах чиглэл тодорно. Эдгээр асуудлыг тусгаж төлөвлөсөн хэдэн цагийн хичээл орсны дараа хоёр дахь судалгаат хичээлээр ажиглагчид сурагчдын сорил туршилт гүйцэтгэх чадварт гарсан өөрчлөлт, багшийн сорил туршилттай хичээлийг зохион байгуулах арга зүйд гарсан хөгжил, багш сурагчид харилцан арга эвээ хялбархан олдог болж үйл ажиллагаа нь хэр зэрэг нэгдмэл болсон гэх мэт хөгжлийг илрүүлэх боломжтой болно. Улмаар зорилгоо нарийвчилж сорил туршилтын тодорхой чадвар эзэмшүүлэх арга зүйг хөгжүүлэхээр дараагийн судалгаат хичээлийг төлөвлөж болно. Чухам яаж нарийвчлах нь тухайн сургуулийн онцлогтой байж болно.

Байгалийн ухааны хичээлүүдэд сорил туршилт маш чухал бөгөөд сорил туршилттай хичээл нь багшаас тусгай онцлогтой бэлтгэл, арга зүй, боловсруулалтыг шаарддаг. Энэ мэтчилэн тухайн хичээл бүр өөрийн онцлогтой учраас харгалзах судлагдахууны модулиудаас хичээлээр юуг яаж заах (зохион байгуулах) талаар дэлгэрүүлэн уншиж судлаарай.

Нэгдүгээрт, хичээлийн бэлтгэл судалгааны цр дцнд боловсруулсан хичээлийн төлөвлөлтийг аль болох бүрэн хэрэгжүүлэх, мөн хичээлийн явцад сурагчдын хариулт, гүйцэтгэл зэргээс хамааран тухайн нөхцөл байдалд нийцүүлэн оновчтой шийдвэрийг газар дээр нь гаргахын харьцааг зохистой барих нь зүйтэй юм.

Хоёрдугаарт, Тухайн суралцах үйл ажиллагаанд сурагч зөвхөн 1 удаагийн 40 минутын хичээлээр бүрэн суралцана гэж байдаггүй. Иймд тодорхой арга зүйг багш, сурагч хоёр харилцан нэгдмэл үйл ажиллагаа болгож чадтал хэд хэдэн хичээлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж сурагчдын эзэмшиж буй байдлыг судлахыг зориорой.

Зөвлөгөө:

Багш яаж заах (зохион байгуулах) вэ?


- Сурагчдаар мэдлэг бүтээлгэх
- Сурагчдын бүтээлч үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

Ажиглагч яаж ажиглах вэ?

- Хичээлийн явцыг ажиглаж, протокол хөтлөх
- Оногдсон үүрэг чиглэлийн дагуу ажиглалтын хуудсаа бөглөх
- Тоон үнэлгээг тэмдэглэх, тайлбарлах
- Чанарын үнэлгээ хийх, тайлбар бичих
- Суралцагчдад илэрч буй өөрчлөлтийг тэмдэглэх
- Сайн талыг тэмдэглэх
- Сул талыг тэмдэглэх
- Сайжруулах арга замыг тэмдэглэх

36. Ажиглагч яаж ажиглах вэ?

Ажиглалт хийхдээ хичээлийн бэлтгэл судалгаанд суурилж хичээлийн судалгаа хийх тул зөвхөн 40 минутын хичээлийг биш хичээлийн бэлтгэлд анхаарлаа хандуулан хичээлийн бүхэлд нь ажиглах ёстойг сануулна. Хичээлийн бэлтгэл хэр хангагдсанаас тухайн хичээлийн чанар, үр дүн харагдах учраас хичээлд ажиглалт хийхийн өмнө тухайн багшийн хичээлийн хөтөлбөртэй урьдчилан танилцсан байвал зүгээр. Учир нь, тухайн хичээлээр анх дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг мэдэж байх нь өөрийн ажиглаж буй зүйлийг бүрэн гүйцэд илрүүлж, хэлэлцүүлэгт бэлтгэхэд тустай. Болж өгвөл багшийг хичээл зааж байхад нь хөтөлбөрийг нь хамт тулгаж яваад яг аль хэсэгт нь алдаа гарч байна, түүнийг арай өөрөөр хэрхэн хийж болох байсан талаар саналаа бичээд явбал зүгээр.



Учир нь хичээл дууссаны дараа зарим алдаанууд мартагдах магадлалтай. Мөн хичээлийн үед хэрэглэх гэж байгаа тарааж өгөх материал, сорил туршилтын заавар зэрэгтэй урьдчилан танилцсан, ажиглалт эхлэхийн өмнө хичээлийн үед онцолж ажиглах зүйлээ ялгаж тэмдэглэсэн, хичээлийн явцад багш хэрхэн хэрэглэж байгааг, сурагчид хэрхэн ойлгож яаж хэрэглэж байгааг хамтад нь тулгаж тэмдэглэх нь зүйтэй юм. Судалгаат хичээлийн гол утга учир нь хичээлийн бэлтгэл судалгааг яавал сайтар хангаж хичээлийг үр дүнтэй цаашид заах вэ гэдгийг илрүүлэхэд оршино. Улмаар багш өөрөө хөгжиж, тэгснээр сурагчид хөгжих болно.

Ажиглагч багш бүр өөр өөрийн үүргийн дагуу болон хичээлийг ерөнхийд нь ажиглаж байх үедээ хичээлийн протокол (ХИЧЭЭЛИЙН ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС-ыг үзнэ үү)-ыг хөтлөнө. Хичээл ажиглагчийн хэрэглэдэг үндсэн хэрэглэгдэхүүн болох суудлын план зураг (сурагчийн үйл ажиллагааг тэмдэглэх), хоёр баганатай хүснэгт (багш ба сурагчийн асуулт, хариулт, үйл ажиллагааг тэмдэглэх) нь хичээлийн явцын тэмдэглэл хөтлөх хуудсанд тусгагдсан байдаг бөгөөд түүнийгээ цагтай бичгийн тавцан (хичээлийн үеийн цаг ашиглалтыг хянах) дээр тавиад олон өнгийн бал (баримт, өөрийн бодол, чухал зүйлсийг ялган тэмдэглэх)-аар ялган тэмдэглэх нь ажиглалтыг чанартай, үр дүнтэй хийхэд их тустай.

Энэ хуудас дээр багш, сурагчийн үйл ажиллагааг болон тухайн үед гарч байсан алдаа, оноотой зүйлийг сайтар тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь хичээлийн судалгааны ажиглалтын бусад хуудсыг (төслийн 1-р шатанд хэрэглэж байсан үнэлгээний В хуудас буюу 55-р хуудас дахь Ажиглалтын хуудасны загвар 1, эсвэл тусгайлан боловсруулсан ажиглалтын хуудсууд буюу 57-60-р хуудас дахь Ажиглалтын хуудасны загвар 2-5) бөглөхөд болон хэлэлцүүлэгт хэрэг болно. Бүх үйл ажиллагааг нэг бүрчлэн бичнэ гэхээсээ илүү гол анхаарах ёстой, цаашид анхаармаар зүйлийг тэмдэглэж явах нь оновчтой. Бүх үйл явцыг бүтэн бичнэ гэвэл цаг алдахын зэрэгцээ зарим зүйлийг анзааралгүй үлдэх магадлалтай байж болох юм.

Суудлын план зургийг тухайн ажиглагч энгийн байдлаар хөтлөхөөс (ХИЧЭЭЛИЙН ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАСТ үзүүлснээр) гадна тухайн ангид хичээл заадаг, сурагчдаа судалсан багш нь ажиглагч багш нарт зориулж суудлын план зураг дээр сурагчийн хөгжил, сүүлийн үед гарсан ахиц, өөрчлөлт зэрэг шаардлагатай мэдээллийг өгч болно. Япон багшийн боловсруулсан суудлын план

зурагт сурагчийн талаар тодорхой мэдээлэл тусгасан жишээг дараах зургаар үзүүлээ.

	Хата: Бодол нь түрүүлээд, яриа нь замбараагүй болоод байдаг учир найз нөхөдтэй болж чадаагүй. 2-р улирлын зорилтоо “Найзуудтай болох” гэж бичсэн	Асамино: 9 сарын 2-р долоо хоногоос хичээл сурлагад томоохон өөрчлөлт гарсан. Идэвхтэй болж, анхаарлаа төвлөрүүлэх болсон.
	Шиотани: Хичээлийн дараа өгдөг дэвтэр, карт хоёроо хараад сонсох, бичих чадвар сайн байгаагаа мэддэг. Үүнийгээ харилцан яриандаа илэрхийлдэг.	Ишикава: Томоохон экскурсийн үеэр ахлагч болж үзсэнээр хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн. Экскурсийн үед хүүхдүүд яриаг нь сонсохгүй байх хэцүү байдгийг мэдэрсэн.

Хичээлийн хэлэлцүүлэгт бэлтгэх нь нэг талаас ажиглалтын хамгийн сүүлийн алхам, нөгөө талаас хэлэлцүүлгийн эхлэл юм. Энэ үед ажиглагчид ганцаарчлан ажиллаж ажигласан зүйлээ нэгтгэн цэгцлэх ёстой байдаг.

Ажиглалт хичээл дууссаны дараа хэдэн минутын хугацаанд хичээлийн тэмдэглэл бичсэн протоколын хуудас болон өөрийн санаанд байгаа зүйл дээрээ түшиглэн ажиглалтын хуудас (55-59-р хуудас дахь Ажиглалтын хуудасны загвар 1-5)-ыг бөглөнө.

Төслийн 1-р шатанд ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудас хөтөлдөг байсан. Энэ хуудас нь тухайн хичээлийн элемент нэг бүрийг нарийн задлан шинжлэхэд ихээхэн тустай байдгийг ажиглагчид тэмдэглэн ярьдаг. Гэхдээ сургуулийн түвшний хичээлийн судалгаа нь хичээлд оноо өгч, дүн тавихыг чухалчилж үздэггүй учраас энэ хуудасны үнэлгээ өгдөг хэсгийг орхиод тухайн шалгуур үзүүлэлтээр хичээлд хийсэн задлан шинжилгээ, олж илрүүлсэн зүйлээ чанарын тэмдэглэл байдлаар тэмдэглэж болно. Оноо өгөхөд, 1-рт багш нарт хүндрэлтэй /хэдэн оноо тавих нь шийдэхэд хугацаа, харьцуулалт шаарддаг/, 2-рт, судалгаат хичээл гэхээсээ илүү уралдаан тэмцээний шинжтэй болгох магадлалтай, 3-рт, уламжлалт нээлттэй хичээл рүү хазайж магадгүй гэх зэрэг сөрөг талтай байдаг. Мөн энэ хуудасны зарим шалгуур үзүүлэлт зарим төрлийн хичээлд төдийлөн тохирохгүй байх тохиол гардаг. Иймд тухайн хичээлд анализ хийх шалгуур үзүүлэлтээ ажиглалтаас өмнө харилцан хэлэлцэж тогтоосон байвал зохино.

Тухайн хичээлийн онцлог, хичээлийн судалгааны зорилгоос хамааран багаараа хэлэлцээд тохирох ажиглалтын хуудсуудыг боловсруулж хэрэглэхийг зөвлөж байна. Энд жишээ болгон ХИЧЭЭЛИЙН ЯВЦАД СУРАГЧДАД ИЛЭРЧ БУЙ ИЛРЭЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН (ЧАДВАРААР), ХИЧЭЭЛИЙН ЕРӨНХИЙ АЖИГЛАЛТЫГ ТЭМДЭГЛЭХ ХУУДАС, СУРАГЧДЫН ГАРГАЖ БУЙ АЛДААГ АЖИГЛАХ (ХИЧЭЭЛИЙН ЭЛЕМЕНТЭЭР) хуудсыг үзүүлээ.

Хичээлийн хэлэлцүүлгийн үед ажиглагчид санаа давхардсан зүйлийг хэлэхгүй гэсэн зарчмаар явдаг учраас хэлэлцүүлэг эхлэхээс өмнө ХИЧЭЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС-тай ижил үзүүлэлт бүхий хуудас ХИЧЭЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС (ГАНЦААРЧИЛЖ АЖИЛЛАХ)-ыг ганцаарчлан хөтлөх нь хичээлийн судалгааны баг хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн арга зүйгээ сайжруулахад чухал эх сурвалж болдог.


ХИЧЭЭЛИЙН ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС

1. Үндсэн мэдээлэл

Хичээлийн нэр:
 Сэдэв:.....
 Огноо:
 Анги, бүлэг: Сурагчийн тоо: ...
 Эхэлсэн:цаг, Дууссан:цаг

Хичээл заасан багшийн нэр:
 Ажиглалт хийсэн хүний нэр:
 Ажиглагчийн албан тушаал/
 мэргэжил:

Ангийн план зураг



1. Хичээлийн явцын тэмдэглэл

Хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа	Сурагчийн үйл ажиллагаа	Ажиглагчийн санал, сэтгэгдэл

Ажиглалтын хуудасны загвар

1. Ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудас

Үнэлгээний шалгуур үзүүлэлт			Үнэлгээ					Үнэлгээний бодит шалтгаан
Эхлэл Удиртгал	1	Сэдэл төрүүлж сонирхол татсан байдал	5	4	3	2	1	
	2	Хичээлийн зорилтыг дэвшүүлсэн байдал	5	4	3	2	1	
Агуулга	3	Хичээл болон сэдэв хоорондын залгамж холбоог хангасан байдал	5	4	3	2	1	
	4	Амьдралтай холбосон байдал (түүх, соёл)	5	4	3	2	1	
	5	Агуулгын оновчтой байдал (энгийн, нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх)	5	4	3	2	1	
Аргазүй	6	Сургалтын аргыг сонгосон байдал	5	4	3	2	1	
	7	Багшийн асуултаа томъёолсон байдал (мэдлэг бүтээх үйл ажиллагааг дэмжиж байгаа эсэх, сурагчдад ойлгомжтой, оновчтой, энгийн)	5	4	3	2	1	
	8	Суралцагчдыг сурах аргад сургаж байгаа байдал	5	4	3	2	1	
Хэрэглэгдэхүүн	9	Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгосон байдал (мэдлэг бүтээхэд дэмжлэг болж байгаа эсэх, агуулгад нийцсэн эсэх, суралцагчдад ойлгомжтой, хүртээмжтэй эсэх)	5	4	3	2	1	
	10	Сургалтын хэрэглэгдэхүүний шаардлага хангасан байдал (өнгө, хэмжээ, харагдах байдал, аюулгүй ажиллагааг хангасан эсэх)	5	4	3	2	1	
	11	Самбарыг хичээлийн агуулга, сурагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагааг холбохуйцаар хөтөлсөн байдал (хүүхдийн бодол санааг тусгаж байгаа эсэх)	5	4	3	2	1	
	12	Суралцагчид хичээлийн тэмдэглэлийг хөтөлж байгаа байдал	5	4	3	2	1	

Хугацаа	13	Цаг хуваарилалт (дидактик алхмуудтай нийцэж байгаа эсэх, цагтаа багтсан эсэх)	5	4	3	2	1
	14	Сурагчдад бодох хугацаа хангалттай өгч байгаа эсэх, хариулт ирэх хугацааг тохируулж байгаа байдал	5	4	3	2	1
Харилцаа	15	Багш, сурагчийн суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй байдал (нийт сурагчдад хүртээмжтэй эсэх, сурагчийн санал бодол, хариулт сонголтонд хүндэтгэлтэй хандсан эсэх)	5	4	3	2	1
	16	Сурагчийн буруу ойлгосон тохиолдолд багшийн зүгээс учир шалтгааныг анзаарч байгаа байдал	5	4	3	2	1
	17	Суралцагчдын бие даан болон хамтран ажиллаж байгаа байдал	5	4	3	2	1
Үнэлгээ дүгнэлт	18	Үнэлгээний хэлбэрийг оновчтой сонгосон байдал (бодитой хүртээмжтэй)	5	4	3	2	1
	19	Хичээлийн дүгнэлтийг оновчтой сонгосон байдал (бодитой, хүртээмжтэй)	5	4	3	2	1
	20	Суралцагчдын сэтгэл хангалуун байдал	5	4	3	2	1

Ажиглалтын хуудасны загвар**2. Хичээлийн явцад сурагчдад илэрч буй илрэл, түүний шалтгаан (чадвараар)**

Хичээлийн нэр		Огноо	
Хичээлийн сэдэв			
Хичээл заасан багшийн нэр		Эхэлсэн цаг Дууссан цаг	
Ажиглагчийн нэр		Анги, бүлэг	
Албан тушаал			
Ажилласан жил		Суралцагчийн тоо	

Чадвар	Суралцагчдад илэрч буй илрэл	Шалтгаан
Асуултад хариулж буй байдал		
Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх		
Тэмдэглэл хөтлөх/ Дэвтэр хөтлөлт		
Хамтран ажиллах		
Бие даан ажиллах		
Мэдээлэлтэй ажиллах/ ТӨМ-тэй ажиллах		
Туршилтын багажтай ажиллах/ Спиртэн дэнтэй ажиллах		
Шил сав суулгатай харьцах		
Сорилын үйлийг гүйцэтгэх/Халаах		
Аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж буй байдал		

Ажиллалтын хуудасны загвар

3. Хичээлийн ерөнхий ажиглалтыг тэмдэглэх хуудас

Сэдэв: Анги: ... Заасан багш:

Ажигласан чиглэл: (ерөнхий, сонгосон сурагч, баг, бусад)

Хичээлийн элемент	Сурагчдад илэрч буй өөрчлөлт (ажиглалт)	Дүгнэлт
Сэргээн санах		
Сэдэл үүсгэх үе		
Асуудлыг таних		
Таамаглал дэвшүүлэх		
Таамаглалаа туршилтаар шалгах		
Багатгах		

Дүгнэлт

Үзүүлэлт	Тэмдэглэл
Хичээлийн давуу тал	
Хичээлийн сул тал	
Сул талыг сайжруулах арга зам	

Ажиглагч

Ажиглалтын хуудасны загвар

4. Сурагчдын гаргаж буй алдааг ажиглах
(хичээлийн элементээр)

Хичээлийн нэр		Огноо	
Хичээлийн сэдэв			
Хичээл заасан багшийн нэр		Эхэлсэн цаг:	Дууссан цаг:
Ажиглагчийн нэр		Анги, бүлэг	
Албан тушаал			
Ажилласан жил		Суралцагчийн тоо	

Хичээлийн элемент	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа, алдаа, шалтгаан
Сэргээн санах		
Сэдэлжүүлэх		
Мэдлэг бүтээх (Таамаглал дэвшилчлэх)		
Мэдлэг бүтээх (Таамаглал шалгах/ туршилт гүйцэтгэх)		
Мэдлэг бүтээх (Туршилтын үр дүнг боловсруулах)		
Мэдлэг бүтээх (Туршилтын үр дүнг боловсруулалтад үндэслэн дүгнэлт гаргах)		
Гэрийн даалгавар өгөх		

Ажиглалтын хуудасны загвар

5. Хичээлийн хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөх хуудас
(ганцаарчилж ажиллах)

Хичээлийн нэр: Анги, бүлэг: Огноо:

Хичээлийн сэдэв:

Хичээл заасан багшийн нэр:

Хэлэлцүүлэгт оролцсон ажиглагчид:

Ажиглагчийн нэр

Албан тушаал

Явцын тэмдэглэл:

Заасан хичээлийн хувьд оновчтой болсон зүйл, түүний шалтгаан	
Заасан хичээлийн хувьд дутагдалтай болсон зүйл, түүний шалтгаан	
Сурагчдад гарч буй илрэл	
Төлөвлөсөн хичээлийн давуу тал, түүний шалтгаан	
Төлөвлөсөн хичээлийн сул тал, түүний шалтгаан	
Сайжруулах боломжийн талаар таны санал	

2.2.3. Хичээлийн хэлэлцүүлэг, хэлэлцүүлэг зохион байгуулах

Хичээлийн хэлэлцүүлэг

Хичээлийн судалгаа хийх орчилт үйл явцын нэг нь хичээлийн хэлэлцүүлэг юм. Хичээлээ хэр сайжруулах нь хэлэлцүүлгийг хэрхэн явуулахаас нэлээд хамааралтай болох нь туршилтын үед ажиглагдаж байлаа. Энэ талаар төслийн байгалийн ухааны дидактикийн зөвлөх Токио Гакүгэй их сургуулийн зөвлөх профессор Фүкүчи Акитэрүгийн өгсөн зөвлөгөөг эш татан танилцуулъя.

...багш хичээлээ өөрчилснөөр өөрөө, улмаар хцүхдцүд ч бас өөрчлөгдөж байгааг мэдрэх нь гол зорилго болно. Мөн яагаад заах аргаа өөрчлөх ёстой талаар ойлгох нь чухал.

“Хичээлийн судалгаа” - сургуульд эрдэм шинжилгээний ажил явуулах гэсэн цг бөгөөд энэ нь хичээлийг зүгээр л нэг явуулахаар зогсохгүй хичээлийн ажиглалтад өөрчлөлт оруулахгүй бол бодит болж чадахгүй ээ. Японы хувьд, ямар ч сургуульд судалгааны баг зохион байгуулагдсан байдаг бөгөөд “хичээлийн судалгаа”, “хичээлд бэлтгэх судалгаа”-г ашиглан хичээлийн чанарыг сайжруулахад үнэн санаанаасаа чармайн ажилладаг. “Хичээлийн судалгаа” өдөр тутамд явагдаж байдаг юм.

...Хичээлийг бүтээж бий болгоно гэдэг нь агуулга (хичээлийн хэрэглэгдэхцүнийг оруулан), хичээлийг явуулах арга (багшийн сонгох заах арга) болон сурч байгаа сурагч агуулгатай холбоотой мэдлэг болон танин мэдэхцүн нөхцөл гэсэн гурван хүчин зүйл болно. Энэ хүчин зүйлийг тодорхой болгон, хичээлийг шинжлэн, илцү сайн хичээлийг бий болгох нь хичээлийн судалгааны хэлэлцүүлэг хийсний дүнд биелнэ.

Агуулга, хичээлийн хэрэглэгдэхцүн болон сурагчдын бодит чадварт голлон анхаарч “хичээлд бэлтгэх судалгаа”-ны чухлыг сайн ойлгон судлах аргаа харилцан мэдэх нь чухал юм. Судалгааны хичээлийг явуулах багш хэр зэрэг бэлтгэл судалгаа хийсэн нь хичээл дээр харагддаг. Хцүхдийн алдаа болон танин мэдэхцүн тцвшнийг (өсөлт хөгжил) мэдэх нь хичээл явуулахад чухлаас гадна тэрээр хэр зэрэг гцнзгий мэдэж байгаагаас хамаарч хичээл цр дцнтэй эсэх нь шийдэгдэнэ. Тэдгээр нь хичээлийн дараа шууд явуулах хэлэлцүүлэг дээр шалгагдана (хичээлийн мониторинг чухал болох нь). Хэлэлцүүлгийн хувьд, бүх хүн (удирдаж байгаа хүн, хичээл явуулсан багш, ажиглагч багш) “хэрвээ би энэ хичээлийг заасан бол ингэх байсан” гэж хандах хэрэгтэй. Хичээлийг зөвхөн шцүмжлэх бус бүтээлч санал санаа гаргах нөхцөлийг бий болгохоор хичээх хэрэгтэй юм.

Зорилт нь хэсэг хэсэг тус бүрийн бичигдсэн бөгөөд эцсийн эцэст нэг төрлийн жишээ учраас зорилтоо улам нэмэгдүцлэн судлах нь тохиромжтой.

Хичээлийн хэлэлцүүлгийн үр дүнгээр багш хичээлээ боловсронгуй болгоод дахин хичээлийн судалгаа хийх замаар хөтөлбөрөө хөгжүүлэх үйл ажиллагаа явуулна. Ер нь хичээлийн судалгааны нэг хэсэг болох хэлэлцүүлгийг хэр оновчтой, үр дүнтэй зохион байгуулснаас хичээлийн судалгааны үр дүн шууд хамаарна.

Хэлэлцүүлэг нь хичээлийн үйл явцыг ажиглахтай шууд холбоотой ч, хэлэлцүүлэг

хэр үр дүнтэй болох нь юуны түрүүнд оролцогчид тухайн судалгаат хичээлийн бэлтгэл судалгаа болон хөтөлбөртэй хэр танилцсанаас шууд хамаарна. Иймээс хэлэлцүүлэг зохион байгуулахын өмнө хэлэлцүүлэг хийх зорилго, зорилтоо тодорхой болгох, арга хэлбэрээ сонгох, зохион байгуулах менежментээ урьдчилан төлөвлөх хэрэгтэй болдог.

Үүнээс гадна ХЭН? (хөтлөгч, багш нар, менежер, зөвлөх багш г.м. оролцогчид), ЮУГ? (хичээлийн явцын алдаа оноо, эрсдэл, түүнийг даван туулах арга зам, дидактик шийдэл), ХААНА? (сэтгэлзүйн таатай орчинд), ЯАЖ? (ээрэг хандлага, авах гээхийн ухаанаар) ярих вэ? зэргийг харгалзах нь чухал.

Хичээлийн хэлэлцүүлгийн зорилго, арга хэлбэр

Бид ямар зорилготой, ямар түвшний хичээлийн судалгаа зохион байгуулах вэ?, Хэн хэн хичээлийн судалгаанд оролцох вэ? гэдгийг харгалзан хичээлийн судалгааны зорилгоо тодорхойлох ба хичээлийн судалгаа хийх зорилгоос хамааран хэлэлцүүлгээр ярилцах асуудал буюу хэлэлцүүлэг хийх зорилгоо тодорхойлно. Хичээлийн судалгааны зорилго нь ямар чиглэлийн хичээлийн судалгааг, зохион байгуулалтын ямар түвшинд (хүснэгт 2) хийхээс хамааран дараах байдлаар томъёологдож болох юм.

Хүснэгт 1.

Хичээлийн судалгааны түвшин ба зорилго

№	Хичээлийн судалгааны чиглэл	Зорилго	Түвшин
1	Сайн хичээлийн туршлага судлах – Туршлагатай багш нар залуу багш нартаа сургах – Залуу багш нар туршлагатай багш нараасаа санал зөвлөмж авах – Ижил түвшний багш нар бие, биеэсээ суралцах	• Тухайн хичээлийн арга зүйн мөн чанарыг таниулах • Шинэ арга зүйг олж судлах • ...	• Сургууль • Дүүрэг, аймаг/нийслэл • Улс
2	Зохионбайгуулагдсан хичээлийн арга зүйг сайжруулах, залуу багшийг хөгжүүлэх	• Багш ажлын байран дээрээ мэргэжил дээшлүүлэх • Сургуулийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх (сурагчдын ажиглах чадварыг хөгжүүлэх, ...)	• Сургууль • Дүүрэг, аймаг/нийслэл • Улс
3	Хичээлийн судалгаа хийх аргад суралцах	• Мэргэжил дээшлүүлэх	• Сургууль • Дүүрэг, аймаг/нийслэл • Улс
4	Хэрэглэгдэхүүний судалгаа хийх, турших	• Судлаачийн түвшинд судалгааны ажил хийх, сургалтын болоод бусад судалгааны материал боловсруулах	Их дээд болон ЕБС-ийн түвшинд
5	Бусад		

Жишээ -1

Хичээлийн судалгаагаа сайн хичээлийн туршлага судлах зорилгоор зохион байгуулсан үед тухайн хичээлийн арга зүйн мөн чанарыг таниулах зорилгын хүрээнд хичээлийн:

1. Бүтэц, зохион байгуулалт
2. Зорилго, зорилт
3. Дидактик шийдэл
4. Хичээлийн элементүүд
5. Хэрэглэгдэхүүн, түүний шийдэл
6. Суралцахуйн үйл ажиллагаа
7. Асуулт, хариулт гэх мэтийн талаар урьдчилан судалж, дүгнэлтээ гаргах, хичээлээ ажигласны дараа бусдын дүгнэлттэй харьцуулан дүгнэх зэргээр хэлэлцүүлгийг хийж болох ба үүнд зөвлөх багш, багийн ахлагчийн гүйцэтгэх үүрэг хамгийн чухал.

Жишээ- 2

Хичээлийн арга зүйг сайжруулах, залуу багшийг хөгжүүлэх чиглэлтэй хичээлийн судалгаа зохион байгуулах үед оролцогчид бие биенээсээ харилцан суралцах боломжийг олгох зорилгыг дэвшүүлж болох ба оролцогчдын хамтын үйл ажиллагаанд тулгуурласан, оролцоонд суурилсан аргыг сонгож хэлэлцүүлгийг зохион байгуулж болох юм. Үүнд оролцогчид бие биенээсээ харилцан суралцах боломжийг олгох зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж болно.

- Хичээлийн төлөвлөлт ба хэрэгжилтийг харьцуулан, алхам бүрээр харилцан санал солилцож, тайлбарлуулах, хүрсэн үр дүнд үндэслэн зөвлөх багш, багийн ахлагч чиглүүлэх, дүгнэх
- Оролцогч бүр дидактик шийдлээ хувилбар болгон дэвшүүлэх

Жишээ- 3

Хичээлийн судалгаа хийх аргад сургах чиглэлтэй хичээлийн судалгааг зохион байгуулах үед оролцогчдыг хэлэлцүүлэгт бүтээлчээр оролцох арга барилд сургах, хэлэлцүүлгээс өөртөө хэрэгтэй санааг олуулах зорилгын хүрээнд дараах хоёр үйл ажиллагааг зохион байгуулах нь ач холбогдолтой байсан юм. Үүнд: 3

Үйл ажиллагаа- 1

Төлөвлөсөн хичээлийн боловсруулалт, заасан явцын:

- Давуу тал, түүний учир шалтгаан
- Сул тал, түүний учир шалтгаан
- Сул талыг сайжруулах арга зам зэргийг оролцогчдын ганцаарчилсан болон багийн үйл ажиллагаагаар тодорхойлох аргаар хэлэлцүүлгийг зохион байгуулсан үед оролцогчдын гүйцэтгэх үүрэг, бүтээлч оролцоо чухал байх ба хамтран ажиллах үед өөрсдийн гаргасан санал, дүгнэлт, шийдлүүдийг харьцуулах хэрэгтэй.

Үйл ажиллагаа -2

Хэлэлцүүлгийн үед оролцогчдын гаргасан бүтээгдэхүүнд анализ хийх

Үйл ажиллагаа -1

Заасан хичээлд анализ хийж, шинээр төлөвлөсөн хичээлийн боловсруулалт нь

үнэхээр тухайн хичээлийн хувьд зөв тодорхойлогдож чадсан эсэх,

- Давуу тал болж буйн учир шалтгааныг зөв тодорхойлж, тайлбарлаж чадсан эсэх, оролцогчид өөртөө хэрэгтэй санаа олж авахад дэмжлэг болохуйц хэмжээнд, ойлгомжтой, нарийвчлан томъёолж чадсан эсэх (хэт ерөнхий байна уу, эсвэл ямар давуу талын шалтгаан болж байгаа нь тодорхой бичигдсэн байна уу гэх мэт)
- Заасан хичээлийн явц, төлөвлөсөн хичээлийн боловсруулалтын сул тал нь тухайн хичээлийн хувьд үнэхээр сул тал болж чадаж байгаа эсэх,
- Сул тал болж буйн учир шалтгааныг зөв тодорхойлж, тайлбарлаж чадсан эсэх, оролцогчид өөртөө хэрэгтэй санаа олж авахад дэмжлэг болохуйц хэмжээнд ойлгомжтой, нарийвчлагдан томъёологдож чадсан эсэх (хэт ерөнхий байна уу, эсвэл ямар сул талын шалтгаан болж байгаа нь тодорхой бичигдсэн байна уу гэх мэт)
- Сул талыг арилгах арга замыг тодорхойлохдоо хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад бодит дэмжлэг болох эсэх, хэрэглээ болох эсэх, сайжруулах аргыг оновчтой тодорхойлсон эсэх, маш тодорхой томъёолж чадсан эсэх

Энэ арга хэлбэрээр хэлэлцүүлгийг зохион байгуулах үед зөвлөх багш, багийн ахлагчдын чиглүүлэг, гүйцэтгэх үүрэг, оролцоо чухал ба зөвлөх багш, багийн ахлагчийн тавьсан асуулт, санал, дүгнэлтийн хүрээнд оролцогчид хамтран, “Үйл ажиллагаа-1”-ийн үр дүнд гарсан бүтээгдэхүүнээ эргэн харах, өөрсдийн тодорхойлсон тухайн шийдлүүдийг харьцуулан дахин судлах нь чухал байдаг. Энэ нь хичээлийн судалгааны зорилгын биелэлтэд чухал ач холбогдолтой болно. Жишээ нь, хичээлийн хэлэлцүүлгээр багшийн заасан хичээлийн арга зүй, төлөвлөлтийн:

- Давуу талыг тодруулах, тайлбарлах
- Сул талыг тодруулах, тайлбарлах
- Сул талыг сайжруулах арга замыг тодруулах, тайлбарлах

зэрэг үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар тогтмол хэрэгжүүлэх нь багшийн заах арга зүйг хөгжүүлж, улмаар сурагчдын суралцахуйд дэмжлэг болох чухал ач холбогдолтой юм.

Хичээлийн хэлэлцүүлэг хийх хэлбэр, хэрэглэгдэхүүн

Хичээлийн хэлэлцүүлгийг ямар зорилгоор хэрхэн хийх тухай дээр өгүүлсэн жишээнээс үзвэл, ямар зорилгоор, ямар асуудал хэлэлцэх вэ? гэдгээс хэлэлцүүлэг хийх аргаа сонгох нь илүү тохиромжтой байна. Гэхдээ тодорхой зорилгын хүрээнд тодорхой арга ашиглан хичээлийн судалгааг зохион байгуулахдаа судалгаат хичээлд ажиглалт хийсэн материалдаа тулгуурлан хэлэлцүүлэг зохион байгуулж болохоос гадна зарим тохиолдолд тухайн хичээлийн видео бичлэгт (Хичээлийг бүтэн бичсэн видео бичлэг байвал бүр сайн.) ажиглалт хийж хэлэлцүүлгийг зохион байгуулж болно. Ямар ч тохиолдолд хичээлийн ажиглалт, хэлэлцүүлгийн хуудас болон бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулж хэрэглэх хэрэгтэй болно. Хичээлийн ажиглалт, хэлэлцүүлгийн хуудсыг боловсруулахдаа хичээлийн судалгаа хийж буй зорилго болоод заах хичээлийн арга зүйн төлөвлөлтийн онцлог, ажиглалт судалгаа хийх чиглэл зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Тухайлбал, Зохион байгуулсан хичээлийн арга зүйг сайжруулах, залуу багшийг хөгжүүлэх зорилго бүхий хичээлийн судалгааг зохион байгуулах үед дараах хэлбэрийн ажиглалт хэлэлцүүлгийн хуудсыг боловсруулж болох юм.

САР ӨДӨР		Ажиглагчийн нэр	
Хичээлд судалгаа хийсэн сургуулийн нэр		Анги	
Хичээл		Хичээл заасан багш	
нэгж			
Хичээлийн сэдэв			

1. Хичээл төлөвлөлт

1. Төлөвлөсөн үйл ажиллагаанууд нь хичээлийн зорилготой нийцсэн эсэх?

Маш сайн нийцсэн	Нийцсэн	Зарим нь нийцсэн	нийцээгүй
Тайлбар:			

2. Хичээл системтэй төлөвлөгдсөн үү? (Үе шат нь) ялгагдаж байсан уу?

Маш сайн системтэй	системтэй	Тийм ч их системтэй биш	Системтэй биш
Тайлбар:			

3. Аливаа үйл ажиллагааг (хувь, хос, бүлэг, ангиар) зохион байгуулсан нь оновчтой байсан уу?

Маш оновчтой	Оновчтой	Тийм ч их оновчтой биш	Оновчтой биш
Тайлбар:			

4. Хичээлийн төлөвлөлтөд сурагчийн хариу үйлдлийг хангалттай тооцсон уу? (Сурагчдаас ирэх хариултыг авч үзсэн эсэх, ялангуяа суралцахуйн хүндрэлүүдийг авч үзсэн үү?)

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

5. Сургалтын хэрэглэгдэхүүн (самбар) нь сурагчийн чадварыг шавхахад туслахаар төлөвлөсөн үү?

Маш сайн төлөвлөсөн	Сайн төлөвлөсөн	Тийм ч сайн биш төлөвлөсөн	Төлөвлөгөөтэй биш
Тайлбар:			

2. Хичээлийн ажиглалт

1. Багш хичээлийн зорилгыг сурагчдад ойлгомжтой байдлаар тайлбарлаж чадсан уу?

Маш сайн нийцсэн	Нийцсэн	Зарим нь нийцсэн	нийцээгүй
Тайлбар:			

2. Багш хөтөлбөртөө тулгуурлан сурагчдын суралцах үйл ажиллагааг сайн зохион байгуулсан уу?

Маш сайн	Сайн	Заримдаа сайн	Сайн биш
Тайлбар:			

3. Багш сурагчдад хийх зүйлийг нь ойлгомжтой хэлж өгсөн үү?

Маш сайн	Сайн	Заримдаа сайн	Сайн биш
Тайлбар:			

4. Сурагчид багшийн зааварт хангалттай анхаарал хандуулсан уу?

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

5. Сурагчид өөрийн санаа бодлоо бусадтайгаа идэвхитэй хуваалцсан уу?

Маш идэвхтэй	Идэвхтэй	Тийм ч идэвхтэй биш	Идэвхтэй биш
Тайлбар:			

6. Сурагчид үйл ажиллагаануудад идэвхитэй оролцсон уу?

Маш идэвхитэй	Идэвхитэй	Тийм ч идэвхтэй биш	Идэвхтэй биш
Тайлбар:			

7. Багш сурагчдыг бусадтайгаа саналаа солилцоход нь хангалттай дэмжлэг үзүүлсэн үү?

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

8. Багш сурагчдтай шаардлагатай үед илүү ойр ганцаарчлан ажилласан уу?

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Огт үгүй
Тайлбар:			

9. Багш суралцахуйн зорилгод үндэслэн хичээлээ оновчтой зохион байгуулсан уу?

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

10. Төлөвлөсөн үйл ажиллагаа болон хэрэглсэн хэрэглэгдэхүүн (самбар, ном, тоглоом, карт,... г.м) нь сурагчдыг суралцах үйл ажиллагаанд хангалттай сэдэлжүүлж чадсан уу?

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

11. Багш хичээлээ оновчтой дүгнэж чадсан уу? (Бататгах, үнэлэх, дараагийн хичээлийн тайлбар)

Маш хангалттай	Хангалтай	Тийм ч их хангалттай биш	Хангалттай биш
Тайлбар:			

Хичээлийн хэлэлцүүлэгт ашиглах

Хичээлийн тухай өөрийн бодлоо бичнэ үү

--

Хэлэлцүүлгийн хуудсыг гүйцэд хөтлөх нь хичээлийн арга зүйг сайжруулах чухал баримт болох учраас аль болох бүрэн бичиж тэмдэглэх нь чухал. Үүнээс гадна, манайд нөхцөл байдлыг тооцож үзвэл, хичээлийн бүх явцыг урт цаасан дээр (*Факсын цаас илүү тохиромжтой байлаа.*), эсгий балаар, өөрийн үнэлэлт дүгнэлтгүйгээр, харагдахуйц томоор бичиж хананд байрлуулан хэлэлцүүлэгтээ ашиглах нь олон талын (*хичээлийн аль хэсэгт ямар санал хэлэхээ баримжаалах, цаас, цаг хэмнэх, санал давхардуулалгүй ярих г.м.*) ач холбогдолтой байлаа. Ер нь хичээлийн явцад тухайн нөхцөл байдлаас шалтгаалаад хичээлийн хөтөлбөрөөс хальсан үйл ажиллагаа явагддаг тал бий. Үүнийг алдалгүй тэмдэглэж аваад хэлэлцүүлэгт ашиглах зэрэг ач холбогдолтойгоос гадна хэлэлцүүлэгт биечлэн оролцож амжихгүй (*тухайн цагт хичээлтэй*) багш нар тодруулах асуулт болон хичээлийн яг аль хэсгийг сайжруулах талаар өөрсдийн саналаа наалддаг цаасан дээр бичээд, тухайн хэсэгт нь наагаад явж болно.



Хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулалтын хувьд дараах 2 үе шатаар хэрэгжүүлбэл илүү оновчтой болох нь ажиглагдсан. Үүнд:

1. Нэгдсэн хэлэлцүүлэгт оролцохын өмнөх бэлтгэл
2. Нэгдсэн хэлэлцүүлэг

Оролцогчид, нэгдсэн хэлэлцүүлэгт оролцохын өмнөх бэлтгэл ажлыг сайн хийх нь өөрийн санал бодол, ажиглалтын тэмдэглэлээ цэгцлэх, хэлэлцүүлгийг илүү үр дүнтэй зохион байгуулагдахад тустай. Тухайлбал, тухайн судалгаат хичээлийн арга зүйг сайжруулах, залуу багшийг хөгжүүлэх зорилго бүхий хичээлийн судалгааг зохион байгуулах үед **ХИЧЭЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС (ГАНЦААРЧИЛЖ АЖИЛЛАХ)** хэрэглэж болно.

Түүнчлэн хичээл ажиглалтын явцад бичсэн бичлэг, авсан зураг, оролцогчдын тавьсан асуулт, хариулсан хариулт зэргийг ашиглан хичээлийн хэлэлцүүлгийг өрнүүлэх боломжтой.

Хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулах менежмент

Хэлэлцүүлэгт хэн оролцож байна вэ? гэдэгт үндэслэн хэлэлцүүлгийг яаж зохион байгуулах вэ? гэдгийг шийдвэрлэх хэрэгтэй болно. Иймд хичээлийн нэгдсэн хэлэлцүүлэг явуулах менежментийн талаар Такахата багшийн нэгэн зөвлөгөөг танилцуулъя. Үүнд хэлэлцүүлгийн үед ярих дараалал чухал. Эхлээд хичээл заасан багш, дараа нь ажиглагч багш нар хэлэлцүүлгийн зорилготой уялдуулан (тухайн хичээлийг хэрхэн сайжруулах гэх мэт) өөрсдийн саналаа танилцуулах, эцэст нь зөвлөх багш (их, дээд сургуулийн профессор, арга зүйч, захирал, сургалтын менежер гэх мэт) санал дүгнэлтээ хэлнэ гээд дараах чухал санааг зөвлөсөн юм.

1. Хэлэлцүүлгийн хөтлөгч тэр хичээлийн зорилго болон зорилтын талаар тодорхой ойлголттой байж хэлэлцүүлгийг үр ашигтайгаар зохион байгуулах үүрэгтэй. Ажиглалт хийсэн талаас санаа оноо гарахгүй байгаа тохиолдолд хөтлөгч өөрөө асуудал дэвшүүлж хэлэлцүүлгийг өрнүүлнэ. Иймээс хөтлөгчөөр ямар хүнийг сонгох вэ гэдэг нь бас чухал асуудал юм.
2. Хичээлд ажиглалт хийсэн хүмүүс хичээл эхлэхээс өмнө хичээлийн хөтөлбөртэй танилцаж тэрхүү хичээлээр багшийн зорьж байгаа зүйлийг ойлгож авна. Ингэсний үндсэн дээр хичээлийн явцад анзаарсан зүйл байвал хичээлийн киррикулим дээр дор бүр тэмдэглэж түүнийгээ хэлэлцүүлгийн явц болон өөрийн хичээл дээр ашиглана.
3. Хэлэлцүүлэгт оролцож буй хүмүүс хүүхдийн алдааг хичээлээ дутуу давтсан байна гэж дүгнээд орхих биш тэр алдааны цаана байгаа шалтгааныг олохыг хичээж түүнд анализ хийж энэ алдааг яаж засаж болох талаар бодож тунгаах хэрэгтэй.
4. Хичээл заасан багшийг зөвхөн шүүмжлэлээр булж болохгүй. Бүтээлч санааг нэмж хэлэх талаар анхаарах хэрэгтэй. Ер нь 3 удаа магтаад 2 удаа сануулах байдлаар санаагаа хэлсэн нь дээр байдаг.

Хэлэлцүүлгийг зохион байгуулахын өмнө хөтлөгч багш, тэмдэглэл хөтлөх багшаа тус тус сонгохын зэрэгцээ ярих дараалал, зохион байгуулалт, хэлэлцүүлэгт оролцогчдын үүрэг зэргийг тодруулах хэрэгтэй.

Хэлэлцүүлэгт оролцогчдын үүрэг

Хэлэлцүүлгийн хөтлөгч: Хэлэлцүүлгийн зорилго, зорилт болон хичээлийн зорилго, зорилтын талаар тодорхой ойлголттой байж, хэлэлцүүлгийг үр ашигтайгаар зохион байгуулах үүрэг гүйцэтгэх ба тухайн чиглэлээр асуудал дэвшүүлж, хэлэлцүүлгийг өрнүүлж болно.

Хичээл заасан багш: Зорилгоо тодотгон тайлбарлаж, хичээлийнхээ ололттой ба дутагдалтай талыг дүгнэнэ. Тулгарсан бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар ярина.

Ажиглагч: Ажиглалт хийсэн тэмдэглэлийнхээ дагуу асуулт тавьж, сайжруулах зүйлийг тодруулан, түүнийг хэрхэн сайжруулах талаар санал бодлоо дэвшүүлнэ.

Зөвлөх багш: Хичээлийн судалгаа хийж байгаа багш нарт алдсан оносон зүйл дээр онолын үндэстэй дидактикийн зөвлөгөө өгнө.

Тэмдэглэл хөтлөгч: Хичээлийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хөтөлнө. Тэмдэглэл бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй байх нь хэлэлцүүлгийн болоод хичээлийн судалгааны зорилтын биелэлт, тухайн хичээлийг сайжруулан дахин заах зэрэгт чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хичээлийн судалгааг тодорхой үечлэлтэйгээр зохион байгуулах явцад тухай бүрийн хэлэлцүүлгийг хэзээ, хаана, ямар хугацаанд зохион байгуулах вэ?, Ямар хэрэглэгдэхүүн шаардлагатай вэ? Гэх зэрэг асуудлыг хэлэлцүүлэг эхлэхээс өмнө бодож төлөвлөсөн байх нь зүйтэй. (Хүснэгт 2).

№	Зохион байгуулалт		Анхаарах зүйл
1	Хэзээ зохион байгуулах нь тохиромжтой вэ?	Судалгаатай хичээлийг заасны дараа зохион байгуулах нь оновчтой.	Иймд судалгаат хичээлийн дараагийн цаг дээр хэлэлцүүлэгт оролцох багш нар хичээлгүй байх зэргээр менежментийн төлөвлөлтийг урьдчилан хийх шаардлагатай болдог.
2	Хэлэлцүүлгийг хаана зохион байгуулах вэ?	Хэлэлцүүлгийг хичээл явагдсан ангид нь, өөрөөр хэлбэл тухайн орчинд нь зохион байгуулах хамгийн тохиромжтой.	Хэрэв анги танхимд зохион багуулахаар бол тухайн хэлэлцүүлэгт ашиглах шаардлагатай сурагчдын бүтээл зэргийг заавал байрлуулах хэрэгтэй.
3	Хэлэлцүүлэг хэр удаан үргэлжлэх нь зүйтэй вэ?	Хэлэлцүүлэг үргэлжлэх тогтоосон хугацаа байдаггүй. Энэ нь хичээлийн судалгааны зорилго, зорилт, тухайн цаг үеийн боломжоос хамаарна. Сургуульд суурилсан судалгаат хичээл зохион байгуулж үед ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаагаар төлөвлөж байсан. Дунджаар 40 – 60 минут.	Хэлэлцүүлгийн зорилго болон оролцогчдын тооноос хамааран хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа янз бүр байж болох тул судалгаат хичээлийг зохион байгуулахдаа хичээлийн дараа хэлэлцүүлгийн хугацаа хүрэлцээтэй байх орчныг бүрдүүлэхээр төлөвлөх нь зүйтэй.
4	Хэлэлцүүлэг зохион байгуулахад юу шаардлагатай вэ?	Хичээлийн төлөвлөлт, ашигласан хэрэглэгдэхүүн, сурагчдын бүтээл.	Тухайн хичээлийн арга зүйн шийдэл, ололт, дутагдлыг бодит жишээ, баримт дээр тулгуурлан ярилцах, зөвлөх нь өгөөжтэй байдаг тул ийм боломжийг бүрдүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй.
5	Хэлэлцүүлэгт хэн хэн оролцох вэ?	Хэлэлцүүлэгт хичээл заасан багш, ажиглагчид болон зөвлөх багш заавал оролцох ёстой.	Хичээлийн ажиглалт хийх, хэлэлцүүлэгт оролцох хүний тоо тухайн хичээлийн зорилго, зорилтоос хамааран харилцан адилгүй байж болох ч наймаас дээш байх нь зохимжтой.

Хэлэлцүүлэгт оролцож байхад анхаарах зүйл

Төслийн эхний шатны хичээлийн судалгааны арга зүйг турших явцад бидэнд анхаармаар олон зүйл байсан ба түүнийг ойлгож засах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулж байна. Тухайлбал, Хэлэлцүүлэг зохион байгуулах үед бидний хичээлд анализ хийдэг хуучин арга барил, ялангуяа багшийг сөрөг хандлагаар шүүмжлэх, давхардсан санааг давтан хэлэх гэх мэт бэрхшээл учирч байсныг анхаарууштай..

Хичээл ажиглагчдад энгийн хичээл (нээлттэй хичээл) ба судалгаат хичээл хоёрын

ялгаатай талыг ойлгуулах нь зүйтэй. Хичээлийн судалгаа нь “Багшийн ажлын байран дээрх” мэргэжил дээшлүүлэх нэг хэлбэр гэж Японд үздэг байна.

Хэлэлцүүлэг хийхдээ дугуй ширээний ярилцлага маягаар хэлэлцүүлэг хийх газраа засах нь зүйтэй. Энэ нь оролцогчид ижил тэгш байхыг илэрхийлэхээс гадна нүүр нүүрээ харан бусаддаа нөхөрсгөөр хандахад дэмжлэг болдог.

Хичээлийн дараах хэлэлцүүлгээр ажиглагч багш нар нь санал бодлоо хэлэх явцад хичээлийн үйл ажиллагааг урьдчилан бүгд ярилцаж хийсэн тул түүн дээрээ техникийн болон арга зүйн зарим жижиг өөрчлөлт хийх, тухайн нөхцөл байдалд хэрхэн хөтлөгдөж явсан тухай л ярьж, өмнөх төлөвлөлтдөө хэт баригдаж байгаа байдал харагддагийг анхаарах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ч.Лхагважав, Н.Нэргүй, Сургалтын арга зүйн хөгжил: Чиг хандлага, шийдлийн үндэслэл, Сургалтын арга зүй (Багш нарт зориулсан сургалтын материал). 5-33 тал.
2. Б.Бурмаа, Суралцагчдын суралцахуйн хөгжлийг дэмжих арга зүйн мөн чанар //Хүн байгаль модуль (Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх төсөл), 2010 он
3. Грейс Крейг, Психология развития, М., 2001 г
4. Н.Нэргүй, Н.Норжхорлоо, Л.Отгонсүрэн ба бусад, Зургаан настай суралцагч (багшийн гарын авлага), “Урлах эрдэм” ХК., 2009
5. Б.Бурмаа ба бусад, Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага (Стандарт хөгжлийн онол арга зүй), “Соёмбо принтинг” ХХК., УБ., 2003
6. Н.Норжхорлоо, Л.Отгонсүрэн, Н.Оюунцэцэг, Шийдвэрлэх нас, “Эдмон” ХК., 2011
7. Б.Бурмаа, Н.Оюунцэцэг ба бусад, ТХБ-ын үзэл баримтлалыг “Хүн орчин” хичээлийн хөтөлбөрт тусгах нь (ЕБС-ийн багш нарт зориулсан зөвлөмж), “migma Printing”ХХК. 2009 он
8. Ж.Батдэлгэр, Цэцэрлэгийн бэлтгэл, ЕБС-ийн “0” бүлгийн агуулга, арга зүйн зөвлөмж, УБ., 2004, 34-43 тал
9. Н.Оюунцэцэг, Цогзолмаа ба бусад, Хүн байгаль сургалтын модуль (Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх төсөл), 2010 он
10. Н.Нэргүй ба бусад, Хими-II (ЕБС-ийн 11 жилийн сургалттай сургуулийн 9-р ангийн сурах бичиг), “Адмон” ХХК., 2007 он
11. Ц.Лувсандорж нар. Математикийн хичээлийн соёлын хөгжил модуль. 2004 он.
12. Б.Бурмаа. 2010 онд СХД-т болсон сургалтын илтгэлийн материал.
13. 2010 онд СХД-т болсон сургалтын илтгэлийн материал. Япон зөвлөхүүдийн санал, зөвлөмж.
14. Masami Isoda, : “Japanese Lesson study in mathematics-Its Impact, Diversity and Potential for Educational Improvement”. 2007.
15. TAKAHASHI Akihiko, YOSHIDA Makoto, Developing tools and artifacts for supporting Lesson Study and instructional improvement, WALS2012 International Conference